



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

2020–2024 ОНД ЭХЭЛСЭН УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУДАЛГАА



Улаанбаатар хот
2026 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

2020–2024 ОНД ЭХЭЛСЭН УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУДАЛГАА

“Зэт Файнаншил энд Инвестмент Консалтинг” ХХК

2026 он

ННА 65
ДАА 327
Х-409

Энэхүү судалгааны дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум 2015

ISBN: 978-9919-529-06-2

ТОВЬЁГ	4
ӨМНӨХ ҮГ	8
ХУРААНГУЙ	9
УДИРТГАЛ	10
I. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11
1.1 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт	12
1.2 2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	14
1.2.1 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	15
1.2.2 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	17
1.2.3 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	19
1.2.4 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	22
1.2.5 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	25
II. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ	29
2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги	29
2.1.1 Стратеги 1 – Хөгжлийн үе шатны онол	30
2.1.2 Стратеги 2 – Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах нь	35
2.1.3 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, стратегийг тодорхойлж буй аргачлал	37
2.2 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл	37
2.2.1 Боловсролын салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт	40
2.2.2 Эрүүл мэндийн салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт	42
2.2.3 Дэд бүтцийн салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт	45
2.3 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх арга зүй	46
2.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөлд тавигдах шаардлага, төслийг үнэлэх, төлөвлөх аргачлал	46
2.3.2 Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлэх олон улсын аргачлалууд	55
2.4 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ	60
III. УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2020–2024 ОНД ЭХЭЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ	63
Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2020–2024 онд эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн шинжилгээ	64
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	82
ЭХ СУРВАЛЖ	86

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр	16
Хүснэгт 2.	2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл арга, хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)	18
Хүснэгт 3.	2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл арга, хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)	20
Хүснэгт 4.	Төсөл, арга хэмжээ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	21
Хүснэгт 5.	2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл арга, хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)	23
Хүснэгт 6.	2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл арга, хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)	25
Хүснэгт 7.	Ростоугийн хөгжлийн үе шатууд, тэдгээрийн онцлог	31
Хүснэгт 8.	Өмнөд Солонгос улсын хөгжлийн үе шатууд, үе шат бүрд хийгдсэн төсвийн хөрөнгө оруулалтууд, эзлэх хувиар	32
Хүснэгт 9.	Бразил улсын хөгжлийн үе шат, Ростоугийн онолоор	33
Хүснэгт 10.	Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулах стратегийн үндсэн алхмууд	36
Хүснэгт 11.	Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар салбар бүрд 2020–2024 онд эхэлсэн төслүүдэд төсөвлөсөн санхүүжилтийн нийт дүн, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр	38
Хүснэгт 12.	Монгол Улсын амьдралын чанарын индекс, 2025 он	39
Хүснэгт 13.	Боловсролын салбарт улсын төсвийн санхүүжилтээр 2020–2024 онд ашиглалтад оруулсан сургууль, цэцэрлэгийн тоо, хүчин чадал	40
Хүснэгт 14.	Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд ашиглалтад оруулсан эмнэлгийн тоо, хүчин чадал	43
Хүснэгт 15.	Дэд бүтэц, зам гүүр, эрчим хүчний салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд ашиглалтад оруулсан байгууламжийн тоо, хүчин чадал	45
Хүснэгт 16.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах тусгай шаардлагууд	47
Хүснэгт 17.	УТХО–аар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх 1 дүгээр үе шат	51
Хүснэгт 18.	УТХО–аар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх 2 дугаар үе шат	52
Хүснэгт 19.	Олон улсын байгууллагуудаас гаргасан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлдэг индексүүд	55
Хүснэгт 20.	Улс орнуудын төсвийн хөрөнгө оруулалтыг үнэлэх аргачлалууд	56
Хүснэгт 21.	2023 онд шинээр хэрэгжүүлсэн өндөр төсөвт өртөгтэй 10 төслийн мэдээлэл, сая төгрөгөөр	65
Хүснэгт 22.	2020–2024 онд хэрэгжиж эхэлсэн хамгийн өндөр төсөвт өртөгтэй 12 төслийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр	66
Хүснэгт 23.	2020–2024 онд эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд, зориулалтаар, төслүүдийн тоо, нийт төсөвт өртөг, эзлэх хувиар	67

Хүснэгт 24.	2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эхэлсэн төслийн тоо, байршлаар, тэрбум төгрөгөөр	69
Хүснэгт 25.	2020–2024 онд шинээр эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн тендерт хамгийн олон удаа шалгарсан топ 10 компани.....	71
Хүснэгт 26.	Төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр эхэлсэн төслийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр.....	73
Хүснэгт 27.	2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг нь хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр	74
Хүснэгт 28.	Төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр эхэлсэн төслийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр.....	75
Хүснэгт 29.	2021 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг нь хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр	76
Хүснэгт 30.	Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр.....	77
Хүснэгт 31.	2022 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг нь хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр	78
Хүснэгт 32.	Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр.....	79
Хүснэгт 33.	Төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр.....	80

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	ДНБ ба улсын төсвийн хөрөнгө оруулалтын харьцаа /2020–2024 он/	13
Зураг 2.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын улсын нэгдсэн төсвийн зарцуулалтад эзлэх хувь /2020–2024 он/	13
Зураг 3.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /2020–2024 он/	14
Зураг 4.	Grand cherokee, Toyota Land Cruiser 300GXR, Land Cruiser 250 маркийн автомашин	27
Зураг 5.	Боловсролын түвшний индекс болон ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж /2015–2024 он/	42
Зураг 6.	Монгол Улсын эмнэлгийн орны эргэлтийн тоо /2015–2024 он/	43
Зураг 7.	Монгол Улсын хүн амын дундаж наслалт, хүйсээр	44
Зураг 8.	Монгол Улсын тээврийн гүйцэтгэлийн индекс, 2023 он	46
Зураг 9.	“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд” журамд тусгагдсан аргачлалууд	48

Зураг 10.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал.....	49
Зураг 11.	Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал.....	50
Зураг 12.	УТХО–тай хөтөлбөрүүдийн санхүүжилт олгох зохицуулалт.....	54
Зураг 13.	CAPEX%, 2024.....	60
Зураг 14.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөлөл болон нэг хүнд ногдох ДНБ–ий харьцуулалт.....	61
Зураг 15.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон хөрөнгө оруулалтын зардлын харьцуулалт.....	62
Зураг 16.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон нэг хүнд ногдох ДНБ–ий харьцуулалт.....	62
Зураг 17.	2020–2024 онд шинээр хэрэгжүүлж эхэлсэн нийт төслийн тоо, анхны төсөвт өртөг, тэрбум төгрөгөөр.....	64
Зураг 18.	2020–2024 онд шинээр хэрэгжиж эхэлсэн төслүүдийн тоо, төсөвт өртгийн ангилал, тэрбум төгрөгөөр.....	66
Зураг 19.	2020–2024 онд шинээр эхэлсэн төслийн анхлан төсөвлөсөн төсөвт өртөг, ТЕЗ–аар, тэрбум төгрөгөөр.....	68
Зураг 20.	2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, төслийн тоогоор, төсөвт өртөг, тэрбум төгрөгөөр.....	70
Зураг 21.	2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, нийт төслийн тоонд эзлэх хувиар.....	72
Зураг 22.	2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, нийт төсөвт өртөгт эзлэх хувиар.....	72

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1.	2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөгт өөрчлөлт орсон, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн жагсаалт.....	87
Хавсралт 2.	2021 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөгт өөрчлөлт орсон, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн жагсаалт.....	98
Хавсралт 3.	Газрын асуудал шийдэгдээгүй байхад улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний судалгаа (сая төгрөгөөр).....	112
Хавсралт 4.	2022 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөгт өөрчлөлт орсон, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн жагсаалт.....	113
Хавсралт 5.	2023 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөгт өөрчлөлт орсон, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн жагсаалт.....	134

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НУБХОАЗБТБХД	Нийслэлийн урсгал ба хөрөнгө оруулалтын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, бүртгэл, хяналт, дүгнэлт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ОУВС	Олон улсын валютын сан
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
BIP	Banco Integrado de Proyectos
CAPEX	Capital expenditure
CBA	Cost benefit analysis
CPR	Capital productivity ratio
DIPRES	Direcciyn de Presupuestos
ICOR	Incremental Capital–Output Ratio
IMF	International Monetary Fund
IRR	Internal rate of return
KPI	Key Performance Indicators
KDI	Korea Development Institute
LPI	Logistics performance index
MCDA	Multi–Criteria decision analysis
NPV	Net present value
OECD	Organisation for economic co–operation and development
PFS	Preliminary feasibility study
PIPI	Public Investment Performance Index
PIMS	Public investment management system
PIMAC	Public and private infrastructure investment management center
PPS	Public procurement service
SDG	Sustainable development goals
SNIP	Sistema nacional de inversiones publicas

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь Засгийн газрын зүгээс дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зэрэг замаар эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын чухал хэрэгсэл юм.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын зардал 2020 онд 1.3 их наяд төгрөг байсан бол 2024 онд 3.8 их наяд төгрөг болжээ. Хөрөнгө оруулалтын төслүүд холбогдох хуульд заасан төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй байх, хэрэгжилт удаашрах, улмаар төсөвт өртөг нэмэгдэх зэрэг асуудал гарч байгааг төрийн аудитын дүгнэлт болон иргэний нийгмийн зүгээс хийсэн ажиглалт, судалгаанаас харж болно. Ийнхүү төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт оновчтой бус, үүнээс улбаалан хэрэгжилтийн явцад төслүүдийн өртөг зардал өсөн нэмэгдэж байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулахад хүргэж ирлээ.

Засгийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтад 2020–2024 онд нийт 10.4 их наяд төгрөг зарцуулсан байна. Иймээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт сүүлийн жилүүдэд ямар түвшинд байгааг судлах зорилгоор Нээлттэй нийгэм форумын захиалгаар “Зэт Файнаншил энд Инвестмент Консалтинг” ХХК-ийн А.Мөнхцог ахлагчтай судалгааны баг Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2020–2024 онд эхэлсэн хөрөнгө оруулалтын судалгааг хийж, манай улс төсвийн хөрөнгө оруулалт хийхэд ашиглаж буй аргачлалыг олон улсын аргачлалтай харьцуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төлөвлөлт болон хэрэгжилтийн уялдааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулсныг сонирхогч талуудад хүргэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг зөвхөн тоон гүйцэтгэлээр бус, эдийн засаг, нийгмийн бодит нөлөөллөөр хэмжих шаардлага улам бүр нэмэгдэж байгаа болон хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд төсөл сонголт, төлөвлөлтийн ил тод байдал, гүйцэтгэлийн хяналт, бодлогын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн хяналт–шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай зэрэг олон асуудлыг судалгааны багийн зүгээс онцолжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, төлөвлөлт болон хэрэгжилтийг сайжруулах талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэхүү судалгаа зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Судалгааг хийж гүйцэтгэсэн судалгааны баг, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч Д.Баярмаа, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

Энэхүү судалгаа нь 2020–2024 оны Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт, үр ашиг, тулгамдсан асуудал болон цаашдын чиг хандлагыг хамарсан иж бүрэн шинжилгээ юм. Судалгааны хүрээнд нээлттэй эх сурвалж, төрийн байгууллагуудын тайлан мэдээ, аудитын дүгнэлт болон олон улсын аргачлалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн болно.

2020–2024 онд улсын төсвийн нийт зардал болон хөрөнгө оруулалтын хэмжээ тогтвортой өссөн бөгөөд энэ нь эдийн засгийг дэмжих, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь салбаруудын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, улсын төсвийн нийт зардал 2020 онд 13.9 их наяд төгрөг байсан бол 2024 онд 30.4 их наяд төгрөгт, хөрөнгө оруулалтын дүн 1.4 их наядаас 3.1 их наяд төгрөгт хүрч тус тус өссөн нь төрийн бодлогоор дамжуулан хөгжлийн хөшүүргийг идэвхжүүлж байгааг харуулж байна.

Гэвч хэрэгжилтийн явцад төлөвлөлтийн чанар, төсөл сонголт, гүйцэтгэлийн хяналт, бодлогын уялдаа зэрэг чиглэлээр цөөнгүй сорилт хэвээр байгааг судалгааны дүн харуулж байна. Үндэсний аудитын газраас жил бүрийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангуудад техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон зураг төслийн бүрдэл дутуу, хэрэгжилтийн хугацаа удаашралтай, бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй зэрэг нийтлэг зөрчил, доголдлыг тэмдэглэсэн байна. Судалгааны тайланд жил бүрийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд гарсан зөрчлийн тухай дэлгэрэнгүй дурдсан ба холбогдох хэсгээс танилцана уу.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг зөвхөн тоон гүйцэтгэлээр бус, эдийн засаг, нийгмийн бодит нөлөөллөөр хэмжих шаардлага улам бүр нэмэгдэж байна. 2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 6,300 гаруй төсөл, арга хэмжээ хэрэгжиж, гүйцэтгэл дунджаар 89 хувьтай байсан ч энэ нь хөрөнгө оруулалтын чанар, өгөөжийг илтгэх үзүүлэлт бус, төсвийн зарцуулалтын түвшнийг харуулсан хязгаарлагдмал үнэлгээ юм. Хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд төсөл сонголт, төлөвлөлтийн ил тод байдал, нэгдсэн хяналт–шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна. Одоогийн нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хэрхэн сонгож буй арга зүйг судалгаанд хураангуйлан оруулсан ба олон улсад төслүүдийг хэрхэн сонгодог тухай арга аргачлал, онолын арга зүйг авч үзэж, холбогдох дүгнэлтийг хийсэн болно.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)–ий 4–6 хувийг эзэлж, эдийн засгийн өсөлтийн суурь түвшинд хүрч байгаа ч үр ашгийн түвшин хангалтгүй байна. CAPEX (Capital Expenditure Ratio) харьцангуй өндөр боловч CPR (Capital Productivity Ratio) дундаж байгаа нь хөрөнгө оруулалтын бүтээмж бүрэн ашиглагдахгүй байгааг илтгэнэ. Иймээс төсөл сонголт, төлөвлөлт, менежмент болон хяналт–шинжилгээний тогтолцоог сайжруулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бодит эдийн засгийн өсөлттэй уялдуулах шаардлагатай байна.

Монгол Улсын төсвийн зардал сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2020 онд улсын төсвийн нийт зардал 13.9 их наяд төгрөг байсан бол 2024 онд 30.4 их наяд төгрөгт хүрч, жилд дунджаар 21.6 хувиар өсжээ. Үүний дотор төсвийн хөрөнгө оруулалтын дүн жилд дунджаар 22 орчим хувиар өсөж, 1.4 их наяд төгрөгөөс 3.1 их наяд төгрөгт хүрсэн нь улсын хөгжлийн стратегийн хэрэгжилт, дэд бүтцийн бүтээн байгуулалтад төрийн оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

Төсвийн хөрөнгө оруулалт нь зам, гүүр тавих, сургууль, цэцэрлэг барих, өөрөөр хэлбэл эрчим хүч, боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь салбаруудыг дэмжих замаар эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын чухал хэрэгсэл юм. Гэвч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэл, хэрэгжилтийн чанар олон жилийн турш асуудал дагуулсаар ирсэн. Эдгээр хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт 80–96 хувь байгаа хэдий ч тэдгээрийн эдийн засаг, нийгэмд бодитоор үзүүлж буй нөлөөллийн тухай дүгнэлт, мэдээлэл байхгүй байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт эргэлзэхэд хүргэж байна.

Мөн эдгээр төсөл хугацаандаа дуусаагүй эсвэл гүйцэтгэл нь чанаргүй болсон зэргээс дахин төсөвлөлт шаарддаг нь эдийн засаг, нийгэмд бий болох бодит өгөөжийг бууруулах, жил бүрийн төсөвт санхүүгийн ачаалал нэмэх, иргэдийн дунд төрөөс хийж буй хөрөнгө оруулалтад итгэх итгэл буурах зэрэг эрсдэлийг дагуулж байна. Хэдийгээр Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, холбогдох журам, стандартууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх үйл явц хангалтгүй хэвээр байгааг олон улсын байгууллагын зөвлөмж, аудитын дүгнэлтүүд, дотоодын судалгаануудад анхааруулсаар байна.

Иймд уг судалгаагаар Бүлэг 1–т “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжилтийн түвшин болон хэрэгжилтэд тулгамдаж буй гол асуудлуудыг товч дүгнэж, Бүлэг 2–т Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх голлох салбаруудыг сонгох стратегийг судалж, төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж буй голлох чиглэлүүд, тэдгээрийн нөхцөл байдлыг дүгнэн, төсвийн хөрөнгө оруулалт хийхэд ашиглаж буй төслийн арга аргачлалыг олон улсын арга аргачлалтай харьцуулж, Бүлэг 3–т 2020–2024 онуудад эхэлсэн Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийн нээлттэй мэдээлэлд үндэслэн хэрэгжилтийг 4 түвшинд ангилж, хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох замаар Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж, боловсруулахад тулгарч буй асуудлыг өргөн цар хүрээнд тодорхойлж, цаашид анхаарах зүйлс болон засаж сайжруулах боломжийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэхүү судалгааны ажлыг нээлттэй мэдээлэлд үндэслэн А.Мөнхцог ахлагчтай, судлаач Д.Болортуяа, Ц.Булгансайхан, Э.Мөнхболд, Э.Төгөлдөр нарын бүрэлдэхүүнтэй баг хамтран гүйцэтгэв.

I. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлгийн хүрээнд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ач холбогдол, эдийн засагт эзлэх байр суурь болон 2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтуудын ерөнхий хэрэгжилтийг нээлттэй мэдээлэлд тулгуурлан тодорхойлов. 2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах бодлогын гол хэрэгсэл хэвээр байсан бөгөөд нийт төсвийн зардлын 16–18 хувь, ДНБ-ий 4–6 хувийг эзэлж байв. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын төслүүдийн бодит хэрэгжилтийн үр дүн зорилтот түвшиндээ хүрээгүй бөгөөд хэрэгжилтийн шат дахь зохион байгуулалтын болон үр ашиг, үр нөлөөний хязгаарлалт, хяналтын сул байдал нь бодит үр ашгийг бууруулж байгааг Үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тодорхой тусгасан байна. Тайланд дурдсаны дагуу хэрэгжилтийг үнэлэхэд дараах үндсэн асуудлууд тулгарч байна.

Нэгдүгээрт, хөрөнгө оруулалтыг төсөвлөх, төсөл, арга хэмжээг сонгох, эрэмбэлэх, батлах процесс нь хууль, бодлогын баримт бичгүүдтэй нийцэхгүй хэвээр байна. Жил бүр бэлтгэл хангагдаагүй, ТЭЗҮ болон зураг, төсөвгүй олон төслийг төсөвт тусгаж, хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, Үндэсний аудитын газрын 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн гүйцэтгэлийн тайланд дурдсанаар тухайн онд зураг төсөвгүй 400 гаруй төсөл батлагдсан байсан бол мөн 2024 оны ижил тайланг үзэхэд шинээр батлагдсан 712 төслийн дийлэнхийнх нь хэрэгжилтийн бэлтгэл хангагдаагүй байна.

Хоёрдугаарт, төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт жил бүр хангалтгүй байж, зарим жил гүйцэтгэл 80 хувь хүртэл түвшинд хүрч буурсан байна. Энэ нь төсөвлөлт ба гүйцэтгэлийн хооронд зөрчил үүсгэж, эдийн засаг дахь эрэлт, хөрөнгө оруулалтын өгөөж, иргэдийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж, төсвийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлж байгааг Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан байна.

Гуравдугаарт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд эрэмбэлэлгүй, олон жил дамнан үргэлжлэх жижиг төсөл хэт их тусаж буй нь төсвийн үр ашгийг сулруулж байна. Бүх аймаг, суманд жигд хуваарилалт хийх хандлага давамгайлснаар давхардсан, үр ашиг багатай, зарим тохиолдолд ашиглалтад ордоггүй бүтээн байгуулалтыг бий болгож, төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

Дөрөвдүгээрт, захиалагч байгууллагуудын чадавх, хяналт, хариуцлагын түвшин харилцан адилгүй байгаагаас хэрэгжилтийн чанар газар нутгийн хувьд ихээхэн ялгаатай байна. Энэ нь гүйцэтгэлд нөлөөлөх гол хүчин зүйл зөвхөн санхүүжилтийн хүрэлцээ бус, хэрэгжүүлэгч институцийн чадвар, удирдлагын тогтолцоотой салшгүй холбоотойг харуулж байна. Мөн жил бүрийн аудитын тайланд тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн талаар дэлгэрэнгүй дүгнэлт өгдөг ч, ижил төрлийн дутагдал тогтмол давтагдаж буй нь тухайн

дүгнэлтэд төсвийн ерөнхийлөн захирагч нар ач холбогдол өгч, арга хэмжээ авахгүй байгааг харуулж байна.

Иймээс цаашид төсвийн хөрөнгө оруулалтыг зөвхөн тоон өсөлтөөр бус, үр нөлөө, чанар, нийгэм, эдийн засгийн өгөөжөөр хэмжих үзэл баримтлалд шилжих шаардлагатай. Үүнд, нэгдсэн төлөвлөлт, төслийн цахим үнэлгээний систем, хяналт, шинжилгээний тогтолцоог сайжруулан, улс төрөөс ангид, хөгжлийн тэргүүлэх чиглэлд суурилсан бодлогын хандлага нэн шаардлагатай байна.

1.1 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалт бол эдийн засгийн дунд болон урт хугацааны өсөлтийг дэмжих, хөгжлийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын үндсэн хэрэгсэл юм. Монгол Улсын хувьд энэ нь зөвхөн төсвийн зарлагын нэг бүрэлдэхүүн хэсэг бус, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг чиглүүлэх стратегийн механизм, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах бодит хөшүүрэг гэж үзэж болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын гол зорилго нь эдийн засгийн өсөлтөд суурь дэд бүтцээр дамжуулан хөшүүрэг үзүүлэх, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Үүнд, зам, эрчим хүч, боловсрол, эрүүл мэндийн барилга байгууламж, мэдээллийн технологи, төрийн албаны дижитал шилжилт зэрэг салбарууд хамрагддаг. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ эдийн засгийн мөчлөг, түүхий эдийн орлогын хэлбэлзлээс хамаарч өөрчлөгдөж ирсэн байна. Төсвийн хөрөнгө оруулалт 2020 оны “Ковид-19” цар тахлын үеийн эдийн засгийн уналтаас хойш сэргэсэн бөгөөд 2021 оноос хойш эдийн засгийн идэвхжилтэй уялдан нэмэгдэж байна.


Гэсэн хэдий ч бодлогын түвшинд хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашиг, ач холбогдол бага, давхардсан төсөвлөлт, гүйцэтгэлийн хугацаа хэт сунжрах зэрэг олон асуудал тулгарсаар байна. Үндэсний аудитын газраас хийсэн аудитын тайланд төсвийн хөрөнгө оруулалтын 30-аас дээш хувь нь тухайн ондоо бүрэн хэрэгждэггүй, олон жил дамнасан, төслийн үр өгөөжийн тооцоо дутмаг байдлаас шалтгаалж үр ашиг нь тодорхой бус хэвээр байгаа талаар дурдсан байна (Үндэсний аудитын газар, 2024).

ДНБ ба төсвийн хөрөнгө оруулалт: Олон улсын судалгаагаар ДНБ-ий 1 хувийн хэмжээтэй дэд бүтцийн хөрөнгө оруулалт нь ДНБ-ий бодит өсөлтийг ойролцоогоор 1 нэгж пунктээр нэмэгдүүлэх хандлагатай байдаг (Монгол Улсын Засгийн газар, 2025). Энэ нь дэд бүтцийн хөрөнгө оруулалт дан ганц зардал биш, харин урт хугацааны өсөлт, бүтээмж, зах зээлийн үр ашгийг сайжруулах эдийн засгийн хөшүүрэг болохыг илтгэнэ. Тээвэр, эрчим хүч, мэдээллийн технологи, усан хангамж зэрэг суурь дэд бүтэц сайжирснаар үйлдвэрлэлийн өртөг буурч, хувийн хэвшлийн хувьд хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэх, ажлын байр нэмэгдэх, улмаар өрсөлдөх чадвар сайжрах зэрэг эерэг нөлөөг бий болгодог байна. Үүний зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, нийгмийн амьдралын чанар мөн дээшилдэг.

Гэвч Монгол Улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын бодит хэмжээ олон улсын дунджаас доогуур түвшинд байна. Хөгжиж буй улс орнууд дунджаар ДНБ-ий 6.6 хувийг дэд бүтцэд зарцуулж байхад Монгол Улс сүүлийн жилүүдэд дунджаар ДНБ-ий 4.1 хувийг төсвийн хөрөнгө оруулалтад

зарцуулж байгаа нь дэд бүтцийн санхүүжилтийн дутмаг байдал, түүний эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна (Монгол Улсын Засгийн газар, 2025).


Зураг 1. ДНБ ба улсын төсвийн хөрөнгө оруулалтын харьцаа (2020–2024 он)



Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төсөвт эзлэх хувь: Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийхээр батлагдсан санхүүжилт 2020 онд 1.65 их наяд төгрөг байсан бол 2024 онд 3.85 их наяд төгрөг болж, нэрлэсэн утгаар 2.3 дахин өссөн байна. Гэвч энэхүү өсөлт төсвийн нийт зардлын өсөлттэй харьцангуй ижил хурдтай байгаа тул хөрөнгө оруулалтын төсөвт эзлэх жин 15–18 хувийн хооронд тогтвортой хэвээр байна. Энэ нь төсвийн бүтцийн шинэтгэл хангалтгүй, капитал зардлын үр ашигт чиглэсэн хуваарилалт бодлогын хэмжээнд тодорхой бус байгааг харуулж байна.

Зураг 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төсвийн зарцуулалтад эзлэх хувь (2020–2024 он)



Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

Төсвийн зарлагын бүтэц урсгал шинж чанартай хэвээр байгаа нь дунд хугацаанд өсөлт, бүтээмжийг дэмжих төсөвлөлтийн зорилго алдагдахад хүргэх эрсдэл дагуулж байна. Тухайлбал, 2024 онд улсын төсвийн нийт зарлагын 81.7 хувийг урсгал болон бусад зардал бүрдүүлж байгаа нь капитал зардалд чиглэсэн төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Төсвийн хөрөнгө оруулалт нь зардлын нэг төрөл бус, ирээдүйн эдийн засгийн чадавхыг бүрдүүлэгч стратегийн механизм учраас түүний өсөлтийг зөвхөн тоон хэмжээгээр бус, бодлогын зорилт, бүтцийн шинэчлэл, институцийн зохицуулалт, төсөл хэрэгжилтийн өгөөжтэй хослуулсан цогц хандлагаар үнэлж, удирдах шаардлагатай байна.


1.2 2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт давхардсан тоогоор 6301 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 11.85 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 10.48 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл дунджаар 89.3 хувьтай байна. 2023 оны хувьд эхлүүлсэн төслүүдийг дуусгах зорилт тавьж, шинэ төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгаагүй бөгөөд гүйцэтгэл хамгийн өндөр буюу 96.4 хувьд хүрсэн бол 2024 онд гүйцэтгэл 80.3 хувьтай¹ байна.

Энэ хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь шинэ төслийн тоог хязгаарлах, өмнөх онуудын төсөл, арга хэмжээг дуусгах, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлд төвлөрч ирсэн ч төлөвлөлтийн чанар, хууль, дүрэм журмын хэрэгжилт сул, ТЭЗҮ болон зураг төслийн бүрдэл дутуу, хэрэгжилтийн уялдаа муу байсаар байна.

Тухайлбал, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд зардал-үр ашгийн шинжилгээ хийгээгүй, баталгаажаагүй төсөл, арга хэмжээнүүдийг төсөвт тусгах, газрын маргаантай барилга, байгууламж батлах зэрэг зөрчил байнга давтагдсан нь системийн түвшний асуудал болохыг харуулж байна.

Зураг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (2020–2024 он)



Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг жагсаан харвал дараах үр дүн гарч байна. Үүнд:

¹ Концессын гэрээний дагуу хэрэгжсэн төслүүд орсон буюу нийт хэрэгжсэн төслүүдийн гүйцэтгэлийн хувь

2020 он: Зураг төсөвгүй 42 төсөл батлагдсан, нийт 8.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 16 төсөл тодотголын үеэр хасагдсан, гурван цэцэрлэгийн төсөв 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийслэлийн Засаг даргад эрх шилжсэн 2020 онд шинээр хэрэгжих 138.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 209 төсөл, арга хэмжээнээс 113.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 114 төсөл, арга хэмжээг түүвэрлэн төсөвлөлтийн шаардлага хангуулсан эсэхийг шалгахад зураг төсөв шаардлагатай 62 төсөл, арга хэмжээ гарсан байна.

2021 он: 1101 төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.47–т заасны дагуу ТЭЗҮ хийсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагатай нийт 141 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр батлуулсан байна.

2022 он: Тухайн онд шинээр хэрэгжүүлэх 664 төсөл арга хэмжээнээс барилга, байгууламж, их засвар ангилалд 502 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 81 хувь буюу 406 төсөл, арга хэмжээ нь магадлалаар баталгаажсан зураг, төсөлгүй батлагдсан байна.

2023 он: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын 5 төсөл, арга хэмжээнээс 3 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1139 төсөл арга хэмжээнээс 883 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсний 62.5 хувь буюу 552 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн, 37.5 хувь буюу 331 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

2024 он: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд газрын зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээг тусгахыг хориглосон байхад 79.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталснаас зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад тодорхой хугацаа зарцуулснаас шалтгаалж 272.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 45 барилга байгууламжийн ажлын тендерийг 2024 оны 10, 11, 12 дугаар сард зарласнаар гэрээ байгуулах ажиллагаа хойшлогдож, тухайн онд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулах боломжгүй болжээ.

Хэдийгээр хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр өсөж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өндөр хэвээр байгаа ч төрийн хөрөнгө оруулалтын үр ашиг, бодлогын уялдаа, төлөвлөлтийн сахилга хариуцлага, хяналт шалгалтын үр нөлөө нь хангалтгүй түвшинд байсаар байна. Цаашид тогтолцооны чанартай шинэчлэл хийхгүй бол төсвийн хөрөнгө оруулалт нь хүчин чармайлт ихтэй боловч үр дүн багатай зардал хэвээр үлдэх эрсдэлтэй байна. Дараагийн хэсэгт 2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг гүйцэтгэлийн тайлан болон аудитын тайланд үндэслэн хураангуйлан дүгнэсэн болно.

1.2.1 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1356 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1.6 их наяд төгрөг батлагдсан бөгөөд үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1347 төсөл, арга хэмжээний 1.3 их наяд төгрөг, “Барих шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээгээр хэрэгжих 9 төсөл, арга хэмжээний 323.5 тэрбум төгрөгийг тус тус баталжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1347 төсөл, арга хэмжээнээс 844 (62.6 хувь) төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжиж, 503 (37.4 хувь) төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 1,093.7 тэрбум төгрөг буюу 82.2 хувийн биелэлттэй байна (Монгол Улсын Засгийн газар, 2021).

Хүснэгт 1. 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Ангилал	Төслийн тоо	Төслийн өртөг	Санхүүжих дүн	2020/12/31–ний байдлаар		
				Гүйцэтгэл	Хувиар	Үлдэгдэл дүн
Нийт	1356	5,175.3	1,654.3	1,414.6	85.5%	239.7
Улсын төсөв	1347	4,118.2	1,330.8	1,093.7	82.1%	237.2
Концесс	9	1057.1	323.5	320.9	99.2%	2.5

Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2021)

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний батлагдсан нийт санхүүжилтийн 19.5 хувь нь боловсрол, шинжлэх ухааны салбарт, 12.7 хувь нь зам, тээврийн салбарт, 10.8 хувь нь барилга, хот байгуулалтын салбарт, 7.2 хувь нь эрүүл мэндийн салбарт, үлдсэн нь бусад салбарт хэрэгжсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 296 барилга байгууламж ашиглалтад орсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд хийсэн аудитын тайлангаас гарсан голлох дүгнэлтүүдийг энэ хэсэгт тусгав. Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусгахаар заажээ. Нийслэлийн Засаг даргад эрх шилжсэн 2020 онд шинээр хэрэгжих 138.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 209 төсөл, арга хэмжээнээс 113.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 114 төсөл, арга хэмжээг түүвэрлэн төсөвлөлтийн шаардлага хангуулсан эсэхийг шалгахад зураг төсөв шаардлагатай 62 төсөл, арга хэмжээ гарсан байна. Үүнээс 42 төсөл, арга хэмжээ нь баталгаажсан зураг, төсөвгүй байсан ба энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.44 дэх заалтыг зөрчсөн байна. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлснээр байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй зарим асуудал үүссэн байна (Нийслэл дэх төрийн аудитын газар, 2021). Үүнд:

- » Агро паркийн эко сургалтын төвийн барилга, 300 суудал /Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Төсөвт өртөг: 2.5 тэрбум төгрөг/ – Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/723 дугаар захирамжтай, 18634307692000 нэгж талбарын дугаартай. Баянгол дүүргийн 20–р хорооны нутаг дэвсгэрт ТЭЦ–4 станцын гудамжинд цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн зориулалттай газрын зориулалтыг өөрчлөн, архитектур төлөвлөлтийг зөөвөрлөх боломжтой түр барилга хэлбэрээр төлөвлөсөн. Тус барилга нь БОНХАЖ–ын болон БХБ–ын сайдын 2015 оны А–230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”–ын 3.95 дахь заалтыг зөрчин баригдсан тул холбогдох газраас ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг олгоогүй байна. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд баригдсан барилга байгууламж нь хүрээлэн буй орчны тэнцвэрт харьцаа, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй тул холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулах нөхцөл үүссэн байна.

Төсвийн тухай хуульд ерөнхий тоогоор батлуулсан нь зураг, төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.² Тухайлбал зарим барилга,

2 <https://open.audit.mn/reportSingle/9355>, 10–р хуудас.

байгууламжийн нэмэлт ажлын зураг, төсвийг хууль батлагдахаас өмнө магадлал хийлгэж баталгаажуулаагүйгээс төсөвт өртөг нь 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Тухайлбал:

- » Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар хот Хан–Уул дүүрэг, 28 дугаар цэцэрлэг/ төслийн 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг 728.1 сая төгрөгөөр;
- » Цэцэрлэгийн барилга, 250 ор /Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 31 дүгээр хороо/ төслийн 2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг 500 сая төгрөгөөр;
- » Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/ төслийн 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг 250 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна (Нийслэл дэх төрийн аудитын газар, 2021).

2020 онд нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь Төсвийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангаагүйгээр хэрэгжсэн нь эрх зүйн зөрчил, төсөвт өртгийн нэмэгдэл болон байгаль орчны эрсдэлийг үүсгэсэн байна. Тухайлбал Үндэсний аудитын газрын тайланд дурдсан тоо, баримтыг авч үзэхэд, зураг төсөвгүй 42 төсөл батлагдсан, нийт 8.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 16 төсөл тодотголын үеэр хасагдсан, гурван цэцэрлэгийн төсөв 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн зэрэг нь төлөвлөлтийн чанар сул, зардлын тооцоо үндэслэлгүй байсныг харуулж байна. Ийнхүү хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг боловсруулах шатанд Төсвийн тухай хуульд туссан шаардлага болох зураг төсөв, техникийн болон эдийн засгийн тооцоог хангалтгүй боловсруулсан нь төсөвт дарамт үүсгэж, төслийн хэрэгжилт, үр өгөөжид сөргөөр нөлөөлсөн гэж аудитын дүгнэлтэд тэмдэглэжээ.

1.2.2 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1106 төсөл, арга хэмжээний 1.6 их наяд төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1101 төсөл, арга хэмжээний 1.4 их наяд төгрөг, “Барих шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 5 төсөл, арга хэмжээний 266.2 тэрбум төгрөг тус тус батлагдсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 1101 төсөл, арга хэмжээнээс 458 төсөл арга хэмжээ (41.6 хувь) шинээр, 643 төсөл арга хэмжээ (58.4 хувь) нь он дамжин шилжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл 1.3 их наяд төгрөг буюу 92.4 хувийн биелэлттэй байна.

Үүнийг өмнөх 2020 онтой харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 1.9 дахин, санхүүжих дүн 80.7 тэрбум төгрөгөөр буурч, үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжих дүн 168.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь он дамжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг дуусгах бодлого баримталсан гэж үзэхээр байна. Мөн барилга байгууламжийн 787 төсөл, их засварт 169, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 118, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах 27 төсөл, арга хэмжээ тусгагдан батлагдсан байна.

Хүснэгт 2. 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл арга хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	Шинэ	257	658.5	226.9
	Үргэлжлэх	531	2620.9	857.1
Их засвар	Шинэ	88	59.3	52.3
	Үргэлжлэх	81	57.6	35.3
Тоног төхөөрөмж	Шинэ	90	222.4	186.3
	Үргэлжлэх	27	210.4	15.6
ТЭЗҮ	Шинэ	23	13.7	12.8
	Үргэлжлэх	4	38.7	32.6
Нийт дүн	Шинэ	458	953.9	478.3
	Үргэлжлэх	643	2927.6	940.6

Эх сурвалж: (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2025)

Төсөв захирагчид Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагын хэрэгжилтийг хангахгүй байгаа нь төрийн аудитаар илэрчээ. Тухайлбал, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар 24 төслийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад баталсан 1101 төсөл, арга хэмжээнээс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.47–т заасны дагуу ТЭЗҮ хийсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагатай нийт 141 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр хуульд батлуулсан байна (Үндэсний аудитын газар, 2022). Тухайлбал, хамгийн өндөр дүнтэй 5 төслийг дурдвал:

- » 2021 онд эхлэх Төв аймгийн Зуунмод суманд баригдах Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лабораторийн ажил;
- » 2021 онд эхлэх Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Боловсролын үнэлгээ, мэдээллийн нэгдсэн төвийн барилга;
- » 2021 онд эхлэх Дорноговь аймгийн Сайншанд сумын 7–р багт баригдах “Саран хөхөө” театрын барилга, 700 суудал;
- » 2021 онд эхлэх Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдах Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилга, 200 ор;
- » 2021 онд эхлэх Дорноговь аймгийн Сайншанд сумын 3–р багт баригдах Соёл, урлагийн ордон, 500 суудал бүхий төслүүд байна (Дэлгэрэнгүйг хавсралтад оруулав).

Үүнээс, өмнөх оноос үргэлжлэн болон шинээр хэрэгжсэн нийт 24.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тооцооллыг 2021 оны жилийн эцсийн байдлаар баталгаажуулаагүй байгаагаас 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр гүйцэтгэж, ашиглалтад хүлээн авсан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан 2021 онд шинээр эхлэх барилга байгууламжийн 257 төсөл арга хэмжээнээс 37.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 барилгыг барих газрын зөвшөөрөл аваагүй, хаана барих нь тодорхойгүй байдлаар төлөвлөжээ. Мөн 2020–2021 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 1.5 тэрбум төгрөгийн 3 төсөл арга хэмжээний газрын асуудал бүрэн шийдэгдээгүйгээс хэрэгжилт хангагдаагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж, их засварын 345 төсөл, арга хэмжээний 325–д буюу 94.2 хувьд гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойш буюу барилгын улирал эхэлснээс хойш зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ³–ийн 46 дугаар зүйлийн 46.1.8–д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасныг зөрчиж, төсөл, арга хэмжээ тайлант онд бүрэн хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5–д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан төсөвлөлтийн зарчмыг хангахгүйгээр 2021 онд шинээр хэрэгжүүлэх нийт 171 төсөл, арга хэмжээний санхүүжих дүн хэрэгжих хугацаанд хуваарилсан хэмжээнээс 124.2 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан нь хуулиар тодорхойлсон хугацаанд барилга, байгууламж ашиглалтад орохгүй байх эрсдэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулж гүйцэтгэчийг шалгаруулахдаа 74.0 хувьд нь нээлттэй тендер шалгаруулалт, 18.2 хувьд нь тендер шалгаруулалтын онцгой журам, 4.6 хувьд нь зөвлөх үйлчилгээний аргыг ашигласан байна.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад зарим суурь шаардлагууд хангагдаагүй, эрх зүйн зөрчлүүд гарсан нь хөрөнгө оруулалтын үр ашиг, төсвийн сахилга батад сөргөөр нөлөөлжээ. Тухайлбал, нийт 141 тэрбум төгрөгийн өртөг бүхий 60 барилга байгууламжийг баталгаажсан зураг төсөл, ТЭЗҮ–гүйгээр хуульд тусгаж баталсан нь төсвийн төлөвлөлтийн процесс алдагдсаны илрэл байв. Мөн 17 байгууламжийг баталгаагүй төсөв, зураг төслөөр гүйцэтгэж, ашиглалтад авсан нь техник, санхүүгийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Түүнчлэн шинээр хэрэгжих 257 төсөл, арга хэмжээнээс 13 нь (нийт 37.3 тэрбум төгрөгийн өртөгтэй) баригдах газрын зөвшөөрөлгүй, байршил нь тодорхойгүйгээр батлагдсан бөгөөд 3 төслийн газрын асуудал бүрэн шийдэгдээгүй тул хэрэгжилт зогссон байна. Ийнхүү бэлтгэл хангаагүй төслүүдийг төсөвт тусгасан нь гүйцэтгэл саатах, үргүй зардал бий болох суурь шалтгаан болж байна.

1.2.3 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1376 төсөл, арга хэмжээнд 1.5 их наяд төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1369 төсөл, арга хэмжээний 1.2 их наяд төгрөг, “Барих–шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 7 төсөл, арга хэмжээний 303.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан байна.

3 ТБОНӨХБАҮХАТХ – Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 1369 төсөл, арга хэмжээнээс 664 төсөл, арга хэмжээ (48.5 хувь) шинээр, 705 төсөл, арга хэмжээ (51.5 хувь) нь он дамжин шилжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл 1.5 их наяд төгрөг буюу 99.7 хувийн биелэлттэй байна. Өмнөх оноос шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 87.2 хувь буюу 615 нь барилга, байгууламж байна. Тоног төхөөрөмж, ТЭЗҮ нь тухайн онд бүрэн хэрэгжих боломжтой ч нийт 37 төсөл, арга хэмжээ өмнөх оноос шилжин хэрэгжсэн байна. Энэ нь тоног төхөөрөмж, ТЭЗҮ-ийн хувьд төлөвлөлт, төсөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

Засгийн газраас төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг сайжруулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн батлагдсан төсвийн багцынхаа дүнд багтаан зохицуулалт хийх, барьцаа хөрөнгийн дансанд байршуулан гүйцэтгэлээр санхүүжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэл сайжирсан байна. Мөн эдгээр төслийг хэрэгжүүлсэн 1580 гаруй аж, ахуй нэгжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, 37.9 мянган ажлын байрыг хадгалж, 1.5 их наяд төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжсэн байна.

Хүснэгт 3. 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	Шинэ	3	228.8	118.0
	Үргэлжлэх	980	6152.1	1907.5
Их засвар	Шинэ	2	35.9	35.9
	Үргэлжлэх	71	149.6	72.8
Тоног төхөөрөмж	Шинэ	4	366.1	320.3
	Үргэлжлэх	71	362.6	171.4
ТЭЗҮ	Шинэ	1	40.0	40.0
	Үргэлжлэх	17	41.1	19.9
Нийт дүн	Шинэ	10	670.8	514.2
	Үргэлжлэх	1139	6705.4	2171.8

Эх сурвалж: (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2022)

Эдийн засгийг дэмжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 55 хувь, нийгмийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт 33 хувь, аюулгүй байдал, гадаад харилцаа болон төрийн захиргааны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төслүүдийн санхүүжилт 12 хувийн гүйцэтгэлтэй байна. Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамгийн олон буюу 430 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 81.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нийт 791.8 тэрбум төгрөгийг санхүүжилтийг олгосон байна. Тухайлбал бүс нутгийн онцлогтой уялдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийг ангилбал зүүн бүсийн аймгуудад төрийн үйлчилгээг сайжруулах, аюулгүй байдал ба гадаад харилцааны бодлогыг дэмжсэн төслүүдийг түлхүү хэрэгжүүлж

81.2 тэрбум төгрөг, баруун болон хангайн бүсийн аймгуудад нийгмийн хөгжлийн бодлогыг дэмжсэн төслүүдийг түлхүү хэрэгжүүлж 183.5 тэрбум, төвийн бүсийн аймгуудад эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төслүүдийг түлхүү хэрэгжүүлж 124.0 тэрбум төгрөгийг олгосон байна.

Ашиглалтад орсон нийт төслүүдийн 32 хувь нь авто зам, гүүрийн байгууламжийг шинээр барих, дулаан болон цахилгаан хангамжийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, ус зайлуулах шугам сүлжээ, үерийн далан байгуулах, инженерийн байгууламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бол 14 хувь нь сургууль, цэцэрлэг, дотуур байр зэрэг боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, гурван ээлжээс 2 ээлжид шилжих зорилтыг хангахад чиглэсэн байна. Мөн 15 хувь нь нийгмийг соён гэгээрүүлэх, залуус, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх, ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдийн халамж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төслүүд бол 39 хувь нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслүүд байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2–т “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт–шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана” гэж заасан ч эдгээр хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт байхгүй, хүрэх үр дүн нь ерөнхий байгаагаас тухайн жилд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ нь бодлогын баримт бичигтэй уялдахгүй нөхцөл бий болж байна.

Хүснэгт 4. Төсөл, арга хэмжээ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

ТАХ–ний ангилал	2022 онд шинээр хэрэгжүүлсэн ТАХ			2021 оноос хойш хэрэгжүүлсэн ТАХ		
	Нийцсэн ТАХ–ний тоо	Нийцээгүй ТАХ–ний тоо	Нийт	Нийцсэн ТАХ–ний тоо	Нийцээгүй ТАХ–ний тоо	Нийт
Барилга байгууламж	317	130	447	462	190	652
Их засвар	33	23	56	40	33	73
Тоног төхөөрөмж	105	34	139	117	40	157
ТЭЗҮ	14	8	22	15	9	24
Дүн	469	195	664	634	272	906
Хувь	70.6%	29.4%		69.9%	30.1%	

Эх сурвалж: (Үндэсний аудитын газар, 2023)

Дээрх үзүүлэлтээс харахад 2022 онд шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 29.4 хувь, 2021 оноос хойш хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 30.1 хувь нь бодлогын баримт бичигтэй нийцээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5–д хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь “...хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх” гэсэн шаардлагыг хангаагүй байна. Үндэсний аудитын газраас гаргасан тайланд дурдсанаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын 2021–2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдаагүй, Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чиглэсэн байна. Энэ нь дунд хугацааны бодлогын баримт бичгүүд нь харилцан уялдаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дэмжихгүй байгааг харуулж байна (Үндэсний аудитын газар, 2023).

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх 664 төсөл, арга хэмжээнээс барилга, байгууламж, их засвар ангилалд 502 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс 81 хувь буюу 406 төсөл, арга хэмжээ нь магадлалаар баталгаажсан зураг, төсөлгүй батлагдсан байна. Төсөл, арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталж байгаа нь цаашид төсөвт өртөг нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна. Энэ нь тухайн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа албан тушаалтнуудын сахилга, хариуцлага сул байгааг мөн харуулж байна.

Шинээр хэрэгжүүлэх төсөл арга, хэмжээний төсөвлөлтөд "...техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн шаардлага байгаа ч ТЭЗҮ-ийг ихэнх төсөл, арга хэмжээнд хийхгүй баталсан байна. Мөн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалд 15 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээнд зардал, үр ашгийн шинжилгээ хийхээр заасан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний ихэнхэд нь уг шинжилгээ хийгдэхээргүй нөхцөл үүсгэж байна. 2022 онд шинээр хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээнүүдийг авч үзэхэд 73 төсөл, арга хэмжээ 15.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй байгаа нь нийт төслийн 5.3 хувь байна. Өөрөөр хэлбэл нийт төсөл, арга хэмжээний 5 хувьд л зардал, үр ашгийн шинжилгээ хийхээр байна. Гэвч бодит байдал дээр эдгээр төсөл, арга хэмжээнд аргачлалд заасны дагуу шинжилгээ хийгээгүй байна. Төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн гол үзүүлэлт болох эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэн, зөв, бодитой тооцоогүй, улмаар ТЭЗҮ-ийг орхигдуулж байгаа нь хэрэгцээ, шаардлагаас давсан хөрөнгө оруулалт хийгдэх, төсөвт ачаалал нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна (Үндэсний аудитын газар, 2023).

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 99.7 хувьтай, эдийн засаг, нийгмийн бодлогуудыг дэмжих чиглэлээр 1.5 их наяд төгрөгийн санхүүжилт олгогдсон нь төсвийн хэрэгжилт сайжирсныг харуулж байна. Үүний зэрэгцээ төсвийн багцын доторх зохицуулалтыг сайжруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн нь бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 37.9 мянган ажлын байрыг хадгалахад хувь нэмэр оруулжээ.

Нийт дүнгээр авч үзвэл, 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт гүйцэтгэлийн хувьд өндөр байсан ч төлөвлөлтийн хариуцлага болон бодлогын баримт бичгийн уялдаа сул, хууль зөрчсөн төсөл баталдаг, эдийн засгийн үр ашигт үнэлгээ хийхгүйгээр шийдвэр гаргах үзэгдэл гүнзгийрсээр байна. Энэ нь улсын хөрөнгө оруулалтыг стратегийн ач холбогдолтой, өндөр өгөөжтэй төсөлд төвлөрүүлэх бодлогын чадамж сул байгааг харуулж байгаа бөгөөд цаашид төсөв, төлөвлөлт, хяналт, хариуцлагын тогтолцоог бүх түвшинд эргэн харах шаардлагатай байна.

1.2.4 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 21 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 10, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 1129, нийт 7,376.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1139 төсөл, арга хэмжээг 2,686.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1139 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 77.5 хувь буюу 883 төсөл, арга хэмжээг 2023 онд, 22.5 хувь буюу 256 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 5. 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	Шинэ	3	228.87	118.03
	Үргэлжлэх	980	6152.07	1907.55
Их засвар	Шинэ	2	35.88	35.88
	Үргэлжлэх	71	149.64	72.80
Тоног төхөөрөмж	Шинэ	4	366.07	320.29
	Үргэлжлэх	71	362.61	171.47
ТЭЗҮ	Шинэ	1	40.00	40.00
	Үргэлжлэх	17	41.07	19.97
Нийт дүн	Шинэ	10	670.82	514.20
	Үргэлжлэх	1139	6705.39	2171.79

Эх сурвалж: (Үндэсний аудитын газар, 2024)

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга байгууламжийн 3, их засварын 2, тоног төхөөрөмжийн 1, ТЭЗҮ боловсруулах 1, нийт 10 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үндэсний аудитын газрын “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайланд тусгаснаар тухайн онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх барилга байгууламж, их засварын 5 төсөл, арга хэмжээнээс 3 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- I. НУБХОАЗБТБХД⁴-ийн багцын 45.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээний магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгосон байх шаардлагыг хангаагүй;
- II. НУБХОАЗБТБХД-ийн багцын 45 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй;
- III. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын багцын 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Өнөр бүл” хүүхдийн төвийн их засварын ажил зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байхад төсөвт тусгасан байна.

Мөн “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг тэнцүү хуваарилах байдлаар тооцож батлаагүй байна” гэж дүгнэжээ.

Жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталж байгаа нь түлхүүр гардуулах нөхцөлөөр тендер зарлах, батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд

4 НУБХОАЗБТБХД – Нийслэлийн урсгал ба хөрөнгө оруулалтын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, бүртгэл, хяналт, дүгнэлт

бүтэц, тохижилтын ажил иж бүрэн хийгдэхгүй орхигдох, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хүлээж хугацаа алдах зэргээр төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх хүндрэлийн суурь шалтгаан болж байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд шинэ төсөл, арга хэмжээний тоог хязгаарлаж, өмнөх онуудад эхлүүлсэн шилжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, ашиглалтад оруулах чиглэл баримтлахаар төлөвлөжээ. Гэтэл хуулийн төслийн дээрх үзэл баримтлал, чиглэлээ баримтлахгүйгээр Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.616 дахь заалтыг зөрчин, өмнөх оноос шилжин хэрэгжих болон хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний нэр дээр 12.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр эхлэх 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнд:

- » Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2022 оноос 2023 онд шилжин хэрэгжих Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” /Булган/ төсөл арга хэмжээний 1.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийг 6 дахин нэмэгдүүлж, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан–Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Ховд, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт хэрэгжих 10.2 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ ажлыг;
- » Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад 2023 оноос шинээр эхлэн хэрэгжих 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Бизнес инкубатор төв”-ийн барилга /Увс, Улаангом сум/-ыг 2022 оноос шилжих арга хэмжээ нэрээр тусгасан байна.

Мөн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс төслийн ерөнхийлөн захирагч нар гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон, зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн тохиолдолд өөрчлөлтийн зураг төсвийг гаргуулж зохиогч, захиалагчаар хянуулаагүй, ажлын гүйцэтгэлээ өөрчлөлт оруулсан бодит гүйцэтгэлээр бус анхны зураг, төсвийн дүнгээр тооцож гаргасныг баталгаажуулж, санхүүжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1139 төсөл, арга хэмжээнээс 883 төсөл, арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсний 62.5 хувь буюу 552 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн, 37.5 хувь буюу 331 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэл бэрхшээл, тулгарсан асуудлын шалтгаан, үр дагаврыг судлаагүй, шийдвэрлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй, зарим тохиолдолд албан бичгээр харилцаагүй нь хугацаа алдах, удаашрах, хэрэгжихгүй зогсонги байдал үүсэхэд нөлөөлж байна (Үндэсний аудитын газар, 2024).

2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт гүйцэтгэлийн хувьд нийт 1139 төсөл, арга хэмжээнээс 883–ыг тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 62.5 хувь нь хугацаандаа биелсэн бол 37.5 хувь нь хэрэгжээгүй байна. Төлөвлөгөөний биелэлт хууль, бодлогын баримт бичгийн уялдаагүй байдал, зураг төсөвгүй батлагдсан төсөл, захиалагчийн хяналт сул байснаас үүдэн эрс буурсан дүнтэй гарлаа.

Төсөвт тусгагдсан шинээр хэрэгжүүлэх 10 төсөл, арга хэмжээний талаас илүү нь зураг төсөв, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөлгүй батлагдсан нь хууль зөрчсөн, гүйцэтгэлийн саатал дагуулах үндсэн шалтгаануудын нэг болсон. Тухайлбал, 90 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй нийтийн тээвэр болон захиргааны барилгын төслүүд зураг төсөвгүй, шаардлага хангаагүй нөхцөлтэйгөөр төсөвт туссан байна.

Мөн хөрөнгө оруулалтын зарим шинэ төслийг “шилжих” нэрийн дор тусгасан нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийг ноцтойгоор зөрчсөн бөгөөд үүнд “Шинэ хөдөө” болон “Бизнес инкубатор төв” төслүүдийг дурдаж болно. Энэ нь төсвийн сахилга алдагдаж, санхүүгийн төлөвлөлтийг хиймэл байдлаар гуйвуулж буйг харуулж байна. Захиалагчийн хяналтын сул байдал, гүйцэтгэлтэй

холбоотой баримтжуулалт хангалтгүй байснаас зарим төсөл анхны зураг төсвөөрөө санхүүжигдэж, бодит гүйцэтгэлийн дагуу шалгалт хийгдээгүй, илүү санхүүжилт олгогдсон нь хөрөнгө оруулалтын хариуцлагагүй байдал газар авч буйг харуулж байна.

Дүгнэж хэлбэл, 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт тоон дүнгээр өндөр мэт харагдавч, төлөвлөлтийн ил тод бус байдал, хуулийн зөрчил, шаардлага хангаагүй төсөл батлах, хяналтгүй гүйцэтгэл, бодлогын уялдаа сул зэрэг системийн доголдлууд байсаар байгаа нь төсвийн үр ашигт байдлыг алдагдуулж, хэрэгжилтийн чанарыг эрсдэлд оруулж байна. Цаашид төсөл батлах үе шатнаас эхлэн хуульд нийцүүлж, хариуцлагын тогтолцоог бодитоор хэрэгжүүлэхгүй бол улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн төдийлөн сайжрахгүй байх төлөв ажиглагдаж байна.

1.2.5 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1320 төсөл, арга хэмжээнд 3.85 их наяд төгрөг батлагдсанаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1319 төсөл, арга хэмжээнд 3.8 их наяд төгрөг, “Барих–шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан 1 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 25 тэрбум төгрөг тус тус батлагдсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлсэн 712 төсөл, арга хэмжээнд 1.68 их наяд төгрөг, өмнөх онуудаас шилжин хэрэгжиж байгаа 607 төсөл, арга хэмжээнд 1.4 их наяд төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож, гүйцэтгэл 80.3 хувийн биелэлттэй гарсан байна. Мөн эдгээр төслийг санхүүжүүлснээр 1531 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, 36 мянган ажлын байрыг хэвээр хадгалж, 3.1 их наяд төгрөгийн санхүүжилтээр эдийн засгийг дэмжсэн тухай Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн танилцуулгад дурдсан байна (Монгол Улсын Засгийн газар, 2025).

Хүснэгт 6. 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт (төсөл, арга хэмжээний тоо, тэрбум төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль		
		ТАХ–ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	Шинэ	454	5113.4	1489.1
	Үргэлжлэх	556	5031.4	1407.5
Их засвар	Шинэ	21	50.7	46.0
	Үргэлжлэх	27	94.5	35.9
Тоног төхөөрөмж	Шинэ	213	486.9	456.2
	Үргэлжлэх	22	483.5	77.0
ТЭЗҮ	Шинэ	14	318.5	316.6
	Үргэлжлэх	2	0.7	0.4
Нийт дүн	Шинэ	712	5969.5	2307.9
	Үргэлжлэх	607	5610.1	1520.7

Эх сурвалж: (Үндэсний аудитын газар, 2025)

Төсвийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 4.8.37 дахь заалтад тус тус үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн саналын

дагуу гүйцэтгэл, хэрэгжилт сайн 118 төсөл, арга хэмжээнд 127.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийн зохицуулалт хийж, 2024 онд багтаан олгосон байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын хүрээнд гэрээ байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн 462 төсөл, арга хэмжээний 691.6 тэрбум төгрөгийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор гүйцэтгэлээр олгох санхүүгийн арга хэрэгслийг авч хэрэгжүүлсэн байна. Ингэснээр төслүүд хугацаандаа ашиглалтад орох, нэмэлт санхүүжилт үүсэхээс сэргийлэх, дараа онуудын төсвийн ачааллыг бууруулах зэрэг ач холбогдолтой байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан байна. Энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төслүүдийг бүс нутгаар нь харвал Хангайн бүсийн гүйцэтгэл хамгийн өндөр буюу 89 хувь, Хойд бүсийн гүйцэтгэл хамгийн бага буюу 74 хувьтай тус тус гарсан бөгөөд улсын хэмжээнд гүйцэтгэл дунджаар 81.5 хувьтай байна.

2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 1320 төслөөс нийт гүйцэтгэл 80.3 хувьтай гарсан нь өмнөх оны 96.4 хувийн гүйцэтгэлтэй харьцуулахад буурсан дүн болов. Энэ нь 2023 онд шинэ төсөл батлаагүй, зөвхөн өмнөх төслүүдийг дуусгах зорилтыг барьж, хэрэгжилтийн хяналтыг сайжруулсантай холбоотой бол, 2024 онд шинээр 712 төсөл баталж, бодит гүйцэтгэл саарсан дүр зураг харагдаж байна.

Төсөв, гүйцэтгэл дутуу байгаа 462 төсөлд санхүүжилтийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, 2025 оны 8 дугаар сар хүртэл гүйцэтгэлээр санхүүжүүлэх зохицуулалт хийсэн нь хөрөнгө оруулалтад санхүүгийн сахилга, төлөвлөлтийн уян хатан байдлыг оруулж байгаа ч, гүйцэтгэл удаашрах эрсдэлийг бүрэн арилгаагүй байна. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтад уялдуулан тусгасан боловч хэрэгжилт жигд бус байна. Хангайн бүсийн гүйцэтгэл 89 хувьд хүрсэн бол Хойд бүсийнх 74 хувьтай байгаа нь бүс нутгийн хөгжлийн зөрүү, төлөвлөлт-менежментийн ялгааг илтгэж байна.

2024 оны төсвийн хөрөнгө оруулалт нь тоон дүнгээр өссөн ч гүйцэтгэл буурч, төслийн санхүүжилт гажуудан, бүсүүдийн хувьд эрс ялгаа гарч, санхүүжилтийн механизмыг хойшлуулах аргачлал давамгайлсан нь төсвийн бодлогын хэрэгжилтэд системийн доголдол байсаар буйг нотолж байна. Цаашид төсвийн сахилга, урьдчилсан үнэлгээ, бүсийн хариуцлагыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, үр ашигт суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд Үндэсний аудитын газраас хийсэн нийцлийн тайланг авч үзэхэд дараах асуудлыг тодорхой гаргасан байна.

Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх 712 төсөл, арга хэмжээнээс 182 төсөл, арга хэмжээг буюу 25.6 хувийг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн, 74.4 хувь нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй, дунд болон урт хугацааны ерөнхий зорилтод чиглэсэн байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 291 дүгээр зүйлийн 291.1-д заасны дагуу шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг зөвхөн үнэлж, эрэмбэлж байгаа бөгөөд их засварын ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ТЭЗҮ боловсруулах ажлыг нэн тэргүүний хэрэгцээ, шаардлага, ач холбогдол зэрэг шалгуураар үнэлж, эрэмбэлж төлөвлөх асуудлыг хууль, журмаар зохицуулаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд газрын зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээг тусгахыг хориглосон байхад 79.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалттай нийцээгүй байна. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байгаа нь худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж амжихгүй, батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглаж чадахгүй байх, гэрээний хугацаанд хэрэгжихгүй удаашрах зэрэг үр дагаврыг бий болгож, тухайн төсөл, арга хэмжээ олон жил үргэлжлэх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх урт, дунд, богино хугацааны бодлогыг уялдуулах, улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний нэр төрөл, цар хүрээ, төсөвт өртгийн хэмжээ, зориулалт зэргийг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн тоног төхөөрөмжийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг судалж тооцох, тодорхойлох, төлөвлөх, хянах тогтолцоо бүрдээгүйгээс Эрүүл мэндийн сайдын багцын тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнээс “Туулах чадвар сайтай, алсын түргэн тусламжийн автомашин” нэрээр 2.2 тэрбум төгрөгөөр 9 ширхэг жийп машин буюу “Toyota Land Cruiser 300GXR”, “Land Cruiser 250”, “Land Cruiser Prado 150”, “Hilux”, “Grand cherokee” маркийн автомашин худалдан авч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Улсын нэг, хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн, эрүүл мэндийн үндэсний төв, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газарт тус тус олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.116, 6.317 дахь заалттай нийцээгүй байна.

Зураг 4. “Grand cherokee”, “Toyota Land Cruiser 300GXR”, “Land Cruiser 250” маркийн автомашин



Эх сурвалж: (Үндэсний аудитын газар, 2025)

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталснаас зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад тодорхой хугацаа зарцуулснаас шалтгаалж 272.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 45 барилга байгууламжийн ажлын тендерийг 2024 оны 10, 11, 12 дугаар сард зарласнаар гэрээ байгуулах ажиллагаа хойшлогдож, тухайн онд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулах боломжгүй болжээ.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 62.7 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 69.0 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт

оновчгүй, 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ба Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ажлуудыг төлөвлөж баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад санхүүжүүлж эхлүүлсэн 4 хэрэгжиж дуусаагүй зогссон барилга байгууламжийн нэгдсэн судалгаа, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, тулгарсан асуудлын шийдэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна (Үндэсний аудитын газар, 2025).

II. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АРГА ЗҮЙ

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлгийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтыг урт хугацааны алсын хараа, бодлоготой хэрхэн уялдуулан хэрэгжүүлж, тэргүүлэх чиглэлийг сонгож байгааг онолын үндэслэл болон олон улсын туршлагад тулгуурлан тодорхойлж, Монгол Улсын нөхцөл байдалд хэрхэн уялдуулж буйг дүгнэв. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгон шалгаруулахад ашиглаж буй аргачлал, баримт бичгийн хүрээг нэгтгэн судлав.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын систем нь дунд хугацааны төсвийн хүрээнд жил бүрийн төсвийн хязгаарыг тогтоох зохицуулалтаар олон улсын жишигтэй нийцэж байгаа ч стратегийн зорилго, бодлогын уялдаа болон санхүүгийн боломжийг нарийвчлан тооцох, оновчтой удирдах чадавх сул байна. Үүний улмаас төсөл сонгон шалгаруулах, эрэмбэлэх, хэрэгжилт болон хяналтын шатанд гүнзгийрүүлсэн шинжилгээ, үр дүнтэй удирдлага бүрэн хангагдахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад хэрэгжиж буй төсөл үнэлгээний аргачлал нь голчлон зардал–үр ашгийн шинжилгээнд төвлөрдөг бөгөөд санхүүгийн өгөөж, нийгэм, хүрээлэн буй орчны нөлөөлөл зэрэг олон талт үзүүлэлтийг хангалттай хамарч чаддаггүй. Үүний улмаас төслийн бодит үр нөлөө болон гүйцэтгэлийн удирдлага сул байна. Мөн төсөл сонгон шалгаруулах журам тодорхой боловч хэрэгжилт, хяналтын уялдаа хангалтгүй, улс төрийн нөлөөллөөс ангид бус байдал нь төсвийн хөрөнгө оруулалтад оновчгүй, үр ашиггүй төсөл багтах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоо суурь түвшинд бүрдсэн ч стратеги, бодлогын уялдаа, олон шалгуурт үнэлгээ, гүйцэтгэлийн хяналтын чиглэлд анхааран сайжруулах шаардлагатай байна. Хязгаарлагдмал төсвийн нөөцийг илүү өгөөжтэй, ач холбогдолтой төслүүдэд чиглүүлэхийн тулд:

- » Төсвийн хязгаар тогтоох процессыг стратеги, санхүүгийн боломжид тулгуурлан оновчтой болгох;
- » Төслийн үнэлгээг олон талын шалгуурт, хараат бус, дата суурьтай системд шилжүүлэх;
- » Гүйцэтгэлийн хяналтыг цахим платформоор уялдуулан, ил тод, үр дүнтэй болгох шаардлагатай.

Эдгээр шинэчлэл нь төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын үр ашгийг бодитойгоор нэмэгдүүлэх суурь нөхцөл болох юм.

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги

Аливаа улс орон хөгжлийн түвшин, эдийн засаг, нийгмийн бүтэц, нөөц боломж болон гадаад орчны нөлөөллөөс хамааран төсвийн хөрөнгө оруулалтаа аль салбарт төвлөрүүлэх, ямар төслүүдийг хэрэгжүүлэх вэ гэдэг стратегийн сонголт хийдэг. Энэхүү сонголтыг хийхдээ улс орнуудын хувьд олон улсын туршлага болон онолын үндэслэлд тулгуурласан дараах арга зүй, стратегийг өргөн хэрэглэдэг байна. Үүнд:

- » *Хөгжлийн үе шатны онол (Stages of Development Theory)* – Эдийн засгийн хөгжилд суурилсан энэ онол нь улс орнуудын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг хөгжлийн үе шаттай уялдуулан тодорхойлдог.
- » *Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах (SDG prioritization)* – Нэгдсэн үндэсний байгууллагын 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs) нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж буй цогц хүрээ юм. Сүүлийн жилүүдэд олон улс орон эдгээр зорилтыг үндэсний хөгжлийн бодлого, төсвийн төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх хандлагыг өргөнөөр баримтлах болжээ. Ийм уялдаа нь төрийн төсвийн хөрөнгө оруулалтыг нийтийн сайн сайхныг дэмжих, нийгмийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах зэргээр стратегийн түвшинд чиглүүлж, хөгжлийн үр ашгийг дээшлүүлэх суурь нөхцөл болдог.
- » *Хүртээмжтэй өсөлтийн стратеги (Inclusive Growth Strategy)* – Энэ стратеги нь хөгжлийг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмжих бус, хүн амын бүлгүүдэд хүртээмжтэй байдал, нийгмийн шударга байдлыг харгалзан хөрөнгө оруулалтын чиглэлүүдийг тодорхойлдог.
- » *Бодлогын тэргүүлэх чиглэлийн үнэлгээ (Policy Priority Mapping)* – Хөгжлийн бодлого, олон салбарын уялдааг хангах үүднээс олон улс Multi-Criteria Decision Analysis (MCDA), Public Investment Management Assessment (PIMA) зэрэг үнэлгээний арга зүйг ашиглан хөрөнгө оруулалтыг эрэмбэлдэг.

Дээр дурдсан арга зүй, стратегиудаас Хөгжлийн үе шатны онол болон Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах хандлага нь улсын урт хугацааны хөгжлийн зорилго, бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын салбар, чиглэлийг тодорхойлоход илүү оновчтой, зохистой суурь аргачлал болж байна. Эдгээр арга зүй нь төсвийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцыг макро түвшинд авч үзэж, эдийн засгийн бүтэц, нийгмийн хэрэгцээ, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг цогцоор нь харгалзан, хөгжлийн үе шат, зорилтод хүрэх замналд нийцтэй байлгах боломжийг бүрдүүлдэг.

Харин бусад стратеги, тухайлбал хүртээмжтэй өсөлтийн стратеги, бодлогын тэргүүлэх чиглэлийн үнэлгээ зэрэг нь илүү нарийн түвшний буюу тухайн төслийн ач холбогдол, нийгэм-эдийн засгийн өгөөж, хэрэгжилтийн хүртээмж зэргийг олон шалгуураар үнэлж эрэмбэлэхэд чиглэдэг. Энэ нь тухайн хөрөнгө оруулалтын шийдвэрийн хэрэгжилтийн шатанд чухал ач холбогдолтой хэдий ч, урт хугацааны хөгжлийн чиг баримжаа тогтоох үндэслэл болгон ашиглахад хүрээ хязгаар багатай байна. Судалгааны багийн зүгээс эдгээр арга зүйг 2 дугаар бүлгийн 3 дугаар хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Иймд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь үндэсний урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийн чиглэлүүдтэй уялдаж чадаж байгаа эсэх, түүнчлэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явц нь хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор Хөгжлийн үе шатны онол болон Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулсан хөрөнгө оруулалтын арга зүйг дараагийн хэсэгт дэлгэрэнгүй судалж, олон улсын туршлага, сайн жишээтэй харьцуулан шинжилж, дүгнэлт гаргасан болно.

2.1.1 Стратеги 1 – Хөгжлийн үе шатны онол

Америкийн нэрт эдийн засагч, улс төр судлаач Уолт Уитмен Ростоу 1960 онд хэвлүүлсэн “The Stages of Economic Growth: A Non-Communist Manifesto” бүтээлдээ улс орнуудын эдийн засгийн

хөгжлийн үйл явцыг таван үндсэн үе шаттайгаар онолын түвшинд загварчилсан нь эдийн засгийн хөгжил, бодлого төлөвлөлтийн салбарт суурь онолын хандлага болон төлөвшсөн. Тэрбээр улс орнуудын хөгжлийг уламжлалт нийгмээс орчин үеийн эдийн засгийн өсөлттэй бүтцэд шилжих динамик процесс гэж үзэж, эдийн засгийн хөгжлийн дараалсан шатлал, түүний шинж тэмдгийг системчилсэн байдлаар тайлбарласан нь тухайн үеийн капиталист хөгжлийн загварт онолын дэмжлэг үзүүлсэн төдийгүй хөгжиж буй улс орнуудын хөгжлийн бодлогын суурь үндэслэл болж, улс төр, эдийн засгийн стратеги боловсруулахад өргөн ашиглагдах болсон байна.

Хүснэгт 7. Ростоугийн хөгжлийн үе шатууд, тэдгээрийн онцлог

№	Үе шат	Үе шатны онцлог
1	Уламжлалт нийгэм (Traditional society)	- Хөдөө аж ахуй давамгай - Технологийн хөгжил сул - Дэд бүтэц, боловсрол, шинжлэх ухаан хөгжөөгүй - Нийгмийн бүтэц нь уламжлалт, хаалттай
2	Өсөлтөд бэлтгэх үе (Preconditions for take-off)	- Дэд бүтэц хөгжиж эхэлнэ - Үйлдвэрлэл болон худалдаа нэмэгдэнэ - Хөрөнгө оруулалтын түвшин өснө (ДНБ-ий ~5–10%)
3	Өсөлтийн эхлэл (Take-off)	- Аж үйлдвэрийн үйлдвэрлэл эрчимтэй өснө - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаа нэмэгдэнэ - Экспортод чиглэсэн үйлдвэржилт - Хөрөнгө оруулалт ДНБ-ий $\geq 15\%$ хүрнэ
4	Тогтворжсон өсөлт (Drive to maturity)	- Эдийн засаг төрөлжиж, өндөр технологи нэвтэрнэ - Үйлдвэрлэл олон салбарт хөгжинө - Технологийн шинэчлэл явагдана
5	Өндөр хэрэглээний шат (Age of high mass consumption)	- Орлого өндөр, хэрэглээ нэмэгдсэн - Үйлчилгээний салбар давамгайлна - Нийгмийн хамгаалал, дотоодын хэрэглээний эдийн засаг

Энэхүү судалгаанд Ростоугийн хөгжлийн үе шатны онолын хэрэглээ, бодит хэрэгжилтийг харьцуулан шинжлэх үүднээс дараах хоёр улсыг сонгон авч, дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд: (1) уг онолын бүхий л үе шатыг тууштай хэрэгжүүлж, эдийн засгийн өндөр хөгжилд хүрсэн Бүгд найрамдах Солонгос улсын туршлага, (2) хөгжлийн эхний шатуудыг амжилттай туулсан хэдий ч, бүтэц, институцийн хувьд тогтворжих шилжилтийн шатанд саатсан Холбооны бүгд найрамдах Бразил улсын туршлагыг авч үзэв.

Бүгд найрамдах Солонгос улс: Бүгд найрамдах Солонгос улс нь эдийн засгийн хөгжлийн талаарх Ростоугийн таван шатлалт онолын *жишиг хэрэгжилт* гэж тооцогддог ховор тохиолдлын нэг юм. Тус улс нь хөгжлийн үе шат бүрд зорилтот, төлөвлөгдсөн хөрөнгө оруулалт бүхий төрийн бодлого хэрэгжүүлж, төрийн манлайллыг оновчтой ашигласнаар онолын суурь үзэл баримтлалыг бодит амжилтаар баталсан байдаг. Үүний үр дүнд Солонгос улсын хөгжлийн түүх нь тус онолын бодит хэрэглээний тод жишээ болж, олон судлаачийн анхаарлын төвд орсон байна.

Хүснэгт 8. Бүгд найрамдах Солонгос улсын хөгжлийн үе шатууд, үе шат бүрд хийгдсэн төсвийн хөрөнгө оруулалтууд, эзлэх хувиар

Үе шат	Бүгд найрамдах Солонгос Улсын нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн бодлого	Төсвийн хөрөнгө оруулалт хийсэн салбарууд, эзлэх хувиар
Уламжлалт нийгэм (1945 оноос өмнө)	Эдийн засаг нь хөдөө аж ахуйд суурилсан, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжөөгүй, технологийн бие даасан хөгжилгүй бөгөөд иргэдийн боловсрол сул байсан үе. 1910–1945 оны хооронд Япон улсын колони байсан тул дэд бүтцийн хувьд ихэнх нь Япон улсын зорилгод нийцсэн байсан.	–
Өсөлтөд бэлтгэх үе (1945–1960 он)	1945 онд Япон улсаас салж, тусгаар тогтнолоо зарласан. 1950–иад онд АНУ–ын тусламжаар сэргээн босгох бүтээн байгуулалт өрнүүлж, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн суурь бүтэц тавигдсан.	- Нийгмийн дэд бүтэц $\approx 30\%$ - Батлан хамгаалах дэд бүтэц $\approx 25\%$ - Орон сууц, хот сэргээх $\approx 15\%$ - ХАА болон жижиг үйлдвэр $\approx 15\%$ - Боловсрол, эрүүл мэнд $\approx 10\%$
Өсөлтийн эхлэл үе (1961–1979)	1961 онд генерал Пак Чон Хи төрийн эрхэнд гарч, төвлөрсөн хөгжлийн төлөвлөгөө (5 жилийн төлөвлөгөө) эхлүүлсэн.	- Нийгмийн дэд бүтэц $\approx 55\text{--}60\%$ - Хүнд үйлдвэр, уурхайн тоног төхөөрөмж $\approx 20\text{--}25\%$ - ХАА–загас $\approx 12\text{--}15\%$ - Боловсрол, соёл, эрүүл мэндийн барилга $\approx 5\text{--}10\%$
	1962–1971 онуудад 1, 2 дахь 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хөнгөн үйлдвэрүүдийг дэмжсэн (текстиль, гутал, хүнс). Гадаадын хөрөнгө оруулалт хангалтгүй байсан тул дотоодын үйлдвэрлэлийг ихээр дэмжиж, экспортыг нэмэгдүүлэхэд анхаарсан.	
Хөгжлийг гүнзгийрүүлэх үе (1980–1996)	1970–1980 онуудад Heavy-Chemical Industry (HCI) буюу Хүнд үйлдвэр–хими бодлогын хүрээнд хүнд, химийн үйлдвэрлэлд томоохон хөрөнгө оруулалт хийгдсэн. Төрийн зүгээс Гадаад хөрөнгө оруулалт, ялангуяа Япон болон АНУ–аас хөрөнгө оруулалт татах бодлого явуулсан. Боловсролын системийг шинэчилж, техникийн боловсролыг түлхүү дэмжсэн.	- Хүнд–химийн үйлдвэр $\approx 35\text{--}40\%$ - Нийгмийн дэд бүтэц $\approx 30\text{--}35\%$ - Эрчим хүч $\approx 10\%$ - ХАА $\approx 10\%$ - Батлан хамгаалах, боловсрол $\approx 5\%$
	Хүнд үйлдвэр, хими (HCI) бодлогын хүрээнд ган, усан онгоц, автомашин, цахилгаан барааны үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, Chaebol буюу том корпорацууд (Samsung, Hyundai, LG) хүчирхэгжсэн. Мөн хүнд үйлдвэрээс гадна технологийн хөгжил, инновацад оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн. 1988 онд Сөүл хотод Олимп зохион байгуулсан нь Өмнөд Солонгосын нэр хүндийг өсгөсөн. Дотоодын зах зээлийн багтаамж өсөж, хөдөлмөрийн бүтээмж сайжирч, дундаж давхарга өргөжсөн.	

Өндөр хэрэглээний үе (1997–одоог хүртэл)	1997 оны Азийн санхүүгийн хямралаас сургамж авч, санхүүгийн системийг шинэчилсэн. Мэдээллийн технологи, цахим технологи, хиймэл оюун ухаан, биотехнологи зэрэг өндөр технологийн салбарт илүүтэй анхаарч, нарийн технологиудыг (чип, электроник, хиймэл оюун ухаан буюу AI) ихээр экспортлох болсон. Иргэдийн дундаж орлого 30,000–40,000 ам.долларт хүрсэн. Боловсрол, эрүүл мэндийн систем дэлхийн түвшинд ойртсон. Мөн К–поп, соёлын экспорт нь “зөөлөн хүч”-ийг дэлхийд таниулсан.	(1997–2008)
		• Нийгмийн дэд бүтэц ~35% • Орон сууц–хот сэргээх ~15% • Байгаль–орчин ~10% • Дижитал салбарын судалгаа хөгжүүлэлт ~10% • Боловсрол–соёл ~13% • Халамж–эрүүл мэнд ~10% • Батлан хамгаалах ~2–4%
		(2008–2019)
		• Цифр–нүүрстөрөгч бууруулалтын судалгаа хөгжүүлэлт ~20% • Нийгмийн дэд бүтэц ~15% • Ногоон/байгаль ~15% • Халамж–гэр–эрүүл мэнд ~15% • Боловсрол–соёл ~9% • Батлан хамгаалах ~6%

Эх сурвалж: (II CaКонг, 2010), (Хонг, 2001), болон бусад⁵

Бүгд найрамдах Солонгос улсын хөгжлийн үе шат болон төсвийн хөрөнгө оруулалтыг харьцуулан харахад дэд бүтэц, батлан хамгаалах болон сэргээн босголтод илүүтэй хөрөнгө оруулж, өсөлтийн суурийг тавьсан байна. Үүний дараагаар хүнд үйлдвэрлэлд төвлөрч, экспортыг дэмжсэн бөгөөд энэ нь тус улсын хөгжлийг гүнзгийрэх шатанд хүргэсэн байна. Мөн зөвхөн хүнд үйлдвэрлэл гэлтгүй технологийн салбарт судалгаа, хөгжүүлэлт хийж эхэлсэн бөгөөд энэ нь олон улсын цаашдын чиг хандлагад нийцсэн ухаалаг үйлдэл болжээ. Бүгд найрамдах Солонгос улс нь Ростоугийн онолын үе шатыг зөв тодорхойлж, хөгжлийн бодлогыг үе шаттайгаар оновчтой хэрэгжүүлснээр 25 жилийн хугацаанд хөдөө аж ахуйн эдийн засгаас дэлхийн технологийн төв болж чадсан байна.

Холбооны бүгд найрамдах Бразил улс: Бразил улсын эдийн засгийн хөгжил нь 1960–1970 онд Ростоугийн “Өсөлт эхлэх” үе шатыг амжилттай давж, хөгжлийг гүнзгийрүүлэх үе шат руу шилжиж орсон хэдий ч бодлого хэрэгжүүлэгчдийн сул байдал, макро эдийн засгийн эмзэг, тогтворгүй нөхцөл байдал нь хөгжлийг гүнзгийрүүлэхэд саад учруулсан байна.

Хүснэгт 9. Бразил улсын хөгжлийн үе шат, Ростоугийн онолоор

Үе шат	Он	Нөхцөл байдал
Уламжлалт нийгэм	1950	Хөдөө аж ахуйн эдийн засаг давамгайлж байсан.
Өсөлтөд бэлтгэх үе	1960	Дэд бүтцийн болон аж үйлдвэржилтийн суурь бэхжүүлэлт.
Өсөлт эхлэх үе	1970	Хүнд үйлдвэр, авто үйлдвэрлэл, барилгын томоохон төсөл (Trans–Amazonian Highway буюу Транс Амазоны хурдны зам).
Хөгжлийг гүнзгийрүүлэх үе рүү орсон хэдий ч зогссон	1980	Өрийн хямрал, инфляц, макро эдийн засгийн тэнцвэргүй байдал.

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

5 K Developedia, IMF.org, Archives.go.kr, s–space.snu.ac.kr, Kellogg.nd.edu, encykorea.aks.ac.kr, nabo.go.kr, issues.org, kdi.re.kr, korea.kr, English.moef.go.kr

Бразил улсын “Хөгжлийг гүнзгийрүүлэх” үе шат зогсоход дараах хүчин зүйлс ихээр нөлөөлсөн байна. Үүнд:

1. *Өрийн дарамт*: 1982 он гэхэд гадаад өр 90 тэрбум ам.долларт хүрч, гадаад өр төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй гэдгээ зарлаж, өрийн хямралд орсон.
2. *Инфляц*: 1980–1994 онд гиперинфляц нүүрлэж, 1980 онд 100 хувь байсан бол хамгийн ихдээ 1990 онд 30.4 хувь хүртэл өсөж, тус 14 жилийн хугацаанд жилд дунджаар 2,785 хувийн инфляцын өсөлттэй байсан.
3. *Төрийн тогтолцооны сул байдал ба авлига*: 1989 оны Геддес, Барбара болон Артур Рибейро Нето нарын 1989 онд нийтэлсэн “Бразил дахь авлигын институцийн эх үүсвэр”, Спрингерийн 1989 онд хийсэн “Бразил дахь улс төрийн авлига” судалгаа болон Томас Ж.Требатын 1983 онд хийсэн “Наяад оны Латин Америкийн гадаад өр: Бразилын жишээ” зэрэг судалгааны ажлуудад төрийн байгууллагын үйл ажиллагаа, тендерийн системийн дотоод хяналт, ил тод байдал маш сул байсан нь улсын зээлийн хуваарилалт, төсвийн зарцуулалт болон төрийн худалдан авалт, улс төрийн томилгоо зэрэгт өргөн цар хүрээнд авлигын тогтолцоо бий болж байсныг харуулсан тухай дурдсан байна.

Бразил улсын жишээ нь Ростоугийн хөгжлийн үе шатны онолын албан ёсны замналд саад учруулж болох гол хүчин зүйлсийг тод харуулсан байдаг. Үүнээс дүгнэхэд аливаа улс орон нь төсвийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлогын судалгаа шинжилгээний үндсэн дээр зөв тодорхойлж, тогтвортойгоор хэрэгжүүлж, бодлого хэрэгжүүлэгчид нь хөрөнгө оруулалтын төслийг сонгон шалгаруулах болон бусад үйл ажиллагаанд авлига, хээл хахуулиас ангид зөвхөн тогтсон арга, аргачлалын үндсэн дээр төсөл, болон төсөл хэрэгжүүлэгчийг сонгох үйл ажиллагааг мэргэжлийн, хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Монгол Улстай харьцуулсан дүгнэлт: Бүгд найрамдах Солонгос улсын туршлагаас үзэхэд, хөгжлийн гүнзгийрэх шатанд шилжихийг зорьж буй Монгол Улсад үйлдвэрлэл, судалгаа, хөгжүүлэлт болон инновац зэрэг дэлхийн эдийн засгийн чиг хандлагад нийцсэн салбаруудыг дэмжих хөрөнгө оруулалтын бодлого туйлын шаардлагатай байна. Ийм чиглэлийг баримтлах нь эдийн засгийн бүтцийн шинэчлэл хийх, экспортыг төрөлжүүлэх, дунд ба урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үндэс суурь болох юм. Гэвч Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүтэц харьцангуй нэг талтай байсаар ирсэн бөгөөд дийлэнх хөрөнгө оруулалт нь дэд бүтэц, зам, тээврийн салбарт төвлөрсөн хэвээр байна.

Үүний зэрэгцээ авлигын түвшин өндөр, авлигыг хянах институцийн чадамж сул байгаа нь төсвийн зарцуулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж, хөгжлийн дараагийн шатанд шилжихэд бодит эрсдэл үүсгэж байна. Тухайлбал, 2023 оны байдлаар Дэлхийн банкнаас гаргадаг “Авлигын хяналтын индекс”-ийн –2.5–аас 2.5–ын хооронд үнэлэгддэг үнэлгээгээр Монгол Улс–0.5 оноотой үнэлэгдэж⁶, “Transparency international” байгууллагаас танилцуулдаг Авлигын индексээр Монгол Улс 100 онооноос 33 оноо⁷ авсан нь институцийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоо хангалтгүй хэвээр байгааг тодорхой харуулж байна. Иймд Монгол Улс төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой бий болгох зорилгоор төрийн худалдан авалт, тендерийн процесс дахь авлигыг бууруулж, хяналтыг сайжруулахад анхаарах шаардлагатай. Эс

6 <https://databank.worldbank.org/databases/control-of-corruption>, <https://data.worldbank.org/indicator/CC.ES>

7 <https://www.transparency.org/en/cpi/2024/index/mng>

бөгөөс, Бразил улсын нэгэн адил хөгжлийн анхан шатны дэвшлийг гаргасан ч институцийн сул тогтолцоо, авлигын өндөр эрсдэлээс шалтгаалан дараагийн шатанд шилжих боломжоо алдах нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

2.1.2 Стратеги 2 – Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах нь

Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs)–тай уялдуулан хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын чиглэлийг эрэмбэлэх стратеги нь улс орнуудын зүгээс 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан 17 зорилго, 169 зорилтын хүрээнд өөрийн бодлого, төсөл, хөрөнгө оруулалтыг нийцүүлэх замаар хязгаарлагдмал төсвийн нөөцийг үр ашигтай, оновчтой хуваарилах шийдвэр гаргах чухал аргачлал юм. Энэхүү стратегийн гол зорилго нь нийтийн ашиг сонирхлыг дээдлэх зарчимд тулгуурлан, нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчинд хамгийн өндөр үр өгөөж, нөлөөлөл үзүүлэх салбар, чиглэлүүдийг тодорхойлох, улмаар бодлогын уялдаа, хөрөнгө оруулалтын ухаалаг зохицуулалтыг хангахад оршдог.

Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулж улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбаруудыг сонгох нь дараах давуу талуудыг бий болгож байдаг. Үүнд:

1. *Хязгаарлагдмал нөөцийг оновчтой хуваарилна.* Тогтвортой хөгжлийн зорилгуудын уялдаа холбоо, харилцан хамаарлыг гүнзгий ойлгосноор хязгаарлагдмал нөөцийн нөхцөлд зөвхөн нэг бус, олон зорилгод зэрэг үр өгөөж өгөх стратегийн хөрөнгө оруулалтыг тодорхойлох боломж бүрддэг. Санхүүгийн хомс байдлыг харгалзан бүх зорилгод зэрэг хөрөнгө оруулах боломжгүй тул шат дараалсан, уялдаа бүхий төлөвлөлт хийх нь оновчтой. Тухайлбал, боловсролын салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт нь ядуурлыг бууруулах, эрүүл мэндийг сайжруулах, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг олон талт нөлөө үзүүлдэг.
2. *Хөгжлийн олон талт байдал хангагдана.* Улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжихээс гадна нийгмийн тэгш байдал, байгаль орчны тогтвортой байдал, төрийн байгууллагын чадавх зэрэг өргөн хүрээний асуудлыг авч үздэг.
3. *Бодлогын уялдаа сайжирна.* Яам, төрийн агентлагууд хоорондын хөрөнгө оруулалт нь бие биеийнхээ зорилгод сөргөөр нөлөөлөхгүйгээр дэмжих чиглэлд хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлдэг.
4. *Олон улсын санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлнэ.* Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсвийн бүтэцтэй улс орнууд нь олон улсын донор байгууллага, хөгжлийн банк, төсөл, хөтөлбөрүүдээс санхүүжилт татах боломж нэмэгдэж байдаг.
5. *Хяналт болон үр дүнг үнэлэх процесс сайжирна.* Тогтвортой хөгжлийн зорилтод суурилсан хөрөнгө оруулалтын бодлогын хяналт болон үр дүнгийн үзүүлэлтүүд нь тодорхой байдаг тул хөрөнгө оруулалтын нөлөөлөл болон бүтээмжийг олон улсын түвшинд харьцуулалт хийж, тайлагнах түвшинд дүгнэх боломж нэмэгддэг.
6. *Урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжинэ.* Дэлхий дахины нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагад суурилан тогтвортой хөгжлийн зорилтуудыг тодорхойлдог тул зөвхөн өнөөдрийн тулгамдаж буй асуудлыг шийдэж, богино хугацааны хэрэгцээг хангах бус ирээдүйн хэрэгцээг хангах, хөгжилд чиглэн хөрөнгө оруулалт хийх суурийг тавьдаг.

Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан хөрөнгө оруулалтын салбаруудыг дараах үндсэн алхмын хүрээнд тодорхойлдог.

Хүснэгт 10. Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах стратегийн үндсэн алхмууд

№	Алхам	Тайлбар
1	Улс орны нөхцөл байдлын үнэлгээ хийх	Улс орны хувьд Тогтвортой хөгжлийн бодлогын 17 зорилтын аль нь илүү тулгамдсан байгааг тодорхойлох.
2	Тулгамдаж буй зорилтуудын харилцан хамаарлыг шинжлэх	Зорилт тус бүрийг дэмжих үед бусад зорилгодоо нөлөөлөх нөлөөллийг үнэлэх.
3	Шалгуур тодорхойлох	Дэмжихээр сонгосон төслийн үр дүнг үнэлэх шалгуурыг тодорхойлох.
4	Нөөцийн хуваарилалт, бодлогын уялдааг тодорхойлох	Төсвийн хөрөнгө оруулалтад зарцуулах санхүүжилтийг дэмжихээр сонгосон зорилго тус бүрд хуваарилах.
5	Хяналт хийх, үр дүнг үнэлэх	Үр дүнг хэмжиж, дүгнэлт гаргах.

Монгол Улсын хувьд, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа–2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталсан байна. Ингэхдээ урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг 5 жил тутам хяналт–шинжилгээ, үнэлгээ хийж байхаар заасан байна. Үндэсний аудитын газраас 2025 онд хийсэн “Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт” сэдэвт аудитын тайланд дараах голлох дүгнэлтийг тусгасан байна. Үүнд:

- » Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2021–2024 онд 67.7 хувьтай хэрэгжсэн. Үүнээс 14.8 хувь нь “Үр дүнтэй”, 50.2 хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, 32.5 хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, 2.5 хувь нь “Үр дүнгүй” буюу хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй байна. Мөн үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв тайлагнаж, үнэлээгүй байна.
- » Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан хэдий ч үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй. Мөн санхүүжилтийн эх үүсвэрийг хангалттай шийдвэрлээгүй ба хэрэгжилт дутмаг хэдий ч хариуцлага тооцох нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.
- » “Монгол Улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”–д тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож үнэлээгүй нь хууль, эрх зүйн зохицуулалт дутагдалтай, уг үнэлгээг хийх тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна.

Тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулан төсвийн хөрөнгө оруулалт хийх салбаруудыг эрэмбэлэх, тэдгээрт оруулах хөрөнгө оруулалтын дүнг тодорхойлохын тулд (1) тогтвортой хөгжлийн бодлогыг улсын онцлогт тохируулан боловсруулах, (2) тогтвортой хөгжлийн бодлогын хүлээгдэж буй үр дүн, хэмжих арга зүйг тодорхой болгох, (3) салбар хоорондын уялдаа холбоо, бие биедээ үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Иймд Монгол Улсад хэрэгжиж буй бодлогыг цаашид хэрэгжүүлэхдээ эхний 4 жилийн дүгнэлтэд үндэслэн хүлээгдэж буй үр дүн, хэмжих арга зүйг тодорхой болгож, салбар хоорондын уялдаа холбоог үнэлэн, хөрөнгө оруулалтыг төсөвлөж, мөн хэрэгжилтийг сайжруулахад анхаарснаар хөрөнгө оруулалтын өгөөжийг сайжруулах боломжтой юм.

2.1.3 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, стратегийг тодорхойлж буй аргачлал

Монгол Улсын Сангийн яамнаас жил бүр төсвийн хөрөнгө оруулалт хийх салбарын холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ болох жилийн төсвийн хязгаарыг тогтоож өгдөг. Төсвийн ерөнхийлөн захирагчид нь тус хязгаарын хүрээнд төсвийг зарцуулах эрхтэй байдаг байна.

Жилийн төсвийн хязгаарыг тогтоохдоо Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дах заалтыг баримталдаг байна. Тодруулбал, Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилан дараах цаглаврын дагуу хязгаарыг боловсруулж, баталдаг. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч нар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10–ны дотор хүргүүлэх;
2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 6 дугаар сарын 20–ны дотор Засгийн газарт хүргүүлэх;
3. Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 1–ний дотор батлах;
4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5–ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Ингэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх жилийн төсвийн хязгаар нь тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1–т “Төсвийн хязгаарыг урсгал болон хөрөнгийн зардлаар тогтоосон байх”, 27.2.2–т “Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах” гэсэн шаардлагуудыг хангасан байх хэмээн тусгасан байна. Гэвч, 1 болон 2 дугаар алхамд хэрэгжүүлэх тусгай аргачлал, баримтлах стратеги нь олон нийтэд ил тод бус, тодорхойгүй байгаа нь төсвийн хязгаарыг тогтоох үйл явцад илүү нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангахад саад учруулж байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийн зарчмыг сайжруулах, иргэдийн оролцоо, хяналтыг дэмжих үүднээс тодорхой болгож, илүү ил тод, ойлгомжтой болгох шаардлагатайг харуулж байна.

2.2 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл

Дэлхийн банкны “Төрийн хөрөнгө оруулалтын удирдлагын загвар” баримт бичигт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зорилго бол эдийн засгийн өсөлт, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийн амьдралыг сайжруулах явдал юм” хэмээн тодорхойлсон байна. Олон улсын чиг хандлагаар төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн гол зорилго нь дараах зүйлсийг хангахад чиглэсэн байдаг:

1. *Нийтийн ашиг сонирхлыг хангах.* Боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг нийгмийн салбаруудыг хөгжүүлж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах;
2. *Эдийн засгийн өсөлтийг дэмжих.* Үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийж, ажлын байр нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх;
3. *Тэгш хүртээмжтэй хөгжил бий болгох.* Хот хөдөөгийн ялгааг багасгах, бүс нутгийн хөгжлийг жигд хангах.

4. Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. Иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж, чанартай, хүртээмжтэй болгох (жишээ нь: сургууль, эмнэлэг, зам гүүр барих).
5. Байгаль орчин, тогтвортой хөгжлийг дэмжих. Ногоон хөгжил, байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлд дэмжлэг үзүүлэх.

Монгол Улсын хувьд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7–д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”, 27 дугаар зүйлийн 27.1.3–т төсвийн төслийг боловсруулахад “төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх” шаардлагыг хангасан байхыг шаардсан байна. Үүнээс харахад төсвийн хөрөнгө оруулалт нь стратегийн ач холбогдолтой, урт хугацааны үр ашиг бүхий төсөл байх ёстой бөгөөд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байхыг хуульчилж өгсөн байна.

Монгол Улс алсын хараагаа 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэх орнуудын нэг болох хэмээн тодорхойлж, түүнд хүрэх урт хугацааны хөгжлийн бодлогыг 2020 онд баталсан. Монгол Улсын 2020–2024 онд эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн салбар бүрд тусгасан төслүүдийн нийт төсөвт өртгийг харахад нийт төсвийн 22.4 хувь нь зам тээвэр, 17.9 хувь нь боловсролын салбарт, 15.4 хувь нь нийтийн эзэмшил, дэд бүтэц, 9.2 хувь нь соёл, урлагийн салбарт, 7.6 хувь нь бүтээн байгуулалтад, 6.9 хувь нь эрүүл мэндийн салбарт тус тус хөрөнгө оруулахаар төлөвлөсөн байна. 2020–2024 оны хооронд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбар бүрд хэрэгжүүлж эхэлсэн нийт төслийн төсөвт өртгийн дүнг эдийн засгийн ангилал бүрээр доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар салбар бүрд 2020–2024 онд эхэлсэн төслүүдэд төсөвлөсөн санхүүжилтийн нийт дүн, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр

№	Салбарууд	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Их засвар	ТЭЗҮ	Нийт
		1	2	3	4	
1	Зам, тээвэр	2,585,185	–	56,977	131,210	2,773,371
2	Боловсрол	1,998,497	173,000	36,648	6,200	2,214,345
3	Нийтийн эзэмшил, дэд бүтэц	1,372,811	378,987	92,518	59,804	1,904,120
4	Соёл, урлаг	1,005,351	97,239	23,691	6,942	1,133,223
5	Бүтээн байгуулалт	714,830	19,265	–	205,000	939,095
6	Эрүүл мэнд	577,846	230,263	45,333	–	853,442
7	Захиргааны байгууламж	771,003	24,052	5,148	–	800,203
8	Эрчим хүч	459,219	5,520	241	79	465,059
9	ХАА, цаг уур	124,406	110,124	5,000	250	239,780
10	Батлан хамгаалах	64,868	108,877	19,140	–	192,885
11	Хяналтын байгууллага	106,365	53,875	15,742	–	175,983
12	Хууль сахиулах	85,699	67,890	12,470	–	166,059

№	Салбарууд	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Их засвар	ТЭЗҮ	Нийт
		1	2	3	4	
14	Төрийн захиргааны байгууллагууд	71,824	68,290	5,210	–	145,324
15	Аялал жуулчлал	75,729	–	1,800	1,908	79,437
16	Хэвлэл, интернэт сүлжээ	49,795	17,662	500	–	67,957
17	Онцгой байдлын алба	26,251	17,850	–	–	44,101
18	Гадаад харилцаа	4,424	13,049	14,400	–	31,873

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд эхэлсэн төслүүдийг гол зорилгоор нь ангилан харвал нийт төслийн 66.4 хувь нь нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна. Нийтийн ашиг сонирхлыг хангах буюу боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг нийгмийн салбаруудыг хөгжүүлж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зорилгын хүрээнд Монгол Улсын иргэдийн амьдралын чанарын нөхцөл байдлыг дэлгэрэнгүй авч үзье.

Монгол Улсын иргэдийн амьдралын чанарын индексийг Numbeo сайтаас 2025 оны 6–р сарын 3–ны өдрийн байдлаар гаргасан ба энэ үзүүлэлт авбал зохих 240 онооноос 68.67 буюу “Маш бага”⁸ гэсэн зэрэглэлд орсон байна. Тус индексийг үзүүлэлт тус бүрээр задлан доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 12. Монгол Улсын амьдралын чанарын индекс, 2025 он

№	Үзүүлэлт	Үр дүн	Зэрэглэл
1	Худалдан авах чадварын индекс	39.55	Маш бага
2	Аюулгүй байдлын индекс	48.28	Дундаж
3	Эрүүл мэндийн индекс	51.63	Дундаж
4	Амьдралын өртгийн индекс	30.39	Маш бага
5	Байгалийн уур амьсгалын индекс	–3.54	Бага
6	Хүрээлэн буй бохирдлын индекс	87.93	Маш өндөр
7	Зогсоол, хөдөлгөөн, түгжрэлийн индекс	30.79	Бага
8	ҮХХ–ийн үнэ орлогын харьцаа	13.72	Өндөр
Амьдралын чанарын индекс		68.67	Маш бага

Эх сурвалж: (Numbeo, 2025)

Амьдралын чанарын индексийн найман үндсэн үзүүлэлтийг харьцуулан үзэхэд, Монгол Улсын хувьд “амьдрах өртөг” харьцангуй бага үзүүлэлттэй гарсан нь эерэг тал боловч, тухайн өртгийг давах чадварыг илэрхийлдэг “худалдан авах чадвар” маш бага түвшинд байгаагаас бодит амьдралын нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна. Хэдийгээр аюулгүй байдал болон эрүүл мэндийн

8 https://www.numbeo.com/quality-of-life/country_result.jsp?country=Mongolia

үзүүлэлтүүд дунд зэргийн түвшинд үнэлэгдэж байгаа ч сүүлийн таван жилийн хугацаанд гэмт хэргийн тоо тасралтгүй өссөн, авлига, хээл хахуулийн тархалт өндөр түвшинд хэвээр байгаа нь аюулгүй байдлын индексийг бууруулах хүчин зүйлс болж байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд эмч мэргэжилтнүүдийн ур чадвар, сургалтын чанар, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүртээмж дунд түвшинд хадгалагдаж байгаа хэдий ч, эмнэлгийн байгууллагуудын хариу өгөх хугацаа удаан, иргэдийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж доогуур байгаагаас эрүүл мэндийн салбарын үр нөлөө хязгаарлагдмал байна. Харин байгаль орчны нөхцөл байдлын тухайд, Монгол Улс амьдрахад хүндрэлтэй уур амьсгалтай орны ангилалд багтаж байгаа бөгөөд хүйтэн, хуурай, улирлын эрс тэс уур амьсгал нь иргэдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна. Үүний зэрэгцээ агаар, хөрс, усны бохирдол өндөр түвшинд байгаа нь хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлж, амьдралын чанарт ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна.

Мөн иргэдийн орон сууц худалдан авах чадвар маш хязгаарлагдмал байгааг тус индексийн дүн харуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар дундаж иргэн нийт орлогынхоо 13.72 жилийн хуримтлалтай тэнцэх хэмжээний үнэтэй үл хөдлөх хөрөнгө худалдан авах боломжтой байгаа нь дэлхийн дунджаас хоёр дахин өндөр үзүүлэлт юм.

Засгийн газраас иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор 2020–2024 онуудад боловсролын төсөлд нийт 2.2 их наяд төгрөг, эрүүл мэндийн төсөлд 853 тэрбум төгрөг, нийтийн эзэмшил, дэд бүтэц, зэм тээврийн төслүүдэд нийт 4.7 их наяд төгрөгийг төслүүдийг хэрэгжүүлэх нийт хугацаанд олгохоор төсөвлөсөн байна. Дараах хэсэгт тус 3 салбарын нөхцөл байдлыг дэлгэрэнгүй авч үзэв.

2.2.1 Боловсролын салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онуудад Засгийн газраас мэдээлснээр нийт 157 сургууль, 242 цэцэрлэг ашиглалтад орсон бол боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээлснээр 178 сургууль, 252 цэцэрлэг ашиглалтад оруулж, сургуулийн хүчин чадлыг 81,348 суудлаар, цэцэрлэгийн хүчин чадлыг 39,695 суудлаар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 13. Боловсролын салбарт улсын төсвийн санхүүжилтээр 2020–2024 онд ашиглалтад оруулсан сургууль, цэцэрлэгийн тоо, хүчин чадал

Он	Тоо хүчин чадал	Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээлснээр		Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тайлагнаснаар	
		Сургууль	Цэцэрлэг	Сургууль	Цэцэрлэг
2020	Тоо	32	54	30	64
	Хүчин чадал, суудлын тоо	12840	7435	10800	8515
2021	Тоо	19	35	22	37
	Хүчин чадал, суудлын тоо	6260	5535	Тусгагдаагүй	Тусгагдаагүй
2022	Тоо	34	39	17	32
	Хүчин чадал, суудлын тоо	19798	7070	Тусгагдаагүй	Тусгагдаагүй

Он	Тоо хүчин чадал	Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээлснээр		Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тайлагнаснаар	
		Сургууль	Цэцэрлэг	Сургууль	Цэцэрлэг
Хүчин чадал, суудлын тоо		32850	18180	30000	10840
2024	Тоо	17	7	26	32
	Хүчин чадал, суудлын тоо	9600	1475	12820	4395
Нийт	Тоо	178	252	157	242
	Хүчин чадал, суудлын тоо	81348	39695	Тодорхойлох боломжгүй	Тодорхойлох боломжгүй

Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

Боловсролын хүртээмж, чанарын нөхцөл байдал: Монгол Улсын ерөнхий боловсрол эзэмшиж буй хүүхдүүдийн нийт ерөнхий боловсрол эзэмших насны хүүхдийн тоонд эзлэх хувь 2015–2019 оны хооронд дунджаар 83.9 хувь байсан бол 2020–2024 оны хооронд дунджаар 88.2 хувь болж өссөн байна. Хэдийгээр 88.2 хувь нь сургуульд хамрагдаж байгаа ч 10 орчим хувь нь хүртээмжгүй хэвээр байна. Цэцэрлэгийн буюу 2–5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 2018–2022 он хүртэл дунджаар 76.8 хувь байсан бол 2022 оноос хойш огцом өсөж 89.3 хувьд хүрсэн байна. Ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсролын хувьд аль аль нь хамрагдалтын түвшин нь жишиг буюу 90 хувийн түвшинд дөхөж байна.

Монгол Улсын боловсролын хүртээмж сайн түвшинд байгаа хэдий ч энэ хүртээмжийн түвшний цаана боловсролын байгууллагууд өндөр ачаалалтай ажиллаж байна. Тухайлбал, 2023 онд улсын хэмжээнд ээлжийн коэффициент 1.3 байсан бол 2024 онд 1.27 болж буурсан. Энэ нь нэг ангид хичээллэх нормоос өндөр буюу сургуулиуд 2, зарим нь 3 ээлжээр хичээллэж байгааг илтгэж байна. Энэ нь хичээлийн цаг богиносох, багшийн ачаалал ихэссэнээс болж сургалтын чанар буурах, сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөг үзүүлэх эрсдэл нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, үдээс хойш хичээллэх сурагчдын хувьд ядрах, анхаарал төвлөрөл буурах магадлал өсдөг ба өглөө эрт болон орой харанхуйд сургуульдаа ирж очих, ялангуяа өвлийн улиралд бэртэж гэмтэх эрсдэл нэмэгддэг.

Харин хүн амын боловсролын түвшний индекс нь 2010 онд 0.93–аас 2011 онд 0.72 болж огцом унаснаас хойш дунджаар 0.727 байсан бол 2020–2024 оны хооронд дунджаар 0.758 болж өссөн байна. Улсын хэмжээнд боловсролын түвшин өсөж байгаа хэдий ч Улаанбаатар хотод 2023 болон 2024 онуудад боловсролын түвшний индекс 0.89–өөс 0.81 болон 0.80 болж огцом буурч, харин орон нутагт дурдсан хугацаанд дунджаар 0.0738–аар өссөн байна.

Боловсролын хүртээмж дунджаар 2024 онд 89.9 хувь байхад боловсролын түвшний индекс нь 0.76 байгаа нь боловсролын чанар хангалтгүй байгааг илтгэж байна. Үүнд (1) багш, ажилтны хүртээмж жил ирэх тусам буурч байгаа буюу ерөнхий боловсролын сурагч, багшийн харьцаа 2015 онд 18.8 буюу 1 багшид 18.8 хүүхэд ногддог байсан бол энэ тоо 2024 онд 21.1 болж, нэг багшид ирэх ачаалал илүү нэмэгдсэн, (2) сургуулийн дэд бүтэц буюу тоног төхөөрөмжийн дутагдал хэвээр байгаа буюу Боловсролын яамнаас 2017 онд сургуулиудын 86.5 хувь нь хамгийн багадаа 2mb/s интернэтийн үйлчилгээнд холбогдсон ба сурагч-компьютерын харьцаа 1:12.5, багш-компьютерын харьцаа 1:1.6 хэмээн мэдэгдэж байсан бол 2021 онд ЮНЕСКО–гийн боловсролын бодлогын тойм

тайланд эдгээр сургуулиудын холболтын 40 хувь нь эвдэрсэн бөгөөд үлдсэн сургуулийн холболтын чанар нь GIGA-с тогтоосон стандартаас хамаагүй доогуур байгааг онцолсон, мөн (3) 2019 онд БШУЯ-ны түүвэр шалгалтын үр дүнд бага ангийн сурагчдын математикийн хичээлийн чадвар 53.5 хувь байсан бол 2021 онд 38.2 хувь болж буурсан ба энэ нь цар тахлын үед сургалтын чанар огцом буурсантай холбоотой буюу “Бүх нийт боловсролын төлөө” ТББ-ын 2021 оны судалгаанд дурдсанчлан багш нарын 75.2 хувь нь зайны сургалт явуулах, сурган хүмүүжүүлэх зааварчилгааг огт авч байгаагүй бөгөөд 20 хувь нь дижитал төхөөрөмж ашиглах чадваргүй байгаатай холбоотой байна.

Зураг 5. Боловсролын түвшний индекс болон ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж /2015–2024 он/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд боловсролын салбарт эхэлсэн төслүүдийн 90.3 хувийг барилга, 7.8 хувийг тоног төхөөрөмж, 1.7 хувийг их засвар, 0.3 хувийг ТЭЗҮ тус тус бүрдүүлж байна. Иймд зөвхөн хүртээмжид анхаарахаас гадна шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Гэвч 2030 он хүртэл бага, дунд боловсрол эзэмших хүүхдийн тоо эрчимтэй өсөж байгаа нь Монгол Улсад тулгамдаж буй асуудал болох ээлжийн коэффициентыг улам нэмэгдүүлж, цаашлаад сургалтын чанарт улам бүр сөргөөр нөлөөлөх магадлалтай байгаа тул ээлжийн коэффициент 1–ээс дээш болон шилжин ирэх чиг хандлага өндөртэй байршлуудад сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

2.2.2 Эрүүл мэндийн салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онуудад нийт 160 эмнэлэг ашиглалтад оруулсан байна. Тэдгээр төслийн үр дүнд 2020, 2023 болон 2024 онуудад эмнэлгийн орны хүчин чадал 13,398–аар нэмэгдсэн бол 2021, 2022 онуудад хэдий хэмжээний хүчин чадал нэмэгдсэн талаар нээлттэй мэдээлэл байхгүй байна.


Хүснэгт 14. Эрүүл мэндийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд ашиглалтад оруулсан эмнэлгийн тоо, хүчин чадал

Он	Тоо, хүчин чадал	Эмнэлгийн тоо
2020	Тоо	24
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	645
2021	Тоо	16
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	Тусгагдаагүй
2022	Тоо	19
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	Тусгагдаагүй
2023	Тоо	77
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	10840
2024	Тоо	24
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	1913
Нийт	Тоо	160
	Хүчин чадал, эмнэлгийн орны тоо	Тодорхойлох боломжгүй

Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарын нөхцөл байдал: Эрүүл мэндийн системийн ачаалал, орны ашиглалтын түвшин, үйлчилгээний чанарыг орны эргэлт буюу жилд хэвтэн эмчлүүлсэн нийт хүний тоог нийт ашиглагдаж буй орны тоонд харьцуулан тодорхойлдог. Дэлхийн жишигт энэ харьцаа нь 15–30 хүн/ор байдаг. Энэхүү харьцаа нь Монгол Улсын хувьд сүүлийн 10 жилийн дундаж 34.22, 2024 онд 34.52 буюу 1 оронд жилд дунджаар 34.52 хүн хэвтэн эмчлүүлж байгаа буюу 1 хүн дунджаар 10.52 хоног хэвтэн эмчлүүлсэн байна. Хэдийгээр тус харьцаа нь жишиг харьцаанаас өндөр байгаа хэдий ч 2015 онтой харьцуулахад 4.5 хувиар буурсан байна.

Зураг 6. Монгол Улсын эмнэлгийн орны эргэлтийн тоо (2015–2024 он)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, судлаачдын тооцоолол

Энэ нь жишиг харьцаанаас өндөр байгаа бөгөөд эмнэлгийн систем хэт ачаалалтай, орны хүрэлцээ муу, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай хүмүүсийг хүлээлгэж буйг илтгэж байна. Орны эргэлт хэт өндөр хэвээр байх нь дараах сөрөг талуудыг бий болгож байдаг. Үүнд:

- » Ор хүрэлцэхгүй тул хүмүүс хэвтэн эмчлүүлэхийн тулд удаан хүлээх, тухайн хугацаанд өвчин улам хүндрэх;
- » Ачаалал их байгаагаас болж хэт богино хугацаанд эмчилгээ хийх шаардлага эмнэлгийн салбарт тулгарах тул өвчтөн бүрийг шаардлагатай хугацаанд нь хэвтүүлэн эмчлэх боломж багасах;
- » Эмнэлгийн ачаалал, орны хүртээмжээс шалтгаалж хангалттай хугацаанд хэвтэн эмчлүүлж бүрэн эдгэрээгүй хүн дахин эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хандлагатай байдаг нь ачааллыг улам нэмэгдүүлэх;
- » Эмнэлгийн ажилчдын хэт ачаалал, ядаргаа нь алдаа гарах эрсдэлийг нэмэгдүүлэх;
- » Нэг орыг хэт олон хүн ашиглах нь халдварын эрсдэлийг нэмэгдүүлэх.

Мөн өөр нэгэн чухал үзүүлэлт болох дундаж наслалтын үзүүлэлтийг авч үзэхэд, Монгол Улсын хүн амын дундаж наслалт жилд дунджаар 0.3 хувиар өсөж, 2024 оны байдлаар 71.77 байна. Хүн амын дундаж наслалт тогтвортой өсөх нь эрүүл мэндийн тогтолцоо болон амьдралын чанар тогтвортой сайжирч байгааг илтгэж байна. Монгол Улсын хүн амын дундаж наслалт нь дэлхийн дундажтай ойролцоо боловч 1.6 жилээр доогуур, Төв Азийн орнуудтай ижил түвшинд, харин хөгжингүй орнуудтай харьцуулахад 10–12 жилээр бага байна.

Зураг 7. Монгол Улсын хүн амын дундаж наслалт, хүйсээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020–2024 онд нийт эрүүл мэндийн салбарын улсын төсвийн хөрөнгийн оруулалтын төсөвт өртгийн 67.7 хувийг барилгын төсөл, 27 хувийг тоног төхөөрөмжийн төсөл, 5.3 хувийг их засварын төсөл эзэлж байна. Эрүүл мэндийн салбарын хүртээмж болон чанар бага боловч сайжирсаар байгаа хэдий ч Монгол Улс дахь эрүүл мэндийн хүртээмж, чанар хангалтгүй хэвээр байна.

2.2.3 Дэд бүтцийн салбар дахь улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онуудад инженерийн дэд бүтцийн нийт 266 төсөл, цахилгаан, дулаан хангамжийн 123 төсөл хэрэгжүүлсэн байна. Зам, гүүрний 2020, 2023 болон 2024 онуудад ашиглалтад орсон төслүүд 2,694 км-ийн хүчин чадал нэмсэн бол 2021, 2022 онуудад хэдий хэмжээний хүчин чадал нэмэгдсэн талаар нээлттэй мэдээлэл байхгүй байна.

Хүснэгт 15. Дэд бүтэц, зам гүүр, эрчим хүчний салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд ашиглалтад оруулсан байгууламжийн тоо, хүчин чадал

Он	Тоо, хүчин чадал	Инженерийн дэд бүтэц	Зам, гүүр	Цахилгаан, дулаан хангамж
2020	Тоо	59	Тусгагдаагүй	12
	Хүчин чадал	–	815 км	–
2021	Тоо	34	44	4
	Хүчин чадал	–	Тусгагдаагүй	–
2022	Тоо	80	41	16
	Хүчин чадал	–	Тусгагдаагүй	–
2023	Тоо	61	82	15
	Хүчин чадал	–	1684 км	–
2024	Тоо	32	26	76
	Хүчин чадал	–	195 км	–
Нийт	Тоо	266	Тодорхойлох боломжгүй	123
	Хүчин чадал	–	Тодорхойлох боломжгүй	–

Эх сурвалж: (Монгол Улсын Засгийн газар, 2025)

Инженерийн дэд бүтцийн нөхцөл байдал: Инженерийн дэд бүтэц гэдэг нь улс орны хот, суурин газрын нутаг дэвсгэрт баригдсан инженерийн шугам сүлжээ, байгууламжийн цогц систем юм. Үүнд, ус, эрчим хүч, дулаан, зам тээвэр, холбоо, бохир, хог хаягдлын менежмент, мэдээллийн технологи, нийтийн үйлчилгээний систем багтдаг. Нийтийн эзэмшил, дэд бүтэц, зам тээврийн хүрээн дэх төслүүдэд Монгол Улсын төсвийн хүрээнд 2020–2024 онуудад нийт 4.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөсөн. Тэдгээрээс 84.6 хувь нь барилгын, 8.1 хувь нь тоног төхөөрөмжийн, 3.2 хувь нь их засварын, 4.1 хувь нь ТЭЗҮ байна.

Монгол Улсын хувьд зам, тээврийн салбарт илүү төвлөрч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020–2024 онд эхэлсэн төслүүдэд 2.8 их наяд төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь нийт төсвийн хөрөнгө оруулалтын 22.7 хувийг эзэлж байна. Монгол Улсын нийт замын сүлжээ 113,200 орчим км-ийн урттай, үүний ердөө 9 хувь орчим буюу 10,800 км нь хатуу хучилттай байна. Улаанбаатар хотод 2024 оны байдлаар хатуу хучилттай зам 1253 км, түүнээс зөвхөн 16 хувьд нь бохирын ус зайлуулах систем суурилуулсан байна.

Дэлхийн банкнаас гаргадаг улс орны логиستيкийн системийн чанар, үр ашиг, хүртээмж зэргийг 6 үндсэн шалгуураар үнэлдэг LPI (Logistics Performance Index) нь Европын холбооны тэргүүлэгч

орнуудын хувьд дунджаар 4.0–4.3 хооронд байдаг бол Монгол Улсын хувьд хамгийн сүүлд нээлттэй мэдээлснээр 2023 онд 2.5 байсан байна. Тус 6 үндсэн шалгуурын үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Зураг 8. Монгол Улсын тээврийн гүйцэтгэлийн индекс, 2023 он



Эх сурвалж: (Дэлхийн банк, 2023)

Цаг хугацаанд бараа хүргэх чадвар 3.2 байгаа нь харьцангуй сайн бөгөөд дотоод логистикийн зарим механизм хэвийн ажиллаж байгааг илтгэж байна. Гэвч тус үзүүлэлтээс бусад үзүүлэлт нь Монгол Улсын тээврийн хүртээмж, чанар сул байгааг илтгэж байна. Дэд бүтцийн чанар 2.2, гаалийн үр ашиг 2.1 байгаа нь замын чанар муу, боомт, хилийн дэд бүтэц хангалтгүй, гаалийн бүрдүүлэлт удаан, ил тод бус, автоматжуулалт сул зэрэг асуудлуудтай холбоотой.

2025 онд хийгдсэн “Монгол Улсын дэд бүтцийн хөгжил: Ахиц дэвшил, сорилт, хэтийн төлөв”⁹ судалгаанд “Хүн амын 10 гаруй хувь нь цахилгаан эрчим хүчгүй, 25 хүрэхгүй хувь нь төвийн дулаанаар хангагдаж байна. Мөн тус улс цахилгаан эрчим хүчний хангамжийн хэлбэлзэлд өртөмтгий хэвээр байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн цахилгаан тасалдахад хүргэдэг”, мөн “Замыг өргөтгөхөд ихээхэн хүчин чармайлт гаргасан ч замын чанар муу, засвар үйлчилгээ хангалтгүй байгаа нь анхаарал татсан асуудал хэвээр байна. Алслагдсан бүс нутгийн дэд бүтэц хоцрогдсон хэвээр байгаа нь хөдөөгийн хүн амын эдийн засгийн боломжийг хязгаарлаж байна” хэмээн дүгнэсэн байна.

2.3 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх арга зүй

2.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөлд тавигдах шаардлага, төслийг үнэлэх, төлөвлөх аргачлал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах төсөл нь хөгжлийн бодлогын баримт бичиг, стратегийн бодлого, чиглэлийн шаардлагад нийцсэн байх шаардлагатай бөгөөд үүнээс гадна эдийн засгийн ангиллын хувьд Хүснэгт 15–д заасны дагуу ялгаатай тусгай шаардлагуудыг хангасан байх ёстой.

9 “Рояль” ОУИС–ийн Архитектурын тэнхимийн эрхлэгч Д.Золзаяа, “Рояль” ОУИС–ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн багш Jay Ryan R. Fantonalgo, CPA нар, 2025, “Монгол Улсын дэд бүтцийн хөгжил: Ахиц дэвшил, сорилт, хэтийн төлөв”

Хүснэгт 16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд тавигдах тусгай шаардлагууд

№	Эдийн засгийн ангилал	Тавигдах шаардлага
1	Шинээр эхлэх барилга байгууламж	Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу төслийн шинжилгээг хийгдсэн байх;
		Газрын байршил шийдвэрлэсэн байх;
		Хэрэв газаргүй бол тухайн санхүүгийн жилд багтан шийдвэрлэх тооцоолол үндэслэлтэй байх;
		Техникийн нөхцөлтэй байх;
		Магадлал хийгдсэн зураг төсөлтэй байх;
2	Их засвар	Батлагдсан зураг төсөвтэй байх;
		Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;
		Барилга байгууламжийн насжилт, ашиглалтын норм, хугацаа, элэгдлийг тооцоолсон байх;
3	Тоног төхөөрөмж	Техник, тоног төхөөрөмж худалдан авах эрэлт хэрэгцээг тодорхойлсон судалгаатай байх;
		Техник, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг гаргасан байх;
		Үр ашгийн тооцоо болон ашиглалтын үеийн зардлын тооцоолол хийгдсэн байх;
4	ТЭЗҮ	Зураг төсөв, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ нь газрын байршил шийдвэрлэсэн, газар чөлөөлөх шаардлагатай бол нөхөн олговрын зардлыг шийдвэрлэсэн байх;
		Инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын хувьд трасс тодорхойлж, холбогдох газруудтай зөвшилцсөн байх;
		Инженерийн шугам сүлжээний анхан шатны судалгаатай байх.

Эх сурвалж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх үйл ажиллагааны журам

Мөн төслийн онцлогоос хамааран ТЭЗҮ-ийн тооцоо, судалгаа, Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу төслийн шинжилгээг бүрэн хийсэн байх, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулсан байх гэсэн шаардлагуудыг хангасан байх ёстой.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслийг үнэлэх, төлөвлөх аргачлал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслийг үнэлэх, төлөвлөлт хийж төсөвт тусгахтай холбоотой дараах үндсэн хоёр журмыг мөрдөж байна.

1. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”
2. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”

Журам 1. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”–ын зорилго нь УТХО–аар хэрэгжүүлж буй болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлсний үндсэн дээр улсын төсөвт тусгах шийдвэр гаргах, төсвийн зардлыг бууруулах, төсвийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгоход оршино. Тус журамд гурван аргачлалыг тусгасан байна.

Зураг 9. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд” журамд тусгагдсан аргачлалууд




Аргачлал 1. УТХО–аар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал.

Улсын төсвөөр хэрэгжиж байгаа бүх шилжих төслүүдийг үнэлж, эрэмбэлснээр, ирэх жилийн төсөвт суулган үргэлжлүүлэх, тохируулга хийх эсвэл төслийг зогсоох зэрэг шийдвэрийг гаргадаг. Төслийг дахин үнэлэх үйл ажиллагаа нь (1) Төслийг ангилах, (2) Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, (3) Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх гэсэн гурван үе шаттай хийгдэнэ.

ТЕЗ нь дахин үнэлэхэд шаардлагатай төслийг Зураг 11–т тусгасан 3 шалгуур үзүүлэлтээр “хэвийн буюу үргэлжлүүлэх” болон “эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай” гэж хоёр ангилдаг. Хэрэв тус гурван шалгуур үзүүлэлтийн аль нэгт багтсан бол “эргэлзээтэй буюу дахин үнэлэх” шаардлагатай төслийн ангилалд орох бөгөөд төслийг цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, дараах онцгой нөхцөл үүссэн тохиолдолд төсөвт тусгах санал гаргаж, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан төслийг шинэчлэн хэрэгжүүлэх, хойшлуулах, эсвэл зогсоох шийдвэрийг гаргаж болно. Үүнд:

1. Олон улсын гэрээгээр болон бусад гэрээгээр зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төсөл;
2. Төслийн ажлын гүйцэтгэл 80–аас дээш хувьтай;
3. Төслийн санхүүжилтийн гүйцэтгэл 80–аас дээш хувьтай тохиолдлууд хамаарна.

Зураг 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийн дахин үнэлэх аргачлал




Аргачлал 2. УТХО-аар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал

Шинээр хэрэгжүүлэх бүх төрлийн төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцооллыг Аргачлал 2-ын дагуу заавал гүйцэтгэх шаардлагатай. Ингэхдээ төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг зардал-үр ашгийн шинжилгээ /бүрэн болон хялбаршуулсан/ болон

хамгийн бага зардлын шинжилгээний аргыг ашиглан Зураг 12-т тусгасны дагуу төсөвт өртгөөс хамааран тооцно.

Зураг 11. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал



Дээрх аргачлалаар үнэлгээ хийсний дараа төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэж, оноо өгөхөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Зардал-үр ашгийн шинжилгээ хийгдсэн төслүүдийн хувьд Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон үр дүнгийн үзүүлэлтүүдийг үндэслэх;
2. Зардал-үр дүнгийн болон хамгийн бага зардлын шинжилгээ хийгдсэн төслүүдийн хувьд сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй төслүүдтэй харьцуулах.

Ийнхүү тооцсон төслийн эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой болохыг тодорхойлж, баталгаажуулсан баримт бичиг, шийдвэр нь тухайн төсөл хэрэгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлсний дараа хийгдэх хүчин чадлын ашиглалтыг шалгаж дүгнэхэд баримтлах үндсэн баримт бичиг болно.

Аргачлал 3. УТХО–аар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал

Уг аргачлалыг төслийг үнэлэх болон сонгоход ашиглана. Аргачлалын нэгдүгээр үе шатанд Хүснэгт 16–д тусгасны дагуу 7 шалгуур үзүүлэлтээр “хэрэгцээ шаардлага”–д оноо өгч үнэлдэг бол хоёрдугаар шатанд Хүснэгт 17–д заасны дагуу 9 шалгуур үзүүлэлтээр “бэлэн байдал”–д оноо өгч сонгоход ашиглана.

Хүснэгт 17. УТХО–аар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх нэгдүгээр үе шат

№	Шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо				
		1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан	Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан	Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан	Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэртэй нийцсэн	Салбарын хөгжлийн бодлогод онцгойлон тусгагдсан
2	Бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эсэх	Салбар дундын хөгжлийн тэнцвэрийг хангах ач холбогдолтой	Бусад төслийн хэрэгжилтийн бэлтгэх болно	Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө	Хэрэгжиж байгаа бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд шууд нөлөөлнө	Онц чухал төслийн хэрэгжилтэд шууд нөлөөлнө
3	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол	Ач холбогдох тодорхой бус	Ач холбогдол хязгаарлагдмал	Ач холбогдол дунд зэрэг	Ач холбогдол өндөр	Ач холбогдол маш өндөр
4	Төслийн хүчин чадлын ашиглалт	5 дахь жилээс хойш	4 дэх жилдээ	3 дахь жилдээ	2 дахь жилдээ	Эхний жилдээ
5	Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх	Төслийн өртгийг 2–оос дээш жилийн өмнө тооцсон	Барилга байгууламжийн төсөвт өртөг тооцогдсон	Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга байгууламжийн төсөвт өртөг тооцогдсон	Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өртөг тооцогдсон	Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга, байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, урсгал зардал тооцогдсон
6	Төслийн болзошгүй эрсдэл	Тодорхой бус	Төслийн зорилт төдийлөн тодорхой бус, үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал өндөр	Төслийн зорилт нь зарим байдлаар тодорхой ч хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлалтай	Төслийн зорилт нь тодорхой хэдий ч хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал тодорхой хэмжээгээр байгаа	Төслийн зорилт нь маш тодорхой бөгөөд, хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал тун бага

№	Шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо				
		1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо
7	Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	Мэргэжилтэй боловсон хүчин тусгайлан бэлтгэнэ	Гадаадаас мэргэжилтэн урьж ажиллуулна	Ажлын байранд дадлагажуулна	Мэргэжлийн ажиллагсад зах зээлд олдоцтой	Ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан мэргэжилтэй боловсон хүчин бэлэн.

Хүснэгт 18. УТХО-аар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх хоёрдугаар үе шат

№	Шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо				
		1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ерөнхий байдлаар тусгагдсан	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой тусгагдсан	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-оос дээш заалтыг хангана	ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан
2	Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд нийцэж буй байдал	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд тусгагдаагүй	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлтэй шинж чанартай хувьд нийцэж буй	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлтэй нийцэж буй	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа тэргүүлэх ач холбогдолтой	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан
3	Тухайн жилийн үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал	Үндсэн чиглэлд тусгагдаагүй	Үндсэн чиглэлд ерөнхий байдлаар тусгагдсан	Үндсэн чиглэлд тодорхой тусгагдсан	Үндсэн чиглэлийн 2-оос дээш чиглэлийг хангана	Үндсэн чиглэлд тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан
4	Төслийн зардлыг бүрэн, зөв тооцсон эсэх	Нэг маягийн зураг төсөв, жишиг үнэлгээгээр тооцоолсон	Төслийн зардалд тодорхой ажлууд дутуу тооцогдсон	Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20-оос дээш хувиар зөрүүтэй	Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20 хүртэл хувиар зөрүүтэй	Төслийн зардал өнөөгийн үнээр бүрэн тооцогдсон
5	Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	Хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс 100% санхүүжүүлнэ	Бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудал хэлэлцээрийн шатанд байна	Хөрөнгө оруулалтын зардлын 25 хүртэл хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан	Хөрөнгө оруулалтын зардлын 50-аас дээш хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан	Хөрөнгө оруулалтын зардлыг 75-аас дээш хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан

№	Шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо				
		1 оноо	2 оноо	3 оноо	4 оноо	5 оноо
6	Урсгал зардлыг тогтвортой санхүүжүүлэх боломжтой эсэх, төсөвт үзүүлэх ачаалал	Урсгал зардал нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгагдаагүй	Урсгал зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгагдсан	Урсгал зардлын 60 хүртэлх хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгагдсан	Урсгал зардлын 30 хүртэлх хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгасан	Урсгал зардлыг өөрийн орлогоор тогтвортой санхүүжүүлэх боломжтой
7	Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй	Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл өндөр	Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл дунд зэрэг	Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл бага	Эрсдэлийн хүчин зүйлийг хянаж зохицуулах боломжтой
8	Төсөл хэрэгжүүлэх бусад нөхцөл бүрдсэн эсэх	Нэмэлт үйл ажиллагаа, зохицуулалт шаардлагатай	Зарим бэлтгэл үйл ажиллагаа дутуу боловч хэрэгжүүлэх явцад тэдгээр нөхцөлүүдийг бүрдүүлэх боломжтой	Шаардлагатай үндэслэл, зөвшөөрөл зэргийн тодорхой хэсэг нь хангалттай бус боловч, хэрэгжүүлж эхлэхийн өмнө бүрэн хангах боломжтой	Үлдсэн 1–2 асуудал шийдвэрлэгдэх шатандаа байгаа	Төслийг хэрэгжүүлж эхлэх бэлтгэл бүрэн хангагдсан
9	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрэмбэлсэн байдал	Хойшлуулж болох	Шаардлагатай	Чухал ач холбогдолтой	Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэртэй	Нэн чухал ач холбогдолтой

Ийнхүү төслийг үнэлэх нэгдүгээр үе шатанд өгөгдсөн нийт оноо болон төслийг эрэмбэлэх, сонгох хоёрдугаар үе шатанд өгөгдсөн нийт онооны нийлбэрээр тухайн төслийн эцсийн оноо тодорхойлогдоно. Нийлбэр оноогоор хамгийн өндөр үнэлгээ авсан төслийг эхний ээлжид хэрэгжүүлэхээр төсвийн хязгаарт багтаан сонгох бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн (гал түймэр, газар хөдлөлт, осол гарсан зэрэг) улмаас УИХ болон Засгийн газраас зайлшгүй хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан төслүүд, нягт уялдаа холбоо бүхий иж бүрнээр нь ашиглалтад оруулах төслүүдийн хувьд дараалал тогтоохгүйгээр хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Журам 2. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”–ын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон санхүүжилтийн удирдлагыг боловсронгуй болгох замаар төсвийн зардлыг бууруулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

Журмын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, тавигдах шаардлагын тухай заалтууд өмнөх журмын агуулгатай давхардах шинжтэй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих талаар дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Санхүүжилт: Санхүүжилтийг олгоходоо баримт бичгийн бүрдлийг 100 хувь хангасан байх шаардлагатай бөгөөд дутуу тохиолдолд буцаах, цахим системээр санхүүжилтийн хүсэлтийг шийдвэрлүүлэх, цахим системд хуурамч бичиг баримт бүрдүүлэн өгөхөөс сэргийлэх зэрэг бүхий л асуудлуудыг тодорхойлж журамласан байна.

УТХО-аар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийг олгох дээрх зохицуулалтаас гадна хөтөлбөрийн ангиллаас хамаарч дараах шаардлагууд бий болдог.

Зураг 12. УТХО-ын хөтөлбөрүүдийн санхүүжилт олгох зохицуулалт

УТХО-ын хөтөлбөрүүдийн санхүүжилт олгох зохицуулалт

Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт

- Барилга байгууламжийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэх, хэрэгжилт нь Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байх;
- ТЭЗҮ, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг хангасан байх;
- Журмын хавсралтын дагуу санхүүжилтийн хүсэлтийг гаргах;
- Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаанд Барилгын тухай хуулийн 14.6–д, авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4–т заасан хугацааг тус тус баримтлах бөгөөд баталгаат хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна.

Их засвар болон тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжилт

- Захиалагч нь их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг холбогдох маягтын дагуу мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргах бөгөөд их засварын ажлын зураг төсөв нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байх;
- Захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна;
- Их засварын ажлыг хийж дуусаад улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана;
- Захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, холбогдох маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

Зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээний санхүүжилт

- ТЭЗҮС-ны хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, зорилт, хүрэх үр дүн, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг урьдчилсан байдлаар тоймлон судлах, хэрэгжих боломжийг тоймлон тогтоох судалгааны ажил болон холбогдох тайланг боловсруулах;
- ТЭЗҮ боловсруулах ажилд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэлт хэрэгцээ, нөөц боломж, техник-технологи, эдийн засаг, хууль, эрх зүй, үйл ажиллагаа болон цаг хугацааны хувьд хэрэгжих боломжийг судлан тогтоох, тухайн төслийн үр дүн болон үр ашгийг тодорхойлох, гарч болзошгүй эрсдэл, зардлуудыг тодорхойлох судалгааны ажил болон холбогдох тайланг бэлтгэх;
- Зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийг тооцоходоо хүний нөөцийн мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна.

Хяналт: УТХО–аар хэрэгжүүлж буй төслүүдийн явцад тавих хяналтыг захиалагч, түүнийг хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага хэрэгжүүлэх бөгөөд барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлэх ёстой байдаг. Мөн гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4–т заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

Мөн төслийн явцад Сангийн яамны зүгээс төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээний ажилд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч болно. Мөн энэхүү шалгалт хийхдээ хяналт, шалгалтын мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж болох зохицуулалттай байна.

Ашиглалт, түүний өгөөжийг тооцох: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн, ашиглалт, түүний үр өгөөжид үнэлгээ өгөх үйл ажиллагааг Сангийн яамнаас улсын хэмжээнд түүвэрчлэн зохион байгуулна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, түүний үр өгөөжийг тооцох үнэлгээ хийх удирдамжийг Сангийн яамнаас тухай бүр ТЕЗ нарт хүргүүлдэг. Ингэхдээ цахим системийг ашиглан хэрэгжүүлнэ. Ашиглалт, түүний үр өгөөжийг тооцох үнэлгээнд үндэслэн гарах зөвлөмж, цаашид авах арга хэмжээний саналыг Сангийн яам тухай бүр Засгийн газарт танилцуулах бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллана.

2.3.2 Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлэх олон улсын аргачлалууд

Олон улсын туршлагаас үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, үр ашигтай хэрэгжүүлж буй улс орнууд цөөнгүй байна. Ийм туршлагыг үнэлэх, харьцуулан дүгнэх зорилгоор олон улсын нэр хүндтэй байгууллагууд тодорхой үзүүлэлт, индексүүдийг боловсруулан ашигладаг. Тухайлбал, Олон улсын валютын сан (ОУВС)–гаас “Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн индекс”/Public Investment Efficiency Index/, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ” /Public Investment Management Assessment/–г, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ОЕС–D)–аас “Дэд бүтцийн засаглалын тойм” /Infrastructure Governance Reviews/–ыг, мөн Олон улсын дэд бүтцийн төв /Global Infrastructure Hub/–өөс “Дэд бүтцийн луужин” /InfraCompass/ үзүүлэлтийг тус тус боловсруулан ашиглаж байна. Эдгээр индекс нь улс орнуудын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, засаглалын чанар зэрэг үзүүлэлтүүдийг олон улсын түвшинд харьцуулж үнэлэх боломж олгодог.

Хүснэгт 19. Олон улсын байгууллагуудаас гаргасан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлдэг индексүүд

Индекс/Үзүүлэлт	Тэргүүлэгч орнууд	Тайлбар
Public Investment Efficiency Index (ОУВС)	Чили, Канад, Нидерланд, Сингапур, Финланд	Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг буюу гарц (infrastructure outcome)–ыг хэмждэг нийлмэл индекс.

Индекс/Үзүүлэлт	Тэргүүлэгч орнууд	Тайлбар
Public Investment Management Assessment (OYBC)	БНСУ, Чили, Гүрж, Нидерланд	Хөрөнгө оруулалтын системийн төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжилтийг 15 шалгуураар үнэлдэг.
Infrastructure Governance Review (OECD)	Финланд, Нидерланд, Норвеги	Төсөл сонгон шалгаруулалт, шийдвэр гаргалтын ил тод байдал, институцийн засаглалыг үнэлдэг.
InfraCompass (Global Infrastructure Hub)	Сингапур, Австрали, Канад, Чили, Эстони	Хөрөнгө оруулалтын орчныг 8 чиглэлийн дагуу үнэлдэг.

Эх сурвалж: IMF, OECD, Global Infrastructure Hub

Дээр дурдсан олон улсын жишээнүүдэд үндэслэн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үнэлгээ, эрэмбэлэлтийн хүрээнд ашиглагдаж буй арга аргачлалуудыг Монгол Улсад одоогийн мөрдөгдөж буй зохицуулалт, практиктай харьцуулсан шинжилгээг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 20. Улс орнуудын төсвийн хөрөнгө оруулалтыг үнэлэх аргачлалууд

Улс	Жилийн төсвийн хязгаарыг батлах	Төслийн үнэлгээ хийх арга аргачлал	Төслийг үнэлгээний дагуу эрэмбэлж сонгох	Сонгогдсон төслийг хэрэгжүүлэх, хянах
Монгол Улс	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилан, жилийн төсвийн хязгаарыг тогтооно.	Зардал–үр ашгийн шинжилгээ хийнэ төсөл холбогдох шаардлагыг хангасан байх ёстой.	Холбогдох журамд тулгуурлан оноо өгч, жинлэн ач холбогдлыг эрэмбэлнэ.	Сонгогдсон төслүүдийг төсвийн багтаамжид нийцүүлэн хэрэгжүүлж, хянадаг.
БНСУ	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу Сангийн яам жилийн ерөнхий төсвийн хүрээг тогтооно (World Bank, 2012).	Зардал–үр ашиг, дотоод өгөөж, нийгмийн ач холбогдол, өрсөлдөх чадвар зэрэг олон шалгуураар шинжилнэ (World Bank, 2012).	Сангийн яам “Төр, хувийн хэвшлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын менежментийн төв”/Public and Private Infrastructure Investment Management Center (PIMAC)/ өөр “Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл” /Preliminary Feasibility Study(PFS)/г хийлгэж, судалгааны үр дүнгээс хамааран тухайн төслийг улсын төсөвт тусгах эсэх шийдвэрийг гаргадаг (Kim & Rho, 2015).	“Төрийн хөрөнгө оруулалтын систем” /Public Investment Management System(PIMS)/ээр дамжуулан хэрэгжүүлж, хэрэгжилтийг “Төрийн худалдан авах ажиллагааны алба” /Public Procurement Service(PPS)/ хянаж, аудит хийдэг (Kim & Rho, 2015 PPS, 2025).
Улс	Жилийн төсвийн хязгаарыг батлах	Төслийн үнэлгээ хийх арга аргачлал	Төслийг үнэлгээний дагуу эрэмбэлж сонгох	Сонгогдсон төслийг хэрэгжүүлэх, хянах
Чили	Дундаас урт хугацааны төсвийн төлөвлөгөөг Ерөнхийлөгч баталж, жилийн төсвийн хүрээг тогтооно (DIPRES, 2021).	“Үндэсний хөрөнгө оруулалтын систем” / Sistema Nacional de Inversiones (SNI)/–ийн хүрээнд зардал–үр ашгийн шинжилгээг бүх төслийн хувьд заавал хийх журамтай байдаг. (DIPRES, 2021 Ahmad & Andrade, 2016).	“Үндэсний хөрөнгө оруулалтын систем” нь “Хөрөнгө оруулалтын төслийн нэгдсэн сан” /Banco Integrado de Proyectos (BIP)/ платформоор дамжуулан оноо, жинлэлтээр үнэлж, мэдээллийг нэгтгэн төслүүдийг эрэмбэлдэг (DIPRES, 2021 OECD, 2017).	Чили улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг салбар бүрийн яамд хэрэгжүүлж, төсөл дууссаны дараа Сангийн яам / Direcciyon de Presupuestos (DIPRES)/ гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг. (DIPRES, 2019 OECD, 2017).

Нидерланд	Сангийн яам, сайд нараар зөвшилцөн жилийн тэргүүлэх чиглэлийг баталсны дараа төсвийн хүрээг тогтоодог (OECD, 2016).	Зардал–үр ашиг, нийгэм, байгаль орчны нөлөөллийг цогцоор нь үнэлэхийн тулд “Нэгдсэн үнэлгээ” /Integrated Assessment/ийн аргачлалыг ашигладаг (OECD, 2016).	Төсөл бүрийн стратегийн нийцэл, санхүүгийн бодит боломжийн үндсэн дээр жиллэлт хийдэг (OECD, 2016).	Засгийн газрын агентлагууд хэрэгжүүлж, аудитаар хянадаг (OECD, 2016).
Сингапур	Парламентаас “Төсөв батлах хууль” /Supply Act/ийн дагуу жилийн төсвийн хүрээг батална (EC, 2023).	Зардал–үр ашгийн шинжилгээ, гүйцэтгэлд суурилсан төсвийн удирдлага (performance-based budgeting) ийн зарчмаар үнэлж, дүн шинжилгээ хийдэг (EC, 2023).	Төсөл сонголтыг үр дүн, стратегийн нийцэлд нийцүүлэн төсөвт шилжүүлнэ (EC, 2023).	Гүйцэтгэл, аудит дээр парламент, агентлагууд хяналт тавина (EC, 2023).
Норвеги	“Дунд хугацааны төсвийн зорилт” / Medium-Term Budgetary Objective(MBOR)/ системээр стратегийн зорилтод нийцүүлэн төсвийн хязгаарыг баталдаг (World Bank, 2012).	Зардал–үр ашиг, гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хамт ашиглан үнэлгээг хийдэг (World Bank, 2012).	Стратегийн байршил болон санхүүгийн боломжид үндэслэн жиллэлт хийдэг (World Bank, 2012).	Агентлагууд хэрэгжүүлж, гүйцэтгэлд суурилсан аудит хийнэ (World Bank, 2012).
Финлянд	Европын холбоо, Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын стандартын дагуу “Дунд хугацааны зардлын хөтөлбөр” / Medium-Term Expenditure Framework (MTEF)/–д суурилан, дунд хугацааны төсвийн хүрээг баталдаг (IMF, 2025).	Зардал–үр ашиг, нийгэм, байгаль орчны үр нөлөөг нэгдсэн жишгээр үнэлдэг цахим худалдан авах системтэй (IMF, 2025).	Стратеги болон санхүүгийн боломжид нийцсэн төсөлд санхүүжилт олгодог.	“Төвлөрсөн худалдан авалтын агентлаг” / Hansel/ төсвийн хөрөнгө оруулалтыг зохион байгуулдаг бөгөөд төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд аудит, хяналт хийдэг.

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Дүгнэлт: Монгол Улсын төсвийн төлөвлөлт олон улсын зарчмын жишигт нийцэж байгаа ч хэрэгжилтийн түвшинд гүнзгийрүүлэлт шаардаж байна. Тухайлбал,

- » Жилийн төсвийн хязгаарыг батлах: Жилийн төсвийн хязгаарыг дунд хугацааны төсвийн хүрээнд тулгуурлан тогтоодог нь Финланд, Норвеги зэрэг орны тогтолцоотой төстэй боловч стратегийн зорилт, бодлогын уялдаа, санхүүгийн боломжийг нарийвчлан тооцох тооцоолол сул байна.
- » Төслийн үнэлгээ хийх арга, аргачлал: Төслийн урьдчилсан үнэлгээний аргачлал хэт нэг талт, хязгаарлагдмал байна. Тухайлбал, Монгол Улсад төсөл бүрд зардал үр ашгийн шинжилгээ голчлон хэрэглэгддэг бол БНСУ, Сингапур, Финланд зэрэг орнуудад гүйцэтгэлийн шалгуур

(KPI), өгөөжийн түвшин (ROI, IRR) нийгмийн болон байгаль орчны нөлөөллийг хавсарч дүн шинжилгээ хийдэг нь илүү нарийвчилсан, бодит үр дүнтэй үнэлгээ болдог.

- » Төслийг үнэлгээний дагуу эрэмбэлж сонгох: Төсөл сонгон шалгаруулах, эрэмбэлэх үйл явцыг журамласан боловч бодит хэрэгжилт, хяналт уялдаа муутай байна. Тухайлбал, Монгол Улс төсөлд оноо өгч эрэмбэлэх журамтай ч бодит шалгуур, гүйцэтгэлд нөлөөлөх чадвар хязгаарлагдмал байна. Харин PIMAC (Өмнөд Солонгос), SNIP/BIP (Чили) зэрэг тусгай системүүд нь онооны дагуу шаардлага хангасан/шаардлага хангахгүй гэсэн шийдвэр гаргаж, төсвийн шийдвэрийг шууд чиглүүлдэг.
- » Сонгогдсон төслийг хэрэгжүүлэх, хянах: Монгол Улсад төсөл хэрэгжүүлэлт, хяналтын шатанд институцийн хариуцлага тодорхой бөгөөд цахим мэдээллийн сан бүрдсэн хэдий ч интеграци, өгөгдлийн уялдаа сул, бодит гүйцэтгэлийн хяналт хязгаарлагдмал байна. Тухайлбал, Финланд, Сингапур, БНСУ зэрэг орнууд гүйцэтгэлийн хяналт, худалдан авалтын бүхий л шатанд цахим систем (Hansel, PIMS, PPS зэрэг)–ийг ашиглаж, дата суурьтай, ил тод, олон шат дамжлагатай хяналтын механизмтай байдаг.

Кейс судалгаа 1: БНСУ – PIMAC тогтолцооны амжилтын загвар

БНСУ 1997 оны Азийн санхүүгийн хямралаас хойш төсвийн сахилга батыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Төр, хувийн хэвшлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын удирдлагын төв /Public and Private Infrastructure Investment Management Center/ (PIMAC)–ийг байгуулсан. Энэхүү байгууллага нь тус улсын макро эдийн засгийн бодлого, төсвийн зохистой зарцуулалт, стратегийн хөрөнгө оруулалтыг Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл (Preliminary Feasibility Study – PFS) арга зүйд тулгуурлан дүгнэж, төсвийн шийдвэрт нөлөөлдөг бие даасан бүтэц болж төлөвшсөн байна.

Үндсэн онцлог, арга зүй: Төр, хувийн хэвшлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын удирдлагын төв нь хөрөнгө оруулалтын шийдвэрийг шинжлэх ухаанч үндэслэлд тулгуурлан гаргах, санхүүгийн сахилга батыг хангах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэйг харуулж байна. Монгол Улсад ч мөн адил нэгдсэн, хараат бус үнэлгээний тогтолцоог бүрдүүлснээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн үр ашиг, гүйцэтгэлийн чанарыг эрс сайжруулах боломжтой.

- » **Хараат бус үнэлгээ:** PIMAC нь “БНСУ–ын Хөгжлийн институт” /Korea Development Institute(KDI)/–ийн дэргэдэх хараат бус судалгааны төв хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ба энэхүү байгууллагын зорилго нь хөрөнгө оруулалтын саналыг улс төрөөс ангид, эдийн засгийн оновчтой байдлаар шийдвэрлэх явдал юм.
- » **Шаардлага хангасан/Шаардлага хангахгүй үнэлгээ:** Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, 50 тэрбум воноос дээш өртөгтэй бүх төслүүдэд урьдчилсан ТЭЗҮ хийхийг хуульчилсан байдаг. Үүний үндсэн дээр тухайн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг “шаардлага хангасан/шаардлага хангахгүй” хэлбэрээр үнэлж, шийдвэр гаргадаг байна. Энэ загвар нь үр ашиггүй төслүүдийг эхнээс нь шүүх боломжийг олгодог.
- » **Олон шалгуурт үнэлгээний систем:** Төслийн эдийн засгийн үр ашгийг өргөтгөсөн өртөг–өгөөжийн шинжилгээ (Expanded CBA), дотоод өгөөжийн түвшин (IRR), ашиг–зардлын харьцаа (B/C) зэрэг тоон үзүүлэлтүүдээр хэмжихээс гадна, стратегийн зорилтод нийцэл,

нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хүрээлэн буй орчны үр дагавар зэрэг чанарын шалгуур ашиглан цогц үнэлгээ хийдэг.

Нөлөө ба үр дүн: PIMAC-ын тогтолцоо нь төрийн хөрөнгө оруулалтыг оновчтой, үр ашигтай шийдвэрлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна. Тус байгууллага нь улс төрөөс ангид, эдийн засгийн үндэслэлтэй байдлаар төсөл, хөтөлбөрийг дүгнэдэг, хараат бус шинжээчдийн төв бөгөөд хөрөнгө оруулалтын үр ашгийг урьдчилан үнэлэх үндэсний чадамжийг бүрдүүлжээ.

1999–2014 оны хооронд PIMAC нийт 635 төсөлд урьдчилсан ТЭЗҮ (PFS) хийснээс 36 хувийг нь “төсөл хэрэгжих үндэслэл хангалтгүй” хэмээн дүгнэж, төрийн санхүүжилтээс хассан байна. Энэ нь төсвийн хязгаарлагдмал нөөцийг стратегийн ач холбогдол өндөртэй, өгөөж сайтай төслүүд рүү чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлж, үрэлгэн зарцуулалтыг мэдэгдэхүйц бууруулахад нөлөөлжээ.

PIMAC зөвхөн тоон үзүүлэлтээр дүгнэлт гаргадаггүй, харин стратегийн нийцэл, нийгмийн үр нөлөө, эрсдэлийн удирдлага зэрэг чанарын үнэлгээг хослуулсан цогц аргачлалыг ашигладаг. Энэхүү дэвшилтэт үнэлгээний тогтолцоо нь зөвхөн төсөл хэрэгжүүлэх эсэхийг шийдэх төдий бус, төрийн хөрөнгө оруулалтын бодлогын ил тод байдал, сахилга бат, итгэлцлийг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан юм.

Кейс судалгаа 2: Чили улс – SNIP/BIP тогтолцооны туршлага

Чили улс 1990–ээд оноос эхлэн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, төсөл сонголтыг нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтаар хангах зорилгоор Үндэсний хөрөнгө оруулалтын тогтолцоо (Sistema Nacional de Inversiones Publicas, SNIP)–г хөгжүүлсэн. Энэхүү тогтолцоог Сангийн яамны дэргэдэх Төсвийн газраас (Dirección de Presupuestos, DIPRES) удирдан зохион байгуулдаг бөгөөд төслийн бүх үе шатыг хамарсан дүн шинжилгээ, хэрэгжилтийн хяналт, бодлогын нийцлийн үнэлгээ зэрэг өргөн хүрээтэй эрх мэдэлтэйгээр хэрэгжүүлдэг. SNIP нь төсвийн хөрөнгө оруулалтыг илүү хариуцлагатай, үр дүнтэй болгоход чиглэсэн институцийн гол тулгуур болж чадсан юм.

Тогтолцооны бүтэц ба арга зүй

- » **BIP платформ:** Төсөл бүрийг “Banco Integrado de Proyectos” (BIP) нэртэй онлайн платформд бүртгэж, цахим байдлаар оноо өгдөг. Онооны загвар нь стратегийн уялдаа, нийгмийн өгөөж, орон нутгийн ач холбогдол, хүйсийн тэгш байдал зэрэг шалгуур дээр үндэслэдэг байна (Ahmad, 2016).
- » **SNIP системийн үнэлгээ:** Бүх төсөлд заавал ex-ante CBA буюу урьдчилсан өгөөжийн шинжилгээ хийдэг нь хөрөнгө оруулалтын шийдвэрт судалгаа, өгөгдөл суурьтай хандлагыг нэвтрүүлж чадсан байна.
- » **Ex-post үнэлгээ:** Төсөл хэрэгжиж дууссаны дараа гүйцэтгэлд хяналт тавих албан ёсны шат дамжлагатай аудитын тогтолцоо DIPRES-ын хяналтад явагддаг.

Үр дүн ба нөлөө – SNIP тогтолцоо нь төсвийн бодлогыг стратегийн зорилтод нийцүүлэх үндэс суурийг бүрдүүлж, төсвийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог мэдэгдэхүйц сайжруулсан. 2016 оны байдлаар тус системд бүртгэгдсэн бүх төсөлд урьдчилсан болон гүйцэтгэлийн үнэлгээ бүрэн хийгдсэн бөгөөд BIP (Banco Integrado de Proyectos) платформоор дамжуулан олон нийтэд ил тод мэдээлэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд, төсвийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо, хяналт нэмэгдэж, хариуцлагын зарчим бодитоор төлөвшиж эхэлсэн нь Чилийн төсвийн

институцийн чадавх бэхжихэд чухал нөлөө үзүүлсэн юм (Inter-American Development Bank, 2021).

Монгол Улс төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, бодлогын нийцлийг сайжруулахын тулд олон улсын жишигт нийцсэн, дата суурьтай, олон шалгуурт үнэлгээ бүхий нэгдсэн системийг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнд зардал–үр ашгийн үнэлгээг олон талт дүн шинжилгээтэй хослуулж, төсөл сонгон шалгаруулалтыг цахим онооны платформоор дамжуулан улс төрөөс хараат бус явуулах, гүйцэтгэлийн хяналт, аудитын мэдээллийг ил тод байлгах, улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төслийн уялдааг сайжруулах чиглэлээр бодит шинэчлэл хийх нь чухал юм.


2.4 Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ

Хөгжлийн шатнаас хамааран улсын хөрөнгө оруулалтын бүтэц эрс ялгаатай илэрдэг. Хөгжиж буй орнуудын хувьд нийгмийн дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн суурь хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болдог. Тиймээс хөрөнгө оруулалтын зардал (CAPEX)–ын эзлэх хувь өндөр байдаг. Гэвч эдийн засгийн хөгжил ахихын хэрээр дэд бүтцийн анхан шатны хэрэгцээ хангагдаж, урсгал зардлын эзлэх жин өссөний улмаас CAPEX хувь буурах хандлагатай болдог. Энэ нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлт болон хөгжингүй орнуудын зардлын бүтцэд илэрдэг нийтлэг хандлага юм.

Зурагт үзүүлснээр, Монгол Улсын улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн зардалд эзлэх хувь (CAPEX %) нь ижил түвшний эдийн засагтай орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Энэ нь нэг талаар хөгжиж буй эдийн засагт дэд бүтэц болон суурь хөрөнгө оруулалтын эрэлт өндөр байгааг илтгэх үзүүлэлт боловч нөгөө талаар төрийн хөрөнгө оруулалтын үр ашиг ба чанарын асуудал илүү ач холбогдолтой болохыг харуулж байна.

Өндөр CAPEX хувь нь дангаараа эерэг үзүүлэлт биш бөгөөд тэрхүү хөрөнгө оруулалт эдийн засгийн бүтээмж, өсөлтөд бодитой хувь нэмэр оруулж байгаа эсэх нь гол шалгуур үзүүлэлт юм. Иймээс энэхүү судалгаанд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх зорилгоор олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хоёр индекс болох Public Investment Efficiency (PIE), Capital Productivity Ratio (CPR) үзүүлэлтүүдийг ашиглав. Эдгээр үзүүлэлтийг ОУВС–гийн боловсруулсан “Benchmarking Infrastructure Using Public Investment Efficiency Frontiers” (2023) аргачлалд тулгуурлан, 2022–2024 оны боломжит дундаж тоон мэдээлэлд үндэслэн тооцоолсон болно.

Зураг 13. CAPEX %, 2024



Эх сурвалж: Олон улсын валютын сангийн тоон мэдээнд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Public Investment Efficiency (PIE) индекс нь улсын хөрөнгө оруулалт эдийн засгийн гүйцэтгэлд хэр хэмжээний үр ашигтай нөлөөлж буйг хэмжих гол үзүүлэлт юм. Энэхүү индексийг ОУВС-гийн (IMF) боловсруулсан “Benchmarking Infrastructure Using Public Investment Efficiency Frontiers” (2023) аргачлалд тулгуурлан, 2022–2024 оны боломжит дундаж тоон мэдээлэлд үндэслэн тооцоолсон болно.

PIE индексийн ангилал дараах байдлаар тодорхойлогдоно:

- » 0–0.3 – хөрөнгө оруулалтын үр ашиг сул,
- » 0.4–0.6 – дунд түвшний үр ашигтай,
- » 0.6 ба түүнээс дээш – өндөр үр ашигтай түвшин.


Иймд PIE индекс нь төрийн хөрөнгө оруулалт эдийн засгийн бүтээмж, өсөлтөд ямар бодит нөлөө үзүүлж байгааг бусад орны дундажтай харьцуулан үнэлэх суурь хэмжүүр болж өгдөг.

Шинжилгээний үр дүнгээс харахад, бага болон дунд орлоготой орнуудын хувьд нэг хүнд ногдох ДНБ нэмэгдэхийн хэрээр Public Investment Efficiency (PIE) индекс өсөх хандлагатай байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийн эхэн үед дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг суурь салбаруудад чиглэсэн төрийн хөрөнгө оруулалт бүтээмж болон эдийн засгийн өсөлтийг илүү хүчтэй дэмждэг болохыг харуулж байна.

Харин өндөр орлоготой орнуудын хувьд, PIE индекс буурах чиг хандлагатай байгаа нь дэд бүтцийн ханасан байдал болон нэмэлт хөрөнгө оруулалтын ахиу үр өгөөж буурахтай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжил ахихын хэрээр төрийн хөрөнгө оруулалтын бүтээмжийн нэмэлт өсөлт хязгаарлагдаж, үр ашиг нь буурах хандлага ажиглагдана.

Монгол Улсын хувьд, PIE индексийн утга 0.43 гарсан нь дунд түвшний нөлөөтэй ангилалд хамаарч, бага болон дунд орлоготой орнуудын дундажтай ойролцоо байна. Энэ нь улсын хөрөнгө оруулалтын зардлын түвшин (CAPEX %) өндөр байгаатай уялдан, төсвийн хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтөд тодорхой хэмжээний эерэг нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Гэвч PIE-ийн утга дунд түвшинд байгаа нь төрийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломж, өөрөөр хэлбэл илүү өндөр бүтээмж, чанартай хөрөнгө оруулалт хийх потенциал байгааг илтгэнэ. Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт–шинжилгээний үр нөлөөг сайжруулах шаардлагыг онцолж байна.

Зураг 14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нөлөөлөл болон нэг хүнд ногдох ДНБ-ий харьцуулалт



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол


Capital Productivity Ratio (CPR) индекс нь улсын хөрөнгө оруулалтын үр ашгийг зардлын бүтээмжийн талаас үнэлэх үзүүлэлт юм. Өндөр CPR буюу 3-аас дээш байх нь хөрөнгийн бүтээмж сул, үр ашиг бага байгааг илтгэнэ.

Шинжилгээний үр дүнгээс харахад, нэг хүнд ногдох ДНБ нэмэгдэхийн хэрээр CPR буурах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжил ахих тусам хөрөнгө оруулалтын үр ашиг дээшилж, хөрөнгийн бүтээмж сайжирч байна. Харин CAPEX хэмжээ нэмэгдэхийн хэрээр CPR өсөх буюу хөрөнгө оруулалтын үр ашиг буурах зүй тогтол ажиглагдлаа. Энэ нь хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх тусам зардлын бүтээмж буурч, илүү их хөрөнгө оруулалт заавал өндөр үр ашиг авчирдаггүйг харуулж байна.


PIE болон CPR үзүүлэлтийг харьцуулан авч үзвэл, PIE нь хөрөнгө оруулалтын эдийн засгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийг, харин CPR нь хөрөнгө оруулалтын зардлын бүтээмжийн түвшнийг тус тус илэрхийлдэг. Иймээс зарим улсад PIE дунд түвшинд байгаа ч CPR харьцангуй өндөр гарч болох бөгөөд энэ нь тухайн улсын эдийн засгийн бүтцийн онцлог, дэд бүтцийн ханасан байдал, хөрөнгийн ашиглалтын үр ашиг зэргээс хамаардаг.

Тухайлбал, өндөр орлоготой орнуудад дэд бүтцийн хөгжил өндөр түвшинд хүрсэнтэй холбоотойгоор шинэ хөрөнгө оруулалтын ахиу нөлөө (PIE) бага байх хандлагатай ч, одоо байгаа хөрөнгийг үр ашигтай ашиглах чадвар (CPR бага) харьцангуй өндөр байдаг. Монгол Улсын хувьд, улсын хөрөнгө оруулалтын хэмжээ (CAPEX %) харьцангуй өндөр байгаа хэдий ч CPR үзүүлэлт дундаж түвшинд байна. Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг хангалттай бус, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, менежмент, хяналт-шинжилгээний тогтолцоог сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон хөрөнгө оруулалтын зардлын харьцуулалт



Зураг 16. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон нэг хүнд ногдох ДНБ-ий харьцуулалт



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

III. УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2020–2024 ОНД ЭХЭЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлэгт 2020–2024 онд эхэлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийг 4 бүлэгт хуваан үзэж (амжилттай хэрэгжсэн, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн, гүйцэтгэл хангалтгүй, хэрэгжиж буй), тэдгээрийн хэрэгжилтэд юу нөлөөлж байгааг нээлттэй мэдээлэлд үндэслэн тодорхойлсон болно.

2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслийн тоо өсөлт, бууралттай хэлбэлзэж байсан ч төсвийн нийт дүн болон нэг төслийн дундаж өртөг тогтвортой өссөн хандлагатай байв. Ялангуяа 2022 оноос хойш төсөл бүрийн өртөг огцом өссөн нь томоохон дэд бүтцийн төслүүдэд төвлөрч, хөрөнгийн төвлөрөл нэмэгдсэнийг илтгэнэ. Төслүүдийн 60 гаруй хувь нь барилга байгууламжид, төсөвт өртгийн 80 орчим хувь нь мөн энэ ангилалд ногдож буй нь бодлогын түвшинд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг тэргүүлэх чиглэл болгож байгааг харуулж байна.

Төслүүдийг хэрэгжилтийн ангиллаар авч үзвэл, нийт төслийн 61.9 хувь нь амжилттай хэрэгжсэн ч тэдгээрийн төсөвт өртөг харьцангуй бага буюу нийт хөрөнгө оруулалтын 30.6 хувьтай тэнцэж байна. Харин төсвийн 48.9 хувь нь одоогоор хэрэгжиж буй цөөн тооны том төсөлд төвлөрсөн байгаа нь тухайн төслүүд зогсох, гацаанд орсон тохиолдолд хөрөнгө түгжигдэх, төсвийн гүйцэтгэл буурах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хугацааны хоцрогдол болон гүйцэтгэл хангалтгүй хэрэгжсэн төслүүдийн дийлэнх нь мөн л барилга байгууламжийн төслүүд байгаа бөгөөд энэ төрлийн төслүүдийн хугацааг сунгах, төсөвт өртөг нэмэгдэх, санхүүжилт саатах зэрэг асуудал нийтлэг гарч байна. Үүнээс харахад төсөвт өртөг өндөртэй, барилгын төслүүдийн хэрэгжилтэд эрсдэл өндөр байгаа нь бодит нөхцөл, зохион байгуулалтын чадамжтай шууд хамааралтай байна.


Салбарын түвшинд үзвэл, зам тээвэр, боловсрол, барилгын салбаруудад хэт төвлөрсөн хөрөнгө оруулалт хийгдсэн бол байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг салбаруудад бага хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн дүр зурагтай байна.

Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн удирдлагад илүү нарийн шинжилгээ, эрэмбэ дараалал, эрсдэлийн удирдлагын зарчим шаардагдаж байна. Төслийн гүйцэтгэлийг бодит мэдээлэлд суурилан хянаж, хэрэгжилтийн хяналтыг үе шаттай хийх нь төсвийн үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх үндэс болно.

Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2020–2024 онд эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн шинжилгээ

Төслүүдийн ерөнхий мэдээлэл: 2020–2024 оны хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2499 шинэ төсөл хэрэгжүүлсэн байна. Төслийн тоо жил бүр хэлбэлзэж байгаа ч нэг төслийн дундаж өртөг тасралтгүй өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2022 онд нэг төслийн дундаж өртөг өмнөх жилүүдийн түвшнээс ойролцоогоор 2.1 дахин нэмэгдсэн бол 2024 онд энэ үзүүлэлт 2022 оныхоос даруй 2 дахин өссөн дүнтэйгээр шинэ төслүүд төлөвлөгдсөн байна. 2023 онд өмнөх төслүүдийг бүрэн дуусгах зорилгоор нийт хэрэгжүүлэх шинэ төслийн тоог 10 болгож бууруулсан ч нийт 671 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Зураг 17. 2020–2024 онд шинээр хэрэгжүүлж эхэлсэн нийт төслийн тоо, анхны төсөвт өртөг (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2025)

2023 онд шинээр хэрэгжиж эхэлсэн төслүүдийг авч үзвэл, тэдгээрийн дийлэнх нь хатуу дэд бүтэц (авто зам, барилга байгууламж, дэд станц) болон орон сууц, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах чиглэлтэй байна. Түүнчлэн ихэнх төсөл Улаанбаатар хотод төвлөрсөн байгаа нь нийслэлийн төвлөрлийг дагасан стратегийн хөрөнгө оруулалтын бодлого үргэлжилснийг харуулж байна. Мөн 2023 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн дундаж өртөг нь өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Энэ нь цөөн тооны том төсөлд их хэмжээний хөрөнгө төвлөрүүлж байгаа бөгөөд хэрэв тухайн төсөл хойшлогдох эсвэл дуусахгүй үлдвэл их хэмжээний хөрөнгө түгжигдэх, улмаар үр ашиггүй зардал болох эрсдэлийг дагуулж байна.


Хүснэгт 21. 2023 онд шинээр хэрэгжүүлсэн өндөр төсөвт өртөгтэй 10 төслийн мэдээлэл, сая төгрөгөөр

Төсөл	Төрөл	Нийт төсөвт өртөг	Тухайн жилд санхүүжих дүн	Урьдчилсан гүйцэтгэл
Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/	Тоног төхөөрөмж	318,000	272,220	260,279
“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/	Барилга байгууламж	138,353	38,377	38,159
Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	Барилга байгууламж	45,523	45,523	45,230
Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал	Барилга байгууламж	45,000	22,000	15,673
Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/	ТЭЗҮ	40,000	40,000	32,495
Улсын чанартай хатуу хучилттай авто замын их засвар /Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Хэнтий/	Их засвар	35,553	35,553	34,052
Улсын бүртгэлийн ерөнхий газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар/	Тоног төхөөрөмж	18,540	18,540	18,529
Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улаанбаатар/	Тоног төхөөрөмж	15,967	15,967	11,261
Үндэсний дата төвийн тоног төхөөрөмж, техникийн хүчин чадлыг сайжруулах төсөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	Тоног төхөөрөмж	13,572	13,572	13,209
“Өнөр бүл” хүүхдийн төвийн их засвар /Улаанбаатар/	Их засвар	333	333	310
Нийт		670,841	502,085	469,196

Эх сурвалж: (Монгол Улсын Сангийн яам, 2024)

2020–2024 онд нийт хэрэгжүүлсэн төслийг төсөвт өртгөөр ангилан харвал нийт төслийн 91.5 хувь нь 100 саяас 10 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнтэй байна. Энэ нь 2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хувьд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого дунд болон бага өртөгтэй, олон тооны төсөлд төвлөрөх хандлагатай байсныг харуулж байна. Дараагийн хэсэгт хамгийн өндөр өртөгтэй буюу 100 тэрбумаас дээш өртөгтэй 12 төслийг авч үзэв.

Зураг 18. 2020–2024 онд шинээр хэрэгжиж эхэлсэн төслүүдийн тоо, төсөвт өртгийн ангилал, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Өндөр төсөвт өртөгтэй төслүүд нь төсвийн гүйцэтгэлийн эрсдэл, хөрөнгө оруулалтын төвлөрөл, төсвийн дарамтыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөтэй байдаг учир чухалчлан авч үзэх шаардлагатай. 2020–2024 оны хооронд төсөвт өртөг нь 100 тэрбум төгрөгөөс давсан нийт 12 төсөл хэрэгжүүлэхээр тусгагдсан нь нийт шинэ хөрөнгө оруулалтын төсвийн 24 хувийг дангаар эзэлж байна. Энэ нь өндөр өртөгтэй цөөн тооны төсөлд улсын хөрөнгө оруулалтын дөрөвний нэгийг төвлөрүүлж байгааг харуулна.

Өндөр төсөвт өртөгтэй төслүүдийг газар зүйн байршлаар харвал, улсын хэмжээнд 3, Улаанбаатар хотод 3, Хэнтий аймагт 3, Төв аймагт 2, Дорнод аймагт 1 төсөл тус тус байна. Авто замын 5 томоохон төсөл байгаагийн 4 төсөл нь Хэнтий болон Дорнод аймагт хэрэгжиж байна.

Хүснэгт 22. 2020–2024 онд хэрэгжиж эхэлсэн хамгийн өндөр төсөвт өртөгтэй 12 төслийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр

Төсөл	Төсөвт өртөг	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Номтын ам, Төв, Хөшигийн хөндий/	676	2024	2027
Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/	563	2024	2026
Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/	318	2023	2024
Жаргалтхаан–Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян– Адарга, Биндэр, Хэрлэн сум/	264	2024	2026
Бор–Өндөр–Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор–Өндөр сум/	217	2024	2026
Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	140	2024	2026
“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/	138	2023	2024

Төсөл	Төсөвт өртөг	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/	116	2022	2025
Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/	114	2022	2025
Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	110	2021	2021
Өндөрхаан–Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 130 км /Хэнтий, Батноров, Норовлин сум/	109	2022	2025
Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц /Улсын хэмжээнд/	100	2022	2024

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2020–2024 онд шинээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг зориулалт, бүтцээр нь авч үзвэл, төслийн дийлэнх хувийг барилга байгууламжийн ажлууд бүрдүүлж байна. Нийт төслийн 59 хувь нь барилга байгууламжийн ажил байгаа бол 15 хувь нь их засвар, 23 хувь нь тоног төхөөрөмж худалдан авах, 3 хувь нь ТЭЗҮ боловсруулах төслүүд байна. Харин нийт төсөвт өртгөөр нь харвал барилга байгууламжийн төслүүд нийт хөрөнгө оруулалтын 81 хувийг дангаараа эзэлж байгаа нь энэ чиглэлд хөрөнгө оруулалт өндөр төвлөрч байгааг илтгэнэ. Үлдсэн хэсгийг тоног төхөөрөмжийн төслүүд 12 хувь, ТЭЗҮ 4 хувь, их засварын төслүүд 3 хувь тус тус эзэлж байна.

Дундаж төсөвт өртгийн хувьд харьцуулбал, барилга байгууламжийн болон ТЭЗҮ-ийн нэг төсөл дунджаар 6.2–6.3 тэрбум төгрөгийн өртөгтэй байна. Харин их засварын нэг төсөлд 900 сая, тоног төхөөрөмжийн төсөлд 2.4 тэрбум төгрөг дунджаар төсөвлөгдсөн байна. Эдгээр тоон үзүүлэлтээс харахад, шинээр эхэлж буй төслүүд голчлон дэд бүтэц, барилга байгууламжид төвлөрч байгаа бөгөөд энэ нь төсвийн бодлого бүтээн байгуулалт, материаллаг хөрөнгө оруулалтад чиглэсэн хэв шинжийг хадгалж байгааг харуулж байна.

Хүснэгт 23. 2020–2024 онд эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслүүд, зориулалтаар, төслүүдийн тоо, нийт төсөвт өртөг, эзлэх хувиар

Төрөл	Төслийн тоо	Нийт төсөлд эзлэх хувь	Дундаж өртөг	Нийт төсөвт өртөг	Хувь
I. Барилга байгууламж	1,470	59%	6.3	9,280	81%
II. Их засвар	387	15%	0.9	364	3%
III. Тоног төхөөрөмж	576	23%	2.4	1,395	12%
IV. ТЭЗҮ	66	3%	6.2	411	4%
Нийт	2,499	100%	4.6	11,450	100%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийг төсвийн ерөнхийлөн захирагчаар харвал Зам, тээврийн хөгжлийн сайд хамгийн их буюу 2.7 их наяд, Боловсролын сайд 2 их наяд, Барилга, хот

байгуулалтын сайд 1.3 их наяд төгрөгийг захиран зарцуулж байна. Энэ нь зам, тээврийн салбар нь дэд бүтцийн тулгуур салбарын хувьд хөрөнгө оруулалтын гол чиглэл болсоор байгааг харуулж байна.

Хоёрдугаарт, боловсролын салбар 1972 төсөлтэйгөөр эрэмбэлэгдэж байна. Энэ нь сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөл, дотоод орчны сайжруулалт зэрэг боловсролын орчинд чиглэсэн бүтээн байгуулалт, шинэчлэлд ихээхэн анхаарал хандуулсныг илтгэнэ. Үүний дараа Барилга, хот байгуулалтын яам 1281 төсөлтэйгөөр жагсаж байна. Мөн эрүүл мэнд, соёл, спорт, залуучууд, аялал жуулчлал, эрчим хүч, хууль, шүүх, дотоод хэргийн салбаруудад харьцангуй олон тооны төсөл хэрэгжүүлсэн байна.

2020–2024 онд шинээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн дийлэнх нь зам тээвэр, боловсрол, барилгын салбарт төвлөрч, эдгээрийг дагасан дэд бүтцийн шинэчлэл, өргөтгөл илүү түлхүү хэрэгжсэн байна. Харин байгаль орчин, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын чиглэлийн төслүүдийн тоо үлэмж бага байгаа нь эдгээр салбар хөрөнгө оруулалтын хувьд хоёрдогч байр суурь эзэлж байгааг илтгэж байна.

Зураг 19. 2020–2024 онд шинээр эхэлсэн төслийн тоо, ТЕЗ–аар, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод 3.2 их наядын 554 төсөл, улсын хэмжээнд 1.8 их наядын 124 төсөл тус тус хэрэгжсэн байна. Хэнтий аймагт 1.3 их наяд төгрөгийн 169 төсөл хэрэгжсэн нь бусад аймгуудтай харьцуулахад тэргүүлэх үзүүлэлт юм. 2020–2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт нийслэл болон тодорхой цөөн тооны аймагт өндөр төвлөрөлтэй байгааг

дээрх тоон мэдээлэл харуулж байна. Улаанбаатар хотод хэрэгжиж буй төслүүдийн тоо, өртөг улсын дундажтай харьцуулахад өндөр байгаа нь нийслэлийн дэд бүтцийн асуудлыг шийдэх бодлогын давуу байр суурийг харуулж байна. Хөдөө, орон нутагт зарим аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалт бараг хийгдээгүй буюу маш бага хэмжээтэй байгаа нь улсын төсвийн хуваарилалт нь орон нутгийн хөгжлийн стратегитай уялдсан эсэхийг эргэн харах шаардлагатайг сануулж байна.

Хүснэгт 24. 2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эхэлсэн төслийн тоо, байршлаар, тэрбум төгрөгөөр

Байршил	Төслийн тоо	Төсөвт өртөг
Улаанбаатар	554	3,168
Улсын хэмжээнд	124	1,798
Хэнтий	169	1,263
Ховд	134	540
Төв	81	539
Хөвсгөл	159	395
Дархан–Уул	87	391
Дорнод	49	361
Өвөрхангай	126	352
Архангай	119	312
Баянхонгор	71	277
Завхан	88	259
Увс	140	238
Сэлэнгэ	109	217
Говь–Алтай	82	204
Баян–Өлгий	85	191
Сүхбаатар	57	187
Булган	73	168
Дорноговь	45	163
Дундговь	49	120
Орхон	38	119
Говьсүмбэр	17	94
Өмнөговь	43	93

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2020–2024 онд шинээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн хэрэгжилт: 2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуульд тусгагдсан нийт 2499 төслийн бодит хэрэгжилтийн мэдээлэлд тулгуурлан дескриптив

шинжилгээ хийв. Шинжилгээнд шаардлагатай өгөгдлийг opendatalab.mn, opendata.burtgel.gov.mn, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан зэрэг олон нийтэд нээлттэй эх сурвалжуудаас цуглуулан ашигласан болно.

Нийт 9.7 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,470 барилга байгууламжийн төсөл, 372.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 387 их засварын төсөл, 1.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 576 тоног төхөөрөмжийн төсөл, 456.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 66 ТЭЗҮ буюу зөвлөх үйлчилгээтэй холбоотой төсөл тусгагдсан байна. Мөн төсөвт өртгөөр дараах байдлаар хуваан үзэх боломжтой. 2020–2024 оны хооронд нийт 11.96 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 2499 шинээр хэрэгжих төсөл тусгагдсанаас төслийн хэрэгжилтийн байдлыг үнэлэхдээ “Амжилттай хэрэгжсэн”, “Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн”, “Гүйцэтгэл хангалтгүй” болон “Хэрэгжиж буй” гэсэн ангиллаар тодорхойлж, дараах гурван шалгуурын хүрээнд үнэлэв.

1. Нийт төсөвт өртгийн 20 хувийн санхүүжилтийг олгосон эсэх
2. Төсөл төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн эсэх /2024 оноос хойш хэрэгжиж дуусах төслийг хугацаандаа хэрэгжсэнд тооцож авч үзсэн/
3. Төсөл нь 2024 онд багтаж хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн эсэх болно.

Амжилттай хэрэгжсэн төсөлд дээрх гурван шалгуурыг хангасан төслүүдийг авч үзэх бөгөөд нийт 3.66 их наяд төгрөгийн (30.6 хувь) төсөвт өртөгтэй, 1548 төсөл (61.9 хувь) багтаж байна. Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн хувьд 1.46 их наяд төгрөгийн (12.3 хувь) төсөвт өртөгтэй, 355 төсөл (14.2 хувь) багтаж байна. Гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн хувьд 983.2 тэрбум төгрөгийн (8.2 хувь) төсөвт өртөгтэй, 154 төсөл (6.2 хувь), харин хэрэгжиж буй төслүүдийн хувьд нийт 5.8 их наяд төгрөгийн (48.9 хувь) төсөвт өртөг бүхий 442 төсөл (17.7 хувь) тус тус багтаж байна.

Зураг 20. 2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, төслийн тоогоор, төсөвт өртөг (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нэг төслийн дундаж төсөвт өртөг 4.7 тэрбум төгрөг байгаа бөгөөд амжилттай хэрэгжсэн төслүүдийн хувьд 2.36 тэрбум төгрөг, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн хувьд 4.1 тэрбум төгрөг, хэрэгжиж буй төслүүдийн хувьд 13.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байна. Харин гүйцэтгэл хангалтгүй төслийн тухайд 6.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байгаа хэдий ч бодитоор олгосон санхүүжилтийн хэмжээ 541 сая төгрөг байна.

Мөн амжилттай хэрэгжсэн төслүүд нийт төслүүдийн 61.9 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч 30.6 хувийн төсвийг дангаараа бүрдүүлж байна. Харин хэрэгжиж буй төслүүдийн тухайд нийт төслүүдийн 17.7 хувийг бүрдүүлж, нийт төсөвт өртгийн 48.9 хувьтай тэнцэж байгаа нь инфляц, төслүүдийн өртөг өссөнтэй холбоотойгоор 2024 онд эхэлсэн төслүүдийн өртөг өндөр болсныг илтгэж байна. 2024 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн дундаж өртөг 8.4 тэрбум төгрөг болсон нь 2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн дундаж өртөг болох 1.4 тэрбум төгрөгөөс 6 дахин өндөр болсныг харуулж байна. Мөн манай улсын инфляцын түвшин 2020 онд 2.3, 2021 онд 13.4, 2022 онд 13.2, 2023 онд 7.9, 2024 онд 8.4 хувь буюу 2020–2024 онд таван жилийн дотор 54 хувиар өссөн байна.

2020–2024 онд шинээр эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн тендер шалгаруулалтад оролцож, хамгийн олон удаа шалгарсан топ 10 компанийг дараах хүснэгтэд харуулав.


Хүснэгт 25. 2020–2024 онд шинээр эхэлсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн тендерт хамгийн олон удаа шалгарсан топ 10 компани

№	ТОП 10 компани	Тоо
1	“Ай Ти зон” ХХК	634
2	“Сетунари” ХХК	529
3	“Медмонгол” ХХК	505
4	“Сүвэн–Уул” ХХК	443
5	“Монтех дистрибьюшн” ХХК	388
6	“Саммиткомпьютер технологи” ХХК	334
7	“Пролианс” ХХК	284
8	“Чиглэл” ХХК	267
9	“Хашхан” ХХК	233
10	“Баянгол мед” ХХК	220

Эх сурвалж: Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, 2025

Төслийн хэрэгжилтийн ерөнхий байдал: Амжилттай хэрэгжсэн төслүүдийн хувьд 2.8 тэрбум төгрөгийн дундаж өртөгтэй 634 барилга байгууламжийн төсөл, 811.3 сая төгрөгийн дундаж өртөгтэй 334 их засварын төсөл, 2.3 тэрбум төгрөгийн дундаж өртөгтэй 525 тоног төхөөрөмжийн төсөл болон 6.87 тэрбум төгрөгийн дундаж өртөгтэй 55 ТЭЗҮ тус тус багтаж байна. Нийт төслийн дундаж төсөвт өртөг 4.78 тэрбум төгрөг байгаа бөгөөд амжилттай хэрэгжиж буй төслүүдийн дундаж даруй 2 дахин бага байгаа нь бага төсөвт өртөгтэй төслүүд хугацааны хоцрогдол, санхүүжилтийн хүндрэл зэрэгт өртөх магадлал бага, урт хугацаандаа амжилттай хэрэгжих магадлал өндөр байх боломжтойг харуулж байна.

Зураг 21. 2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, нийт төслийн тоонд эзлэх хувиар



Зураг 22. 2020–2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн хэрэгжилт, нийт төсөвт өртөгт эзлэх хувиар



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн 301 төсөл нь 1.27 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга байгууламжийн төсөл, 61.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий их засварын 40 төсөл, 61.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмжийн 10 төсөл, 71.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ТЭЗҮ боловсруулах төслүүд тус тус багтаж байна. Үүнээс барилга байгууламжийн төслүүд ихэвчлэн хугацаа хоцрогдолтой хэрэгжиж байна.

Төсөвт өртөгт өөрчлөлт орсон 2.85 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 566 төсөл байгаагаас барилга байгууламжийн 2.25 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 488 төсөл, их засварын 84.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, тоног төхөөрөмжийн 440.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл, ТЭЗҮ-ийн 73 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл тус тус багтаж байна. Мөн өмнө дурдсанчлан хугацааны хоцрогдолтой хэрэгжиж буй төслүүдийн дийлэнх хувийг барилга байгууламжийн төсөл эзэлж байгаа бөгөөд жил дамнан шилжиж буйтай холбоотой төсөвт өртөгт ч мөн адил өөрчлөлт орох хандлагатай байна. 2020–2024 онуудад шинээр хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилтийг он тус бүрээр харуулав.

2020 оны төслүүд: 2020 онд 688 төсөл шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн бөгөөд эдгээрийн нийт төсөвт өртөг 1.1 их наяд төгрөг байна. Хэрэгжилтийн хувьд 445.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 531 төсөл амжилттай хэрэгжсэн, 570.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн бол 104.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл гүйцэтгэл хангалтгүй ангилалд хамаарч байна.

Хүснэгт 26. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр эхэлсэн төслийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр

Хэрэгжилтийн байдал		I. Барилга байгууламж	II. Их засвар	III. Тоног төхөөрөмж	IV. ТЭЗҮ	Нийт
Амжилттай хэрэгжсэн	Төслийн тоо	190	208	127	6	531
	Сүүлийн төсөвт өртөг	244.7	90.3	108.0	2.8	445.8
Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн	Төслийн тоо	129	17	3	2	151
	Сүүлийн төсөвт өртөг	476.5	19.2	8.4	66.0	570.1
Гүйцэтгэл хангалтгүй	Төслийн тоо	5	0	1	0	6
	Сүүлийн төсөвт өртөг	100.6	–	3.5	–	104.1
Хэрэгжиж буй	Төслийн тоо	0	0	0	0	0
	Сүүлийн төсөвт өртөг	–	–	–	–	–
Нийт	Төслийн тоо	324	225	131	8	688
	Сүүлийн төсөвт өртөг	821.8	109.5	119.8	68.8	1,120.0

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн нийт төсөвт өртгийн 83.6 хувийг барилга байгууламжийн төслүүд бүрдүүлж байна. Үүнийг ТЭЗ нараар ангилан үзвэл Барилга, хот байгуулалтын сайдын 20 төслийн 149.1 тэрбум төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 47 төслийн 154.8 тэрбум төгрөг, Соёлын сайдын 13 төслийн 94.8 тэрбум төгрөгийн төслүүд хугацааны хоцрогдолтой хэрэгжиж, эдгээрийн нийлбэр нь нийт хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн барилга байгууламжийн төслүүдийн 83.7 хувийг бүрдүүлсэн.

2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг өөрчлөгдсөн, хэрэгжих хугацаа хойшилсон төслүүдийг Хавсралт 1–т дэлгэрэнгүй харуулав. Төсөвт өртөг өөрчлөгдсөн нийт 131 төсөл байгаагаас хоёроос дээш удаа өөрчлөгдсөн 25 төсөл байна. Эдгээрээс жишээ дурдвал, Эрүүл мэндийн төвийн салбар амбулаторийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ 2020 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 2.8 тэрбум төгрөг байсан бол 2023 оны байдлаар 4.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв /Улсын хэмжээнд/ 2020 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 20.0 тэрбум төгрөг байсан бол 2023 оны байдлаар 65.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж дууссан байна.

Хүснэгт 27. 2020 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн төсөвт өртөг хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр

№	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг					Анхны төлөвлөсөн дуусах огноо	Бодит дууссан огноо	Төсөв өртгийн өөрчлөлт
		2020	2021	2022	2023	2024			
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/	20,000.0	37,900.0	65,900.0	–	–	2021	2023	45,900.0
2	Үерийн хамгаалалтын байгууламж /Хэнтий, Хэрлэн сум/	1,000.0	13,000.0	13,000.0	14,420.4	–	2021	2023	13,420.4
3	Үерийн усны хамгаалалтын далан суваг /Баян–Өлгий, Өлгий сум/	13,200.0	13,200.0	13,200.0	23,896.7	–	2022	2024	10,696.7
4	Чингис хаан музейн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	53,066.5	62,864.7	62,864.7	63,511.0	–	2021	2023	10,444.5
5	Аврах гал унтраах 10 дугаар ангийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	13,424.0	15,910.4	21,705.8	–	–	2021	2022	8,281.8
6	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Улсын хэмжээнд/	20,000.0	20,000.0	20,357.0	12,406.7	–	2021	2023	7,950.3
7	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	4,000.0	6,541.4	8,041.4	8,971.5	–	2021	2023	4,971.5
8	“Шинэ хороо” төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/	3,800.0	7,600.0	–	8,461.4	–	2020	2023	4,661.4
9	Чингис хот – Дадал сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 50 км /Хэнтий/	45,000.0	–	–	48,840.1	–	2022	2023	3,840.1
10	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Хан–Уул дүүрэг, 10 дугаар сургууль/	4,500.0	5,429.4	–	7,750.5	–	2021	2023	3,250.5

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дундаж өртгийн хувьд амжилттай хэрэгжсэн нэг төслийн төсөвт өртөг 839.5 сая төгрөг байгаа бол хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслийнх 3.8 тэрбум төгрөг, гүйцэтгэл хангалтгүй төслийнх 17.4 тэрбум төгрөг байгаа нь төслийн төсөвт өртөг нэмэгдэхийн хэрээр хэрэгжилтэд хүндрэл үүсэх боломжтой байгааг илэрхийлж байна.

2021 оны төслүүд: 2021 онд 426 төсөл шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн бөгөөд эдгээрийн нийт төсөвт өртөг 11 их наяд төгрөг байна. Хэрэгжилтийн хувьд 471.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 274 төсөл амжилттай хэрэгжсэн, 453.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 128 төсөл хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн, 85 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл гүйцэтгэл хангалтгүй болж үлдсэн 68.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл хэрэгжиж буй ангилалд хамаарч байна.

Хүснэгт 28. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр эхэлсэн төслийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр

Хэрэгжилтийн байдал		I. Барилга байгууламж	II. Их засвар	III. Тоног төхөөрөмж	IV. ТЭЗҮ	Нийт
Амжилттай хэрэгжсэн	Төслийн тоо	103	67	83	21	274
	Сүүлийн төсөвт өртөг	232.9	36.7	188.3	13.4	471.3
Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн	Төслийн тоо	108	17	3	0	128
	Сүүлийн төсөвт өртөг	401.7	23.5	28.4	–	453.7
Гүйцэтгэл хангалтгүй	Төслийн тоо	16	0	2	0	18
	Сүүлийн төсөвт өртөг	79.3	–	5.7	–	85.0
Хэрэгжиж буй	Төслийн тоо	5	0	1	0	6
	Сүүлийн төсөвт өртөг	67.6	–	0.5	–	68.1
Нийт	Төслийн тоо	232	84	89	21	426
	Сүүлийн төсөвт өртөг	781.4	60.3	222.9	13.4	1,078.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2021 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн нийт төсөвт өртгийн 88.5 хувийг барилга байгууламжийн төслүүд бүрдүүлж байна. Үүнийг ТЭЗ нараар ангилан үзвэл Барилга, хот байгуулалтын сайдын 17 төслийн 61.2 тэрбум төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 42 төслийн 118.7 тэрбум төгрөг, Соёлын сайдын 11 төслийн 58.9 тэрбум төгрөгийн төслүүд хугацааны хоцрогдолтой хэрэгжиж, эдгээрийн нийлбэр нь нийт хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн барилга байгууламжийн төслүүдийн 59.4 хувийг бүрдүүлсэн нь ТЭЗ нарын хувьд төвлөрөл буурсан байх магадлалтайг илэрхийлж байна.

2021 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг өөрчлөгдсөн, хэрэгжих хугацаа хойшилсон төслүүдийг Хавсралт 2–т дэлгэрэнгүй харуулав. Төсөвт өртөг өөрчлөгдсөн нийт 142 төсөл байгаагаас хоёроос дээш удаа өөрчлөгдсөн 38 төсөл байна. Эдгээрээс жишээ дурдвал, Цэвэр усны гадна шугам сүлжээ /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ 2021 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 0.5 тэрбум төгрөг байсан бол 2023 оны байдлаар 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж байна. Мөн Сургуулийн барилга, 960 суудал /

Дундговь, Сайнцагаан сум, “Говийн ирээдүй” цогцолбор/ 2021 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 5.5 тэрбум төгрөг байсан бол 2024 оны байдлаар 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж байна.

Хүснэгт 29. 2021 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн төсөвт өртөг хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр

№	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг				Анхны төлөвлөсөн дуусах огноо	Бодит дууссан огноо	Төсөв өртгийн өөрчлөлт
		2021	2022	2023	2024			
1	Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл /Хөвсгөл, Мөрөн сум/	2,300.0	–	7,079.9	–	2022	2024	14,779.9
2	Сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18 дугаар хороо, 12 дугаар сургууль/	7,300.0	7,300.0	18,475.3	21,387.3	2022	2025	14,087.3
3	Музей, номын сангийн цогцолбор /Дархан-Уул, Дархан сум/	5,000.0	14,533.0	15,600.5	–	2022	2024	10,600.5
4	Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, “Говийн ирээдүй” цогцолбор/	5,496.4	–	5,987.9	14,726.6	2022	2025	9,230.2
5	“Саран хөхөө” театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	9,500.0	16,806.1	18,503.1	–	2023	2024	9,003.1
6	Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын конторын барилга /Улсын хэмжээнд/	7,946.7	8,001.0	6,558.5	–	2021	2023	8,611.8
7	Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/	7,800.0	7,800.0	7,935.0	967.4	2023	2024	6,967.6
8	“Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	5,000.0	5,000.0	9,960.8	–	2022	2024	4,960.8
9	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	1,930.0	1,930.0	6,803.9	–	2022	2024	4,873.9
10	Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2,200.0	2,159.9	6,179.0	–	2023	2024	4,019.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Мөн гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн хувьд Барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёлын сайдын багцад хамаарах 57.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн 67.8 хувийг бүрдүүлж байна. Дундаж өртгийн хувьд амжилттай хэрэгжсэн нэг төслийн төсөвт өртөг 1.7 тэрбум төгрөг байгаа бол хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслийнх 3.5 тэрбум төгрөг, гүйцэтгэл хангалтгүй төслийнх 4.7 тэрбум төгрөг, хэрэгжиж буй төслийнх 11.4 тэрбум төгрөг байна. Үүнээс мөн л төслийн төсөвт өртөг нэмэгдэхийн хэрээр хэрэгжилтэд хүндрэл үүсэх боломжтой байгааг илэрхийлж байна.

2022 оны төслүүд: 2022 он 664 төсөл шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн бөгөөд эдгээрийн нийт төсөвт өртөг 3.1 их наяд төгрөг байна. Хэрэгжилтийн хувьд 1.3 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 458 төсөл амжилттай хэрэгжсэн, 445.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 76 төсөл хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн, 775.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 111 төсөл гүйцэтгэл хангалтгүй болж үлдсэн 618.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл хэрэгжиж буй ангилалд хамаарч байна.

Хүснэгт 30. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр

Хэрэгжилтийн байдал		I. Барилга байгууламж	II. Их засвар	III. Тоног төхөөрөмж	IV. ТЭЗҮ	Нийт
Амжилттай хэрэгжсэн	Төслийн тоо	282	40	121	15	458
	Сүүлийн төсөвт өртөг	1,029.7	67.9	182.3	6.0	1,285.9
Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн	Төслийн тоо	64	6	4	2	76
	Сүүлийн төсөвт өртөг	397.2	18.5	24.4	5.6	445.6
Гүйцэтгэл хангалтгүй	Төслийн тоо	83	8	15	5	111
	Сүүлийн төсөвт өртөг	723.9	14.9	32.5	4.4	775.7
Хэрэгжиж буй	Төслийн тоо	18	1	0	0	19
	Сүүлийн төсөвт өртөг	604.1	14.5	–	–	618.6
Нийт	Төслийн тоо	447	55	140	22	664
	Сүүлийн төсөвт өртөг	2,754.9	115.7	239.2	16.0	3,125.8

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2022 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслүүдийн нийт төсөвт өртгийн 58.2 хувийг Барилга, хот байгуулалтын сайдын багцын 18 төслийн 131.1 тэрбум төгрөг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын 28 төслийн 128.4 тэрбум төгрөгийн төслүүд эзэлж байна. Мөн гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн хувьд Барилга, хот байгуулалтын сайдын багцын 218.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 төсөл, Эрчим хүчний сайдын багцын 107.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад хамаарах 230.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн 72.3 хувийг бүрдүүлж байна.

2022 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг өөрчлөгдсөн, хэрэгжих хугацаа хойшилсон төслүүдийг Хавсралт 4–г дэлгэрэнгүй харуулав. Төсөвт өртөг өөрчлөгдсөн нийт 292 төсөл байгаагаас хоёроос дээш удаа өөрчлөгдсөн 11 төсөл байна. Эдгээрээс жишээ дурдвал, Кино театрын барилга

/Ховд, Жаргалант сум/ 2022 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 2.5 тэрбум төгрөг байсан бол 2024 оны байдлаар 5.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж байна. Мөн Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/ 2022 онд хэрэгжиж эхэлсэн төслийн анхны төсөвт өртөг 20.0 тэрбум төгрөг байсан бол 2024 оны байдлаар 14.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хугацааны хоцрогдолтой хэрэгжиж байна.

Хүснэгт 31. 2022 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдийн төсөвт өртөг хамгийн ихээр өөрчлөгдсөн 10 төсөл, тэрбум төгрөгөөр

№	Төслийн нэр	Нийт төсөвт өртөг			Анхны төлөвлөсөн дуусах огноо	Бодит дууссан огноо	Төсөвт өртгийн өөрчлөлт
		2022	2023	2024			
1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	15,000.0	45,957.0	–	2023	2023	30,957.0
2	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/	29,950.0	51,279.6	–	2024	2024	21,329.6
3	Хууль зүй, дотоод хэргийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	17,906.0	5,807.5	–	2022	2023	12,098.5
4	Үндэсний номын сангийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	11,000.0	–	800.0	2023	2024	10,200.0
5	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/	8,000.0	18,000.0	–	2023	2024	10,000.0
6	Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжлийн сургалтын төвийн барилга /Улаанбаатар/	4,400.0	4,400.0	12,461.2	2023	2025	8,061.2
7	Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/	9,319.4	14,833.8	–	2023	2024	5,514.4
8	Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Жаргалант сум, 5 дугаар баг/	10,123.0	15,105.5	–	2024	2024	4,982.5
9	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11 дүгээр хороо, 28 дугаар сургууль/	11,000.0	–	15,701.8	2023	2025	4,701.8
10	Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/	10,000.0	9,958.6	14,494.2	2023	2025	4,535.6

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дундаж өртгийн хувьд амжилттай хэрэгжсэн нэг төслийн төсөвт өртөг 2.8 тэрбум төгрөг байгаа бол хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн төслийнх 5.9 тэрбум төгрөг, гүйцэтгэл хангалтгүй төслийнх 7.0 тэрбум төгрөг, хэрэгжиж буй төслийнх 32.6 тэрбум төгрөг байна.

2023 оны төслүүд: 2023 оны хувьд шилжих төслүүдийг хэрэгжүүлж дуусгахтай холбоотойгоор 10 шинэ төсөл хэрэгжүүлэхээр төсөвлөсөн бөгөөд эдгээрийн нийт төсөвт өртөг 670.8 тэрбум төгрөг байв. Хэрэгжилтийн хувьд 625.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл амжилттай хэрэгжсэн бол 45.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий “Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал” /Улаанбаатар, Хан–Уул дүүрэг/ барилга, байгууламжийн төсөл 2025 онд хэрэгжиж дуусахаар хэрэгжиж байна.

Хүснэгт 32. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр

Хэрэгжилтийн байдал		I. Барилга байгууламж	II. Их засвар	III. Тоног төхөөрөмж	IV. ТЭЗҮ	Нийт
Амжилттай хэрэгжсэн	Төслийн тоо	2	2	4	1	9
	Сүүлийн төсөвт өртөг	183.9	35.9	366.1	40.0	625.8
Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн	Төслийн тоо	0	0	0	0	0
	Сүүлийн төсөвт өртөг	–	–	–	–	–
Гүйцэтгэл хангалтгүй	Төслийн тоо	0	0	0	0	0
	Сүүлийн төсөвт өртөг	–	–	–	–	–
Хэрэгжиж буй	Төслийн тоо	1	0	0	0	1
	Сүүлийн төсөвт өртөг	45.0	–	–	–	45.0
Нийт	Төслийн тоо	3	2	4	1	10
	Сүүлийн төсөвт өртөг	228.9	35.9	366.1	40.0	670.8

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дундаж өртгийн хувьд амжилттай хэрэгжсэн нэг төслийн төсөвт өртөг 69.5 тэрбум төгрөг, хэрэгжиж буй төслийнх 45.0 тэрбум төгрөг байна. 2023 оны хувьд шинэ төслүүд маш цөөн хэрэгжүүлсэн бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн өндөр төсөвт өртөгтэй төслүүдийг хэрэгжүүлсэн тул амжилттай хэрэгжиж дууссан байна.

2023 онд хэрэгжиж эхэлсэн төслүүдээс төсөвт өртөг өөрчлөгдсөн, хэрэгжих хугацаа хойшилсон төслүүдийг Хавсралт 4–т дэлгэрэнгүй харуулав. Хугацааны хоцрогдолтой хэрэгжиж буй 1 төсөл байгаа бөгөөд “Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал” /Улаанбаатар, Хан–Уул дүүрэг/ 2023 онд хэрэгжиж эхэлсэн уг төсөл нь 2025 онд хэрэгжиж дуусахаар байна.

2024 оны төслүүд: 2024 он 711 төсөл шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн бөгөөд эдгээрийн нийт төсөвт өртөг 5.97 их наяд төгрөг байна. Хэрэгжилтийн хувьд 836.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 276 төсөл амжилттай хэрэгжсэн, 18.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл гүйцэтгэл хангалтгүй, 5.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 416 төсөл хэрэгжиж буй ангилалд хамаарч байна.

Хүснэгт 33. Төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төслүүдийн тоо, хэрэгжилтийн байдлаар, тэрбум төгрөгөөр

Хэрэгжилтийн байдал		I. Барилга байгууламж	II. Их засвар	III. Тоног төхөөрөмж	IV. ТЭЗҮ	Нийт
Амжилттай хэрэгжсэн	Төслийн тоо	57	17	190	12	276
	Сүүлийн төсөвт өртөг	114.1	40.2	366.2	315.8	836.2
Хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн	Төслийн тоо	0	0	0	0	0
	Сүүлийн төсөвт өртөг	–	–	–	–	–
Гүйцэтгэл хангалтгүй	Төслийн тоо	7	1	11	0	19
	Сүүлийн төсөвт өртөг	6.9	1.0	10.8	–	18.7
Хэрэгжиж буй	Төслийн тоо	400	3	11	2	416
	Сүүлийн төсөвт өртөг	4,992.4	9.5	110.0	28	5,114.7
Нийт	Төслийн тоо	464	21	212	14	711
	Сүүлийн төсөвт өртөг	5,113.4	50.7	486.9	318.5	5,969.5

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

2024 онд төсөвлөсөн нийт төсвийн 85.7 хувийг хэрэгжиж буй төслүүд бүрдүүлж буй бөгөөд үүнээс барилга байгууламжийн төслүүд нийт төсөвт өртгийн 83.6 хувийг дангаараа бүрдүүлж байна. Хэрэгжиж буй төслүүдийн хувьд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад хамаарах 716.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл, Сангийн сайдын багцад хамаарах 564.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, Боловсролын сайдын багцад хамаарах 899.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 130 төсөл, Зам, тээврийн сайдын багцад хамаарах 1.5 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 73 төсөл дийлэнх хувийг бүрдүүлж байгаа бөгөөд хэрэгжиж буй төслүүдийн 74 хувийг барилга байгууламжийн ажил бүрдүүлсэн байна.

Дундаж өртгийн хувьд амжилттай хэрэгжсэн нэг төслийн төсөвт өртөг 3.0 тэрбум төгрөг байгаа бол гүйцэтгэл хангалтгүй төслийнх 983 сая төгрөг, хэрэгжиж буй төслийнх 12.3 тэрбум төгрөг байна. 2024 оны хувьд барилга байгууламжийн шилжих төсөл нийт төсөвлөсөн төслийн 60 хувийг бүрдүүлж буй тул хэрэгжилтийн хувьд хугацаа хоцорсон төслүүдийг одоогоор төлөөлөн авах боломжгүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн үнэлгээг хийж гүйцэтгэхдээ жилийн төсвийн тухай хууль, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, tender.gov.mn, opendatalab.mn, opendata.gov.mn зэрэг олон нийтэд нээлттэй мэдээллүүдийг ашиглан үнэлэв. Үнэлгээнд шаардлагатай мэдээллийн хомс байдлаас үүдэлтэйгээр төслийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс нөлөөлөх байдлыг 100 хувь илэрхийлээгүй байх магадлалтай.

2023 онд шинээр хэрэгжүүлэх төслүүдийн хувьд алслагдсан утга гэж үзэн бусад онуудыг харьцуулан үзвэл төслүүдийн дундаж өртөг жилд дунджаар 76.7 хувиар өсөн 2024 оны байдлаар 8.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүний дотор амжилттай хэрэгжсэн төслүүдийн хувьд жилд дунджаар 65.4 хувиар өсөн, 3.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2020–2024 онд шинээр хэрэгжсэн төслүүдийн дундаж өртөг 4.8 тэрбум төгрөг байгаа ба амжилттай хэрэгжсэн төслүүдийн хувьд 2.4 тэрбум төгрөг, хугацааны хоцрогдолтой хэрэгжсэн

төслүүдийн хувьд 4.1 тэрбум төгрөг, гүйцэтгэл хангалтгүй төслүүдийн хувьд 6.4 тэрбум төгрөг, хэрэгжиж буй төслүүдийн хувьд 13.2 тэрбум төгрөгийн дундаж төсөвт өртөгтэй байна. Үүнээс харахад хугацаа хэтэрч, гүйцэтгэл буурахын хэрээр төсөвт өртөг нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Мөн барилга байгууламжийн төслүүдийн хувьд хамгийн өндөр хувьтай хугацаа хэтрэлт үүсэж буй бөгөөд дунджаар 1–2 жилийн хугацаагаар хоцорч хэрэгжиж байна. Хугацаа хоцролттой холбоотойгоор төсөл шилжихэд төсөвт өртөг нэмэгдэх хандлага давхар ажиглагдаж буй бөгөөд нийт төслийн 22.6 хувьд төсөвт өртөгт өөрчлөлт орсон байна. 2020–2024 оны хооронд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн 2499 төслийн хэрэгжилтэд үндэслэн хийсэн шинжилгээнээс дараах дүгнэлтүүд гарч байна.

- 1. Хөрөнгө оруулалтын төслүүдийн гүйцэтгэл харьцангуй сул, ихэнх төсөл төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дуусаагүй байна.** Нийт 11.9 их наяд төгрөгийн өртөг бүхий төслүүдээс ердөө 30.6 хувь нь нийт төсөвт өртгийн хамгийн багадаа 20 хувийн санхүүжилтийг олгосон эсэх, төсөл анхны төлөвлөсөн хугацаандаа хэрэгжсэн эсэх, төсөл нь 2024 онд багтаж хэрэгжиж дуусахаар төлөвлөгдсөн эсэх гэсэн 3 шалгуурыг хангасан байна. Харин төслүүдийн 48.9 хувь нь одоогоор хэрэгжиж буй ангилалд багтаж, төсвийн дийлэнх хувийг бүрдүүлж байна.
- 2. Хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөв өндөр байх тусам хэрэгжилтэд хүндрэлүүд бий болж байна.** Дунджаар 2.4 тэрбум төгрөгийн төсөвтэй төслүүд амжилттай хэрэгжсэн бол гүйцэтгэл хангалтгүй ангилалд багтсан төслүүдийн дундаж төсөвт өртөг 6.4 тэрбум, хэрэгжиж буй төслүүдийнх 13.2 тэрбум төгрөг байна. Төсөвт өртгийн хэмжээ нэмэгдэх тусам хугацаа хэтрэх, санхүүжилтийн дутагдалд орох эрсдэл бодитоор нэмэгдэж буйг шинжилгээ харуулж байна.
- 3. Барилга байгууламжийн төслүүд хэрэгжилтийн хувьд хамгийн их хугацаа хоцролттой байна.** Хугацааны хоцрогдолтой төслүүдийн дийлэнхийг барилга байгууламж барьж байгуулах төслүүд эзэлж, ихэвчлэн 1–2 жилээр хоцорсон байна. Төсөл шилжих явцад төсөвт өртөг нэмэгдэх хандлага түгээмэл ажиглагдаж, нийт төслийн 22.6 хувьд төсөвт өртгийн өөрчлөлт оржээ.
- 4. Төсвийн хэт төвлөрөл ТЕЗ–ийн түвшинд ажиглагдаж байна.** Боловсрол, Соёл, Барилга, Зам тээвэр зэрэг салбарын сайд нарын багцуудад төсөл төвлөрөлтэй байж, мөн тухайн ТЕЗ–дад хэрэгжилтийн хоцрогдол, үр ашиггүй төслүүдийн хэмжээ өндөр байна.

Монгол Улсад төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр биш, үр ашиг, хэрэгжилт, гүйцэтгэл чанарын шаардлага хангаж байгаа эсэх зэргээр хэмжих шаардлага улам бүр нэмэгдэж байна. Өндөр төсөвт өртөгтэй, стратегийн төслүүдийн хэрэгжилт удааширч, олон жил дамнан сунжрах нь төсвийн сахилга батыг алдагдуулж, үр ашгийг бууруулж буйг дээрх шинжилгээ тод харуулж байна. Иймд хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжилтэд суурилсан үнэлгээ, хяналт, дахин хуваарилалт хийх механизмыг сайжруулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын төсвийн орлого жил бүр тогтмол өсөж, 2020 онд 10.4 их наяд төгрөг байсан бол 2024 онд 31.5 их наяд төгрөгт хүрсэн нь эдийн засгийн идэвхжил, экспортын өсөлт, гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөө юм. Гэсэн хэдий ч төсвийн зарлага мөн адил хурдтай өсөж буй нь алдагдлыг бүрэн зогсоох боломжийг хязгаарлаж байна.

Төсвийн зардлыг 2024 оны гүйцэтгэлээр харахад 73 хувийг урсгал зардал, 26 хувийг хөрөнгө оруулалт, 1 хувийг цэвэр зээлийн дүн бүрдүүлж байна. Үүнээс 2020–2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар давхардсан тоогоор нийт 6301 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 11.85 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 10.48 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл дунджаар 89.3 хувьтай байна.

Үндэсний аудитын газрын хийсэн жил бүрийн “Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн тайлан”-гийн дүгнэлтээс харахад төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд (1) зардал–үр ашгийн шинжилгээ хийгээгүй, баталгаажаагүй төсөл, арга хэмжээнүүдийг төсөвт тусгах, (2) газрын маргаантай барилга байгууламж батлах зэрэг зөрчил байнга давтагдаж байгаа нь системийн түвшний асуудал болохыг харуулж байна. Иймд цаашид тогтолцооны чанартай шинэчлэл хийхгүй бол төсвийн хөрөнгө оруулалт нь хүчин чармайлт ихтэй боловч үр дүн багатай, зардлын өсөлт хэвээр үргэлжлэх эрсдэлтэй байна.

